

# ХҮЧИНДҮҮЛЭХЭЭС АНГИД БАЙХ ЭРХ

ЕВРОПЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ХЭРЭГЖИЛТ  
ХҮНИЙ ЭРХИЙН ОЛОН УЛСЫН ХЭМ ХЭМЖЭЭ

2018 оны 11 дүгээр сарын 24-нд хэвлэв

**ХҮЧИНДҮҮЛЭХЭЭС АНГИД БАЙХ ЭРХ**  
ЕВРОПЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ХЭРЭГЖИЛТ  
ХҮНИЙ ЭРХИЙН ОЛОН УЛСЫН ХЭМ ХЭМЖЭЭ  
Эмнести Интернэшнл  
Индексийн дугаар: EUR 01/9452/2018

**ЭМНЕСТИ**  
**ИНТЕРНЭШНЛ**



# ГАРЧИГ

1. Удиртгал	2
2. Арга зүй	4
3. Бүсийн хууль тогтоомж, батлагдах гэж буй баримт бичиг	5
3.1 Хүчингийн талаарх Европын хууль тогтоомжид “зөвшөөрөл” хэрхэн туссан бэ	8
3.1.1 Хуульд зөвшөөрлийг хэрхэн тодорхойлдог вэ	10
3.2 Европт хүч хэрэглэсэн эсэхээр хүчинг тодорхойлох хандлага түгээмэл байна	12
3.2.1 “Энэ бол хүчин биш”	12
3.3 Гэрлэлтийн тухай заалт	13
3.4 “Нэр хүнд”, “Ёс суртахууны” эсрэг гэмт хэрэг	13
4. Шүүхэд хандахад тулгарч буй бэрхшээл. Бодит байдал	15
4.1 Мөрдөн шалгах ажлын чанар	15
4.2 Шүүн таслах ажиллагааны явцад зарцуулах цаг хугацаа	15
4.3 Шүүн таслах ажиллагааны явц дах хохирогчийн хамгаалалт	16
4.4 Цагдаа, прокурор, шүүгч, анхны тусламж үзүүлэгчдийн сургалт	17
4.5 Хохирогчид үзүүлэх дэмжлэг	18
4.6 Бэлгийн харилцаа, бэлгийн амьдралын боловсрол	19
4.7 Жендэрийн хэвшмэл ойлголтын сөрөг үр дагавар	19
4.8 Ойлголт нэмэгдүүлэх аян	20
5. Статистик мэдээлэл. Бэлгийн хүчирхийллийн тархалт ба шүүхээр шийдүүлсэн хувь	24
5.1 Бэлгийн хүчирхийллийн тархалт	25
5.2 Бүртгэгдсэн болон шүүхээр шийдвэрлүүлсэн хэргийн хувь	26
5.2.1 Цагдаад мэдээлж бүртгүүлэх	26
5.2.2 Шүүхээр шийдвэрлүүлсэн хэргийн хувь	27
6. Олон улсын хүний эрхийн хэм хэмжээ	28
6.1 Бэлгийн хүчирхийлэлтэй холбоотой хууль эрх зүй	29
6.2 Жендэрт суурилсан бэлгийн хүчирхийллээс сэргийлэх, тэмцэхэд хохирогч төвтэй, жендэрийн мэдрэмжтэй бодлого хэрэгтэй	31
6.2.1 Яллах үйл явц	31
6.2.2 Хохирогчийн хамгаалалт	31
6.2.3 Хүчирхийллийн хохирогчдод үзүүлэх дэмжих үйлчилгээ	33
6.2.4 Гомдол барагдуулах	33
6.2.5 Урьдчилан сэргийлэх ажил	34
7. Зөвлөмж	35

# 1. УДИРТГАЛ

Дэлхий даяар бэлгийн хүчирхийлэл өргөн тархсан, тогтолцооны шинжтэй байна. Одоогоор хүн ам нь хүчирхийллийн айдсаас бүрэн чөлөөлөгдсөн улс орон, түүний хор хөнөөлөөс ангижирсан жендэрийн болон хүн амын бүлэг гэж байхгүй байна. Ямар ч хүн хүйс, жендэр болон жендэрийн илэрхийллээсээ үл хамааран бэлгийн хүчирхийллийн бүх хэлбэрээс ангид байх нь хүний эрхийн чухал асуудал гэдгийг хүлээн зөвшөөрч байгаа хэдий ч, энэхүү судалгаа нь хүчирхийллийн зөвхөн нэг хэлбэр болох охид, эмэгтэйчүүдийн эсрэг хүчинг авч үзсэн болно. Учир нь өнөөг хүртэл маш олон охид эмэгтэйчүүд энэ гэмт хэргийн золиос болсоор байна.

Европын Холбоог (ЕХ) тэр чигээр нь хамарсан хамгийн сүүлийн үеийн судалгаа болох 2014 онд Суурь эрхийн төлөөх байгууллагын хийсэн эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн судалгааны дүнгээс үзэхэд ЕХ-нд арван эмэгтэй тутмын нэг (11%) нь 15 нас хүрээд бэлгийн хүчирхийллийн аль нэг хэлбэрт өртсөн байна<sup>1</sup>. ЕХ-нд хорин эмэгтэй тутмын нэг (5%) нь 15 нас хүрээд хүчиндүүлсэн байна<sup>2</sup>. Суурь эрхийн төлөөх байгууллагын тооцоолсноор, энэ нь ЕХ-нд нийтдээ 9 сая гаруй эмэгтэй 15 нас хүрээд хүчингийн хэргийн золиос болсон гэсэн дүгнэлтэд хүрчээ<sup>3</sup>.

Хүчин болон бэлгийн хүчирхийллийн бусад хэлбэр нь хохирогчийн бие махбод, сэтгэл санааны бүрэн бүтэн байдал, бэлгийн бие даасан байдалд бүдүүлгээр халдсан явдал юм. Хүчин нь хүний эрхийн зөрчил болоод зогсохгүй бусад олон суурь эрхүүдийг зөрчих үндэс болдог. Тухайлбал, хохирогчийн амьд явах эрх, бие болон сэтгэл зүйн хувьд эрүүл байх эрх, хувь хүний аюулгүй байдал, эрх чөлөө, жендэр болон жендэрийн илэрхийллээс үл хамааран гэр бүл болон хуулийн өмнө тэгш байх эрх, ялгаварлан гадуурхалт, эрүү шүүлт болон бусад хууль бус хандлагаас ангид байх эрх гэх мэт олон эрхийг зөрчдөг билээ. Ихэнх тохиолдолд хохирогчид эрхээ мэдэхгүйгээс болж жендэрийн хэвшмэл ойлголт, бэлгийн хүчирхийлэл гэж юуг хэлэх талаар буруу ойлголттой байхаас гадна, хохирогчийг буруутгах, нэр хүндийг нь гутаах, тусламж дэмжлэг хангалтгүй, хууль эрх зүйн тогтолцоо үр дүнгүй байгаагаас олон саад бэрхшээлтэй тулгарч байна.

Биеэ үнэлэгчид, хөдөө орон нутагт амьдардаг, орон гэргүй, иргэншил, цагаачлалын асуудалтай, бүртгэлгүй шилжин суурьшигч, мансууруулах бодис хэрэглэдэг, сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай охид, эмэгтэйчүүд хүчин болоод бэлгийн хүчирхийллийн бусад хэлбэрийн хохирогч болсон тохиолдолд шүүхээр шийдүүлэх явцад эрх нь хамгийн их зөрчигдөх магадлалтай байдаг.

Хүний эрхийн олон улсын болон бүсийн хууль эрх зүйн баримт бичгийн дагуу улс орнууд охид эмэгтэйчүүдийг жендэрт суурилсан хүчирхийллээс хамгаалах, ийм хэргийн тохиолдол болгоныг мөрдөн шалгаж, зохих шийтгэлийг нь ногдуулах, хохирогчийг өмгөөлөх үйлчилгээг зохион байгуулах үүрэгтэй. Энэ нь тухайн хохирогчийн асуудлыг шийдвэрлээд зогсохгүй, бэлгийн хүчирхийллийн суурь шалтгаан болсон үндэсний хууль тогтоомж, бодлого, хандлагыг өөрчлөх ажлыг хийх шаардлагатай гэсэн үг юм<sup>4</sup>.

2011 онд Европын Зөвлөлийн “Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, тэмцэх тухай конвенци” (**Истанбулын конвенци**) -ийг баталсан бөгөөд 2014 оноос хүчин төгөлдөр хэрэгжиж байна<sup>5</sup>. Энэ баримт бичиг нь 1994 онд батлагдсан Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг устгах, тийм гэмт хэрэгт ял оноох, урьдчилан сэргийлэх тухай Америк тивийн конвенци (**Белем ду Парагийн конвенци**)<sup>6</sup>, 2003 онд Африкийн Холбооноос баталсан Африкийн Хүний эрхийн дүрмийн Африкийн эмэгтэйчүүдийн эрхийн тухай нэмэлт протокол

<sup>1</sup> Европын Холбооны Суурь эрхийн төлөөх байгууллага. “Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаарх Европын Холбоог хамарсан судалгааны тайлан” 2014 он.

<sup>2</sup> Дээрх судалгаа, хуудас 21

<sup>3</sup> Дээрх судалгаа, хуудас 41

<sup>4</sup> НҮБ-ын эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн асуудлаарх Тусгай илтгэгчийн 2010 оны тайлан, НҮБ-ын баримт А/НРС/14/22, 2010 оны 4 дүгээр сарын 23.

<sup>5</sup> Европын Зөвлөл “Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, тэмцэх конвенци” (Истанбулын конвенци)-ийг 2011 онд баталсан бөгөөд 2014 оны 8 дугаар сарын 1-ээс хүчин төгөлдөр хэрэгжиж байна.

<sup>6</sup> Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг устгах, тийм гэмт хэрэгт ял оноох, урьдчилан сэргийлэх тухай Америк тивийн конвенци (Белем ду Парагийн конвенци) (1994 оны 6 дугаар сарын 9-нд батлагдсан, 1995 оны 3 дугаар сарын 5-аас хэрэгжиж байна) [1994] ILM 1534.

(Мапутогийн протокол)<sup>7</sup>-ын дараа батлагдсан бүсийн хэмжээний гурав дахь баримт бичиг бөгөөд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг шийдвэрлэхэд хамгийн өргөн хүрээний асуудлыг тусгасан олон улсын баримт бичиг юм. Европын Зөвлөлийн гишүүн орнуудад жендэрт суурилсан хүчирхийллийг шийдвэрлэхэд тулгарч буй сорил бэрхшээл, сайн туршлагуудыг гүнзгийрүүлэн судалсны үндсэн дээр боловсруулж гаргасан өргөн хүрээний шийдлийг санал болгосон байна<sup>8</sup>.

Истанбулын конвенци нь олон талаараа шинэлэг, өөрчлөлтөд чиглэсэн баримт бичиг юм. Энэ нь тогтолцоог өөрчлөх, жендэр болон нийгмийн тэгш байдлыг хангахад чухал арга хэрэгсэл болох боломжтой. Охид, эмэгтэйчүүд нийгмийн болон хувийн амьдралдаа хүчирхийллээс ангид байх эрхийг баталгаажуулах үүргийг засгийн газруудад ногдуулахаас гадна салбар хоорондын хамтын ажиллагааг хангах шаардлагыг тавьжээ. Жишээ нь, бэлгийн чиг хандлага, жендэрийн илэрхийлэлд суурилсан ялгаварлан гадуурхалтыг хориглосон анхны баримт бичиг бөгөөд дүрвэгч болон шилжин суурьшигч эмэгтэйчүүдийн асуудлыг ч тусгаснаараа онцлог юм.

Хэдийгээр улс орнууд бэлгийн хүчирхийлэлтэй тэмцэх үүргийг хүний эрхийн олон улсын болон бүсийн хэмжээний баримт бичгийн дагуу хүлээсэн боловч, бүртгэгдсэн хүчингийн тоо нэмэгдсэн байхад, эдгээр хэргийг мөрдөн шалгасан, гэм бурууг нь тогтоосон хувь хэмжээ буурсан үзүүлэлт Европын орнуудад түгээмэл байна<sup>9</sup>. Маш олон тохиолдолд охид эмэгтэйчүүд ийм хэргийг мэдээлдэггүйгээс эрүүгийн хуулийн дагуу мөрдөн шалгах байгууллагын анхааралд огт өртөхгүй байх нь ч элбэг байна. Гомдол гаргасан хэдий ч, тэдгээрийн маш бага хувь нь шүүхээр шийдүүлдэг бөгөөд энэ нь мөрдөн шалгах явцад гомдлоо буцааж татах явдал түгээмэл байгаатай холбоотой. Үүний улмаас буруутай гэж сэжиглэгдэж буй этгээд хэзээ ч яллагдахгүй, гэм буруу нь тогтоогдохгүй, өөрийн хийсэн гэмт хэргийн төлөө шийтгэл амсахгүйд хүрч байна. Энэ асуудлыг “завхрал” гэж нэрлэдэг<sup>10</sup>. Энэ байдлаар хуулийг завхруулах нь Европын улс орнуудад түгээмэл байгаа нь улс орнууд нэг талаас охид эмэгтэйчүүдийг бэлгийн хүчирхийллээс хамгаалах, нөгөө талаас шударгаар шүүх, хохирлыг барагдуулах тухай олон улсын болон бүсийн хүний эрхийн баримт бичгүүдэд заасан үүргээ биелүүлэхгүй байгааг харуулж байна.

Энэхүү бүсийн судалгаа нь Европын эдийн засгийн бүс (үүнд Исланд, Норвеги, Европын Холбооны 28 гишүүн улс орно) болон Швейцарь<sup>11</sup> хэрэгжиж буй хүчингийн гэмт хэргийн хууль эрх зүйн байдал, хуулийн завхралын үзүүлэлт, хүчингийн гэмт хэргийг шүүн шийдвэрлэх явцад гарч буй хүндрэл бэрхшээл, боломжит үндэсний хэмжээнд хүлээгдэж буй өөрчлөлт зэргийг хамарсан. Түүнчлэн, бэлгийн болон жендэрт суурилсан хүчирхийллийн бусад хэлбэрүүдийн эсрэг олон улсын болон бүсийн хэмжээний хүний эрхийн баримт бичгийг танилцуулсан болно<sup>12</sup>.

Хэдийгээр үндэсний хууль тогтоомж хүний эрхийн олон улсын стандартыг хангаж байх нь чухал боловч, хамгийн сайн хууль эрх зүйн тогтолцоо дангаараа хүчингийн гэмт хэргийг устгаж, шийдвэрлэж чадахгүй юм. Энэ тогтолцоог бүрэн ажиллуулахын тулд бодлогоор дэмжиж, бодит ажил болгох хэрэгтэй. Энэхүү гэмт хэргээс сэргийлэх, хохирогчдод туслалцаа дэмжлэг үзүүлэх ёстой хүмүүсийн дунд ялгаварлан гадуурхалт, хохирогчийг буруутгах, хүчингийн хэргийн талаар буруу ташаа ойлголт түгээмэл байгаа бөгөөд энэ асуудлыг нэн тэргүүнд шийдвэрлэх шаардлагатай байна.<sup>13</sup>

<sup>7</sup> Африкийн Хүний эрхийн дүрмийн Африкийн эмэгтэйчүүдийн эрхийн тухай нэмэлт протокол (Мапутогийн протокол) (2003 оны 7 дугаар сарын 11-нд батлагдсан, 2005 оны 11 дүгээр сарын 25-аас хэрэгжиж байна) CA/LEG/66.6.

<sup>8</sup> “Айдасаас ангид – Хүчирхийллээс ангид” Европын Зөвлөлийн Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, тэмцэх тухай конвенци” (Истанбулын конвенци) 2014 он, холбоос: [www.edoc.coe.int/en/violence-against-women/6138-leaflet-safe-from-fear-istanbul-convention.html](http://www.edoc.coe.int/en/violence-against-women/6138-leaflet-safe-from-fear-istanbul-convention.html).

<sup>9</sup> Тухайлбал, Келли Л., Ловетт Ж. нарын “Өөр тогтолцоо, ижил үр дүн?” 2009 оны Европ даяар мэдээлсэн хүчирхийллийн хэргийн бууралтын талаарх судалгааг харна уу. Холбоос: [www.cwasu.org/resource/different-systems-similar-outcomes-tracking-attribution-in-reported-rape-cases-in-11-european-countries/](http://www.cwasu.org/resource/different-systems-similar-outcomes-tracking-attribution-in-reported-rape-cases-in-11-european-countries/), хуудас 25.

<sup>10</sup> Тухайлбал, дээрх судалгаанаас шүүх тогтолцоонд хүчирхийллийн хэргийг шалгах явцад уналтад орсон талаар хуудас 5-аас үзнэ үү,.

<sup>11</sup> Тойм судалгаанд Андорра, Лихтенштейн, Монако, Сан Марино, Ватикан хамрагдаагүй болно.

<sup>12</sup> Эмнести Интернэшнл, “Зөвшөөрөлгүй бэлгийн хавьтал бол хүчин. Тэгээд яагаад үүнийг Европт есхөн орон хүлээн зөвшөөрсөн бэ?” 2018 оны 4 дүгээр сарын 23. Холбоос: [www.amnesty.org/en/latest/campaigns/2018/04/eu-sex-without-consent-is-rare/](http://www.amnesty.org/en/latest/campaigns/2018/04/eu-sex-without-consent-is-rare/).

<sup>13</sup> Шотландын хүчингийн дараа үзүүлэх үйлчилгээний төвийн хийсэн үнэлгээнээс харахад Шотландын прокурорын газрын жишээн дээр хэдийгээр хууль эрх зүйн үйл явц, тогтоомж, хэрэгжилт сайн байгаа ч гэсэн эрх зүйн тогтолцоо ганцаараа үр дүнгүй байгааг харуулж байна: “Хүчирхийллийн эсрэг хуулийн зохицуулалтыг хийх хэрэгтэй байна” 2017 оны 11 дүгээр сарын 15: [www.rapecrisisscotland.org.uk/news/news/rape-crisis-scotland-calls-for-radical-reform-of-legal-responses-to-rape/](http://www.rapecrisisscotland.org.uk/news/news/rape-crisis-scotland-calls-for-radical-reform-of-legal-responses-to-rape/).

## 2. АРГА ЗҮЙ

Судалгааг хийхдээ голчлон баримт бичгийн судалгааны аргыг ашигласан бөгөөд хэвлэгдэн гарсан ном зүй, судалгааны тайлан, батлагдан гарсан хууль тогтоомж, бүсийн хэмжээний хамааралтай эрх зүйн баримт бичгүүд, мөн Эмнести Интернэшнлийн Европын салбар байгууллагуудтай ярилцлага хийх замаар цуглуулсан мэдээлэлд тулгуурлав. Түүнчлэн, 2017 оны 5 дугаар сараас 9 дүгээр сарын хооронд бүсийн 6 улсын (Англи, Финлянд, Ирланд, Нидерланд, Умард Ирланд, Швед) 17 байгууллага, хувь хүмүүстэй (ТББ, хүчингийн хохирогчдод үйлчилгээ үзүүлэх төв, хуульчид болон бусад зөвлөхүүд) биечлэн болон утсаар хийсэн ярилцлага, бүсийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг Брюссельд төвтэй хоёр байгууллагатай хийсэн ярилцлагын үр дүнг оруулсан болно<sup>14</sup>.

Охид эмэгтэйчүүдийн бэлгийн хүчирхийллийн эсрэг хууль тогтоомж Европын улс орнуудад ямар байгаа талаар, тэдгээрийн бодит хэрэгжилтийг судалсан судалгаа бараг байхгүй байгаа бөгөөд ЕХ-ны бүх орныг хамарсан судалгаа байхгүй байна. Бүсийн сонгосон улс орнуудын хуулийг завхруулсан тоо баримтыг дэлгэрэнгүй судалсан ганц тайлан байгаа бөгөөд энэ нь Лиз Келли, Жо Ловетт нарын 2009 оны судалгааны тайлан ба үр дүнгээс энэхүү судалгааны Тавдугаар бүлэгт дурьдсан болно. 2011 онд Европын Эмэгтэйчүүдийн Лобби бүлэг Европын Жендэрийн тэгш байдлын хүрээлэнгийн өмнөөс судалгаа хийсэн бөгөөд 2007-2010 оны хооронд ЕХ-ны гишүүн орнууд болон Хорватын (тухайн үед ЕХ-ны гишүүн биш байсан) эмэгтэйчүүдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн тоо баримт, мэдээллийн зураглалыг гаргасан байна<sup>15</sup>. Түүнчлэн энэ байгууллага “Хүчирхийллийн барометр” хэмээх судалгааг 2013 онд хийж, Европын 32 орны хууль тогтоомжийг Истанбулын конвенцийн зүйл заалттай хэр нийцэж байгаа талаар болон хохирогч эмэгтэйчүүдийн тоон мэдээллийн чанар, олдоцын талаар судалжээ<sup>16</sup>. 2013 оны дараагийн судалгаа бол Европын Парламентын Дотоод бодлогын ерөнхий газрын хийсэн “Хүчингийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хохирогч эмэгтэйчүүдэд туслах дэлхий даяарх сайн туршлагуудын тойм” бөгөөд дэлхийн хэмжээнд хэрэгжиж буй туршлагуудын ерөнхий зураглалыг өгсөн байна<sup>17</sup>. 2014 оны 3 дугаар сард Европын Холбооны Суурь эрхийн төлөөх байгууллага ЕХ-ны гишүүн улсуудад эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл ямар байгаа талаарх тоо баримт, чиг хандлагын талаар судалсан байна<sup>18</sup>. Нийт ЕХ-г хамарсан дараагийн судалгааг Евростат төслийн хүрээнд ирэх жилүүдэд хийхээр төлөвлөж байна<sup>19</sup>. 2017 оны Тэгш байдлын судалгаа нь “Дэлхий ичиж байна. Дэлхийн хүчингийн гэмт хэргийн тархалт” сэдэвтэй гарсан бөгөөд Европын 18 орны хууль тогтоомжийн талаар товч мэдээллийг өгсөн байна. Тэр мэдээллийг голдуу хууль хэрэгжүүлэгч нараас авсан судалгааны баримтаас бүрдүүлжээ<sup>20</sup>.

Эмнести Интернэшнлийн өөрийн хийсэн судалгаа нь тэдний “Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг зогсооцгоо” сэдэвтэй дэлхийн хэмжээний кампанит ажлын (2004-2010) үеэр хийгджээ. 2007 онд Унгарын Эмнести Интернэшнл байгууллага өөрийн орондоо дотно харилцааны үеийн бэлгийн хүчирхийллийн талаарх судалгааг гаргасан байна<sup>21</sup>. Дани, Финлянд, Норвеги, Шведийн салбар

<sup>14</sup> Эмнести Интернэшнл Нидерландад 2 хуульч, 1 ТББ-ын төлөөлөлтэй уулзсан, Шведэд ТББ-ын 2 төлөөлөл, Финляндад ТББ-ын 2 төлөөлөл, 1 хуульчтай, Ирландад ТББ-ын 6 төлөөлөл (хуульч болон хүчирхийллийн төвийн ажилтнууд), Умард Ирландад бэлгийн хүчирхийллийн хараат бус 1 зөвлөх, ТББ-ын 5 төлөөлөл, Англид хүчирхийллийн төвийн 1 ажилтан, Брюссельд бүсийн хэмжээний байгууллагын 2 төлөөлөгчтэй уулзсан.

<sup>15</sup> Европын Холбооны Суурь эрхийн төлөөх байгууллага. “Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл Европын Холбоог хамарсан судалгааны тайлан” 2013 он: <http://eige.europa.eu/rdc/eige-publications/study-identify-and-map-existing-data-and-resources-sexual-violence-against-women-eu-report>.

<sup>16</sup> Европын эмэгтэйчүүдийн лобби бүлэг, “Хүчингийн барометр” 2013 он: [www.womenlobby.org/2013-EWL-Barometer-on-Rape-Report](http://www.womenlobby.org/2013-EWL-Barometer-on-Rape-Report).

<sup>17</sup> Европын парламент, Дотоод бодлогын ерөнхий газар “Хүчингийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хохирогч эмэгтэйчүүдэд туслах дэлхийн даяарх сайн туршлагуудын тойм” 2013 он: [www.europarl.europa.eu/RegData/etudes/etudes/join/2013/493025/IPOL-FEMM\\_ET\(2013\)493025\\_EN.pdf](http://www.europarl.europa.eu/RegData/etudes/etudes/join/2013/493025/IPOL-FEMM_ET(2013)493025_EN.pdf).

<sup>18</sup> Европын Холбооны Суурь эрхийн төлөөх байгууллага. “Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл Европын Холбоог хамарсан судалгааны тайлан” 2014 он: <http://eige.europa.eu/rdc/eige-publications/study-identify-and-map-existing-data-and-resources-sexual-violence-against-women-eu-report>.

<sup>19</sup> Европын Холбооны Суурь эрхийн төлөөх байгууллага. “Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл Европын Холбоог хамарсан судалгааны тайлан” 2013 он: <http://eige.europa.eu/rdc/eige-publications/study-identify-and-map-existing-data-and-resources-sexual-violence-against-women-eu-report>.

<sup>20</sup> Өнөөгийн тэгш байдал, “Дэлхий ичиж байна. Дэлхийн хүчингийн гэмт хэргийн тархалт. Хуулийн хүрээнд эмэгтэйчүүд, охидыг бэлгийн хүчирхийллээс хамгаалж чадахгүй байна”, 2017 он: [www.equalitynow.org/campaigns/rape-laws-report](http://www.equalitynow.org/campaigns/rape-laws-report).

<sup>21</sup> Эмнести Интернэшнл, “Унгар. Чимээгүй хашгираан: Эмэгтэйчүүдийг хүчин болон гэр бүлийн хүчирхийллээс хамгаалж чадахгүй байна” 2007 он: [www.amnesty.org/en/documents/eur27/002/2007/en/](http://www.amnesty.org/en/documents/eur27/002/2007/en/).

байгууллагууд өөрийн орны бэлгийн хүчирхийллийн талаархи тайланг 2008 онд гаргасан байна. Энэ хамтарсан тайлан нь “Хэрэг хаагдлаа: Скандинавын орнуудын хүчин ба хүний эрхийн байдал” гэсэн нэртэй бөгөөд удаах тайлан нь 2010 онд гарчээ<sup>22</sup>. Зарим салбар байгууллагууд (Эмнести Интернэшнлийн Бельги, Скандинав, Их Британы салбар гэх мэт) өөрийн улс оронд хандлага ямар байгаа талаар судалгаа гаргасан байна<sup>23</sup>. Европын эдийн засгийн бүсээс гадна, 2017 онд Эмнести Интернэшнл Босни-Херцеговина<sup>24</sup> болон Косовогийн<sup>25</sup> дайны үеийн бэлгийн хүчирхийллийн хохирогчид шударга шүүхийн үйлчилгээ авч чадсан эсэх талаар судалгаа хийсэн байна.

## 3. БҮСИЙН ХУУЛЬ ТОГТООМЖ, БАТЛАГДАХ ГЭЖ БҮЙ БАРИМТ БИЧИГ

Европын олон оронд хүчинг гэмт хэрэгт тооцох хууль эрх зүйн байдал хангалтгүй, үр дүнгүй байгаа нь асуудал болж байна. Хүний эрхийн олон улсын баримт бичиг, хэм хэмжээгээр хүчинг өргөн хүрээнд тодорхойлсон байдаг бөгөөд үүнд харилцан зөвшөөрөөгүй байхад нэг хүн өөрийн эрхтэн, эсвэл эд зүйлийг бэлгийн сэдэлтэйгээр нөгөө хүний бие, үтрээ, шулуун гэдэс, эсвэл аманд хийхийг хүчин гэж тооцдог<sup>26</sup>. Хүчин болон харилцан зөвшөөрөөгүй бэлгийн сэдэлтэй бусад бүх үйлдлийг гэмт хэрэгт тооцох шаардлагыг Истанбулын конвенцид заасан байна<sup>27</sup>.

Хүний эрхийн хэм хэмжээнд нийцсэн хууль эрх зүйн баримт бичиг нь хүчинг таслан зогсоох, эсвэл түүнээс урьдчилан сэргийлэх төгс шийдэл болж чадахгүй, харин зөвхөн эхлэл цэг юм. Уг судалгааны тайлан өөрийн боломж, арга зүйн хүрээнд төрийн албаныхан болон хууль хүчний байгууллагынхан хүчинг хуулиар шийтгэх ажлыг хэрхэн хэрэгжүүлж байгаа талаар Дөрөвдүгээр бүлэгт дэлгэрэнгүй дурьдсан байгаа.

Эрх зүйн баримт бичиг, түүнийг хэрэгжүүлэх явцад гэмт этгээд хүч хэрэглэсэн, эсвэл хэрэглэнэ гэж заналхийлснээр хүсээгүй бэлгийн хавьталд эсэргүүцэл үзүүлээгүйг хохирог харилцан зөвшөөрсөн гэж ойлгож болохгүй. Олон улсын эрүүгийн шүүхээс хүчинг тодорхойлохдоо зөвшөөрөөгүй байхад нь “гэмт этгээд хохирогчийн биеийн аль ч хэсэгт бэлэг эрхтнийг бага ч болов хүргэх, эсвэл бэлэг эрхтнийг шургуулах, хохирогчийн шулуун гэдэс, үтрээний амсар, эсвэл биеийн аль нэгэн хэсэгт ямар нэгэн эд зүйлээр хүрэх” гэсэн байдаг<sup>28</sup>.

<sup>22</sup> Эмнести Интернэшнл, “Хэргийг хаалаа. Скандинавын орнуудын хүчин, хүний эрхийн байдал. Товч тайлан” 2010 он: [www.amnesty.org/en/documents/ACT77/001/2010/en/](http://www.amnesty.org/en/documents/ACT77/001/2010/en/).

<sup>23</sup> Бельгийн Эмнести Интернэшнл, SOS Viol, “Etude des opinions et des comportements de la population belge en matière de violences sexuelles” 2014: [www.amnesty.be/IMG/pdf/enquete\\_synthese\\_final.pdf](http://www.amnesty.be/IMG/pdf/enquete_synthese_final.pdf); Данийн Эмнести Интернэшнл: [www.amnesty.dk/nyhedsliste/2015/kan-en-kvindes-paaklaedning-goere-hende-ansvarlig-for-at-blive-voldtaget](http://www.amnesty.dk/nyhedsliste/2015/kan-en-kvindes-paaklaedning-goere-hende-ansvarlig-for-at-blive-voldtaget); Финляндийн Эмнести Интернэшнл, “Asenne Esiin! Mielipidekysely seksuaalisesta vdkivallasta” 2010: [www.amnesty.fi/asenne-esiin-mielipidekysely/](http://www.amnesty.fi/asenne-esiin-mielipidekysely/); Норвегийн Эмнести Интернэшнл, “Undersøkelse om voldtekt Laget for Amnesty International Norge” 2013: [www.amnesty.no/aktuelt/flere-nyheter/skolen-svikter-i-kampen-mot-voldtekt-0](http://www.amnesty.no/aktuelt/flere-nyheter/skolen-svikter-i-kampen-mot-voldtekt-0); Шведийн Эмнести Интернэшнл, “Var ger grdansen? En attityundersökning om veldtdkt” 2008: [www.amnesty.se/upload/files/2011/05/04/Valdtakt-Var%20gar%20gransen-En%20attityundersokning%20om%20valdtakt-](http://www.amnesty.se/upload/files/2011/05/04/Valdtakt-Var%20gar%20gransen-En%20attityundersokning%20om%20valdtakt-) Amnesty.pdf; Их Британи: Шинэ судалгааны дүнгээс харахад эрэгтэйчүүдтэй аальгүйтдэг эмэгтэй хүчиндүүлсний хариуцлагыг хүлээх хэрэгтэй гэж оролцогчдын гуравны нэг нь үзжээ, 2005. [www.amnesty.org.uk/press-releases/uk-new-poll-finds-third-people-believe-women-who-flirt-partially-responsible-being](http://www.amnesty.org.uk/press-releases/uk-new-poll-finds-third-people-believe-women-who-flirt-partially-responsible-being).

<sup>24</sup> Эмнести Интернэшнл, “Бидэнд харамсал биш дэмжлэг хэрэгтэй: Боснигийн дайны цагийн хүчирхийллийн хохирогчдын мэдүүлгээр шударга ёс тогтоох сүүлчийн боломж” 2017, холбоос: [www.amnesty.org/en/documents/eur63/6679/2017/en/](http://www.amnesty.org/en/documents/eur63/6679/2017/en/).

<sup>25</sup> Эмнести Интернэшнл, ““Сүнснийг маань түлэх шарх”: Дайны үеийн хүчирхийллийн хохирогчдод нөхөн олговор олгосон ч шударга ёсыг тогтоогоогүй хэвээр” 2017, холбоос: <https://www.amnesty.org/en/documents/eur70/7558/2017/en/>.

<sup>26</sup> Истанбулын конвенци, 36(1)(а) зүйл; Олон улсын эрүүгийн шүүх “гэмт хэргийн элементүүд” 2011. Хүчингийн хүн төрөлхөтний эсрэг гэмт хэрэгтэй холбогдуулан гэмт хэргийн элементийн 1 ба 2 дугаар элементийг Зүйл 7(1)(g)-1, хуудас 8, олон болон Зүйл Article 8(2)(e)(vi)-1, хуудас 36-37-аас үз.

<sup>27</sup> Истанбулын конвенци, 36(1)зүйл. Мөн 2002 оны 4 дүгээр сарын 30-ны Сайд нарын хорооны баталсан Европын Зөвлөлийн сайд нарын хорооны зөвлөмж № R (2002) 5 болон Тайлбар меморандум H/Inf (2004), догол мөр 35-аас бүх төрлийн зөвшөөрөөгүй үйлдэлд, хохирогч эсэргүүцэл үзүүлээгүй байсан ч шийтгэл ногдуулахыг шаардсан тухай үз. Бас Европын зөвлөлийн парламентчдын чуулганы шийдвэр 1691 (2009), догол 5.2.1-аас улс орнуудыг хүчингийн хэргийг (гэрлэлтийн хүчинг багтаан) албан ёсоор гэмт хэрэг гэж үзэхийг уриалсныг үз.

<sup>28</sup> 7(1)-(g)1(1) зүйл: Олон улсын эрүүгийн шүүх “гэмт хэргийн элементүүд” PCNICC/2000/1/Add.2 (2000). Олон улсын



Хүн өөрийн чөлөөт сонголтыг хийсний үр дүнд зөвшөөрөл өгөх ёстой бөгөөд тухайн үеийн нөхцөл байдал ямар байсныг үнэлэх хэрэгтэй<sup>29</sup>. Аль нэгэн бэлгийн үйлдлийг хийх зөвшөөрлийг сайн дурын үндсэн дээр өгч байгаа учраас ямар ч үед татгалзах эрхтэй байх ёстой<sup>30</sup>. Олон улсын эрүүгийн хуульд сүүлийн үед орсон өөрчлөлтүүдээс харахад зөвшөөрөл гэдэг нь хоёр талын аль нэг нь давуу нөхцөл байдал үүсгээгүй, харилцан чөлөөтэй хийсэн сонголтын үндсэн дээр, эсвэл зөвшөөрөл өгөх боломжтой тохиолдлыг зөвшөөрсөн гэж тооцдог болоод байна<sup>31</sup>. Тийм учраас, хүчингийн тодорхойлолтод сонголтоо чөлөөтэй хийх боломжгүй байх олон төрлийн нөхцөл байдлыг оруулах хэрэгтэй бөгөөд ийм нөхцөл үүсээгүй байсан ч хохирогч, эсвэл гомдол гаргаж байгаа тал үнэхээр зөвшөөрсөн гэдгийг харуулах ямар арга хэмжээг авсан талаар нь гэмт этгээдээс асуух, батлах алхмуудыг оруулах хэрэгтэй байна<sup>32</sup>. Истанбулын конвенцийн тайлбар бичигт мөрдөн шалгах үйл ажиллагаа нь “тухайн хохирогч түүнд хийсэн бэлгийн үйлдлийг зөвшөөрсөн эсэхийг тохиолдол болгон дээр тогтоох зорилгоор нөхцөл байдлын үнэлгээг хийх шаардлагатай. Ийм үнэлгээг хийхдээ хохирогчийн зүгээс хүчин эсвэл хүчирхийллийг даван туулах ямар зан үйлдэл гаргаж байгааг сайн анзаарах хэрэгтэй бөгөөд ийм нөхцөлд ямар зан үйл гаргаж болзошгүй тухай таамаглалд үндэслэх ёсгүй. Түүнчлэн, хүчингийн гэмт хэргийн хууль тогтоомж, эдгээр тохиолдлыг мөрдөн шалгах, шүүх явцад эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн бэлгийн дур хүслийн тухай хуучинсаг, буруу ойлголтоор хандахгүй байхыг баталгаажуулах хэрэгтэй” гэсэн байна<sup>33</sup>.

Эрүүгийн хуулинд хүчин болон бусад хүчирхийллийн хэргийг хохирогчийн биеийн болон сэтгэл санааны бүрэн бүтэн байдал, бэлгийн бие даасан байдлын эсрэг гэмт хэрэг гэж тодорхойлох ёстой бөгөөд ёс суртахуун, олон нийтийн үзэл суртал, нэр хүндийн эсрэг гэмт хэрэг гэж харуулах ёсгүй<sup>34</sup>. Энэ асуудлыг гэмт хэрэгт тооцох хууль тогтоомж нь жендэрийн хувьд хараат биш байх ёстой бөгөөд тухайн хүний хүйс, жендэрийн мэдрэмж зэргээс үл хамааран хүн бүрийн эрхийг хамгаалах учиртай<sup>35</sup>. Гэхдээ энэ нь жендэрийн хувьд харалган байна гэсэн үг бас биш юм. Бэлгийн хүчирхийлэл үйлдсэн гэмт этгээд болгоныг шийтгэх үр дүнтэй тогтолцоог эрүүгийн хуулиар бүрдүүлэх ёстой бөгөөд зарим гэмтэнг хэлтрүүлэх тохиолдол гаргах ёсгүй (тухайлбал, нөхөр нь л хүссэн бол гэрлэсэн эмэгтэйчүүд ямар ч цаг үе, нөхцөлд бэлгийн хавьталд орохыг зөвшөөрөх ёстой гэж үзээд гэрлэлтийг хүчингийн ангилалд оруулдаггүй)<sup>36</sup>.

Иргэний болон захиргааны хууль тогтоомжид ч гэсэн үр дүнтэй шийдлүүдийг тусгах хэрэгтэй (жишээ нь, тусгаарлах, хамгаалах, аюулгүй байдлыг хангах заалтууд орсон байх)<sup>37</sup>. Нас, үндэс угсаа, арьс өнгө, шашин шүтлэг, гэрлэлтийн байдал, нийгмийн байдал, каст болон гарал угсаа,

---

эрүүгийн шүүхийн гэмт хэргийн элементийг цааш дэлгэрүүлж хүч хэрэгэх, хүч хэрэглэхээр заналхийлэх зэргээр халдах, хүчирхийллийн айдаст автуулах, албадах, баривчлан саатуулсан, сэтгэл зүйн дарамт үзүүлэх, эрх мэдлээр дарангуйлах, тухайн хүнийг юм уу өөр хүнийг, албадлагын орчинд давуу байдлыг ашиглах, жинхэнэ зөвшөөрөл өгөх чадваргүй хүнд халдсан зэргээр тодорхойлжээ.” (Зүйл 7(1)-(g)1(2)).

<sup>29</sup> М.С. Болгарын эсрэг (2003) ECHR 651, 1632р зүйл. Мөн Вертидо Филиппины эсрэг, ЭЯГБХУТК-ийн мэдээ 18/2008, НҮБ-ын баримт CEDAW/C/46/D/18/2008 (2010). Истанбулын конвенцийн 36 (2) зүйл; ЭЯГБХУТК-ийн хороо, Ерөнхий зөвлөмжүүд 35, 33-р зүйл, НҮБ-ын Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн хууль эрх зүйн орчны тухай гарын авлага, 2012, хуудас 24.

<sup>30</sup> Үүнийг тухайн орны шүүх баталсан байдаг. Жишээ нь, Англи Уэльсийн шүүх баталсан байна. R v DPP ба "A" [2013] EWHC 945 (Admin), холбоос: [www.judiciary.gov.uk/wp-content/uploads/JCO/Documents/Judgments/f-vdpp-judgment.pdf](http://www.judiciary.gov.uk/wp-content/uploads/JCO/Documents/Judgments/f-vdpp-judgment.pdf); Калифорнийн дээд шүүх, 29 Cal. 4th 756, 60 P.3d 183, 128 Cal. Rptr. 2d 783, 2003 Cal, холбоос: <http://caselaw.findlaw.com/ca-supreme-court/1330844.html>

<sup>31</sup> Олон улсын эрүүгийн шүүх, “Гэмт хэргийн элементүүд” (2011), Элемент 1, 2 Хүн төрөлхөтний эсрэг гэмт хэрэг хүчинтэй холбоотой Зүйл 7(1)(g)-1, хуудас 8, олон улсын ба олон улсын бус зэвсэгт мөргөлдөөнд хүчин дайны гэмт хэрэг болох тухай зүйл 8(2)(b)(xxii)-1 (хуудас 28), зүйл 8(2)(e)(vi)-1, хуудас 36-37. Олон улсын эрүүгийн шүүх, “Хэрэг шалгах, нотлох дүрэм”, НҮБ-ын баримт ICC-ASP/1/3 (2002), Дүрэм 70(a), (b) ба (c).

<sup>32</sup> Вертидо Филиппиний эсрэг, CEDAW Communication 18/2008, НҮБ-ын, баримт CEDAW/C/46/D/18/2008 (2010), догол догол 8.9(b)(ii).

<sup>33</sup> Эмэгтэйчүүд, гэр бүлийн хүчирхийллийн эсрэг тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай Европын Зөвлөлийн Истанбулын Конвенцийн тайлбар тайлан, , 2011, догол догол 192.

<sup>34</sup> ЭЯГБХУТК-ийн хороо, Ерөнхий зөвлөмжүүд 35, НҮБ-ын баримт. CEDAW/C/CG/35, 2017, догол догол 33; Мөн Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн эрх зүйн талаарх гарын авлагаас үзнэ үү Жендэрийн эрх тэгш байдал, эмэгтэйчүүдийг хүчирхэгжүүлэхийн төлөө НҮБ-ын алба; 2012, хуудас 24, холбоос: [www.unwomen.org/en/digital-library/publications/2012/12/handbook-for-legislation-on-violence-against-women](http://www.unwomen.org/en/digital-library/publications/2012/12/handbook-for-legislation-on-violence-against-women).

<sup>35</sup> НҮБ-ын Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн хууль эрх зүйн орчны тухай гарын авлага, 2012, хуудас 12: [www.unwomen.org/en/digital-library/publications/2012/12/handbook-for-legislation-on-violence-against-women](http://www.unwomen.org/en/digital-library/publications/2012/12/handbook-for-legislation-on-violence-against-women).

<sup>36</sup> НҮБ-ын Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн хууль эрх зүйн орчны тухай гарын авлага, 2012, 24, холбоос: [www.unwomen.org/en/digital-library/publications/2012/12/handbook-for-legislation-on-violence-against-women](http://www.unwomen.org/en/digital-library/publications/2012/12/handbook-for-legislation-on-violence-against-women);

<sup>37</sup> ЭЯГБХУТК-ийн хороо, Ерөнхий зөвлөмжүүд 35, НҮБ-ын баримт. CEDAW/C/CG/35, 2017, догол догол 46, 47; Истанбулын Конвенци, зүйл 5.2.

шилжин суурьшилтийн байдал, ажил (үүнд биеэ үнэлэх орно), бэлгийн чиг хандлага, жендэр, жендэрийн илэрхийллээс (жишээ нь, эмэгтэй хүн өөрийгөө илэрхийлэх зорилгоор юу ч өмссөн байж болно) үл хамааран хохирогч болгон хуулийн өмнө эрх тэгш бөгөөд хүчирхийллээс хамгаалуулах ёстой<sup>38</sup>.

Истанбулын конвенци гишүүн орнуудыг “энэхүү Конвенцийн үндсэн санаанд туссан хүчирхийллийн үйлдлээс урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах, гомдлыг барагдуулах үйл ажиллагааг баталгаажуулсан хууль эрх зүйн болон бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэх хэрэгтэй” гэж тодорхой заасан байна<sup>39</sup>. Үүний нэгэн адил ЭЯГБХУТК-ийн хорооны Ерөнхий зөвлөмж 35-д “ийм гэмт үйлдлийг (жендэрт суурилсан хүчирхийлэл) мөрдөн шалгах, шийтгэл оногдуулах, гүйцэтгэх, хохирогчийн гомдлыг барагдуулах үйл явцад бэрхшээл тулгарч байгаа нь эмэгтэйчүүдийн эсрэг жендэрт суурилсан хүчирхийллийн үйлдлийг өөгшүүлсэн, зөвшөөрсөнг илтгэх нэг хэлбэр юм. Энэ чадамжгүй байдал нь өөрөө хүний эрхийн зөрчил мөн” гэсэн байна<sup>40</sup>.

### **М.С. Болгарын эсрэг: Эсэргүүцэл үзүүлээгүй байх нь зөвшөөрөл биш гэдгийг тогтоосон дэвшилтэт шийдвэр**

2004 онд Хүний эрхийн асуудлаарх Европын шүүхээс (үүнээс хойш Шүүх гэнэ) хүчингийн гэмт хэргийг нотлох хүчин зүйл нь хүч хэрэглэсэн, эсвэл хохирогч эсэргүүцэл үзүүлсэн гэдгээс илүүтэйгээр зөвшөөрөл өгөөгүй байх гэж тогтоожээ<sup>41</sup>.

Уг хэрэг нь Болгарын насанд хүрээгүй охин М.С.-ийн хэрэг бөгөөд түүнийг 14 настай байхад нь хоёр эрэгтэй 1995 оны 7 дугаар сарын 31, 8 дугаар сарын 1-ний өдрүүдэд хүчиндсэн гэж мэдүүлсэн байна. Уг хэрэг тэр гурав диско бааранд очоод буцах шөнө болжээ. Охин эрэгтэйчүүдийн нэгэнтэй нь өмнөх орой нь танилцсан байна. Нөгөө эрэгтэй нь ангийн хөвгүүний ах байжээ. Охин хүчиндүүлсэн тухайгаа цагдаад мэдэгджээ. 1995 оны 11 дүгээр сард прокурорын газраас эрүүгийн гэмт хэргийг нээж, мөрдөн шалгуулахаар шийдсэн байна. Охин мөрдөн байцаагчид мэдүүлэхдээ идэвхтэй эсэргүүцэл үзүүлэх хангалттай хүч чадал байгаагүй гэсэн бол, 2 эрэгтэй бэлгийн хавьтлыг охинтой харилцан зөвшөөрөлцсөний үндсэн дээр хийсэн гэж маргаж байв.

1997 оны 3 дугаар сарын 17-нд М.С.-ийн эсрэг хүч хэрэглэсэн, эсвэл охин бусдаас тусламж гуйсан баримт олдоогүй гэх үндэслэлээр прокурор энэ хэргийг хаах шийдвэр гаргажээ. Охин энэ шийдвэрийг давж заалдахаар мужийн шүүх, дараа нь Ерөнхий прокурорын газарт хандсан байна. Гэвч аль аль нь хэргийг хэрэгсэхгүй болгосон бөгөөд шалтгаан нь бүгд ижил байв. Жишээ нь, хоёр дахь удаагаа давж заалдахад прокурорын өгсөн тайлбар нь охины биен дээр шарх, хөхөрсөн толбо, урагдсан хувцас гэх мэт нотлох баримт байгаагүй гэсэн байна. Хэдийгээр насанд хүрээгүй охин анх удаа бэлгийн хавьталд орохдоо маш богино хугацаанд 2 өөр хүнтэй үйлдсэн нь хачирхал төрүүлж байна гэж дурьдсан боловч энэ нь өөрөө нотлох хангалттай баримт болохгүй, нэмэлт нотлох баримт олдохгүй гэдэг нь тодорхой тохиолдолд гэмт үйлдэл гарсан гэдгийг харуулахгүй гэжээ<sup>42</sup>.

1997 оны 12 дугаар сард охин Европын хүний эрхийн шүүхэд хандаж хохирогчийг эсэргүүцэл үзүүлсэн гэдгээ нотлохыг шаардах, нотлож чадахгүй болохоор нь хүчингийн гэмт үйлдлийг шийтгэхгүй орхиж буй хууль эрх зүйн тогтолцоо нь өөрөө хангалтгүй байна гэж гомдол гаргажээ. Шүүх, сэжиглэгдэж буй гэмт этгээдүүдийн буруутай эсэхийг тогтоогоогүй боловч, “бэлгийн гэмт үйлдлийг мөрдөн шалгахдаа уян хатан бус арга хэрэглэж, хохирогчийг эсэргүүцэл үзүүлснээ батлахыг шаардах нь хүчингийн зарим хэлбэрүүдийг шийтгэхгүй орхих эрсдлийг гаргаж байгаа бөгөөд ингэснээрээ иргэний бэлгийн эрх чөлөөнд халдах эрсдлийг үүсгэж байна” гэж тогтоожээ. Тийм учраас, Болгарын засаг захиргаа “хэргийн нөхцөл байдлыг тодорхой болгох боломжит бүх арга хэмжээг аваагүй, хоорондоо зөрүүтэй мэдүүлүүдийг мөрдөн шалгаагүй” болох нь тогтоогджээ.<sup>43</sup> Цаашлаад, шүүхээс энэ хэргийг мөрдөн шалгах явцдаа Европын хүний эрхийн конвенцийн (эрүүдэн шүүх, хүнлэг бус, гутаан доромжилсон хандлагаас хамгаалах тухай) 3 дугаар зүйл, (хувийн болон гэр бүлийн амьдралыг хамгаалах эрхийн тухай) 8 дугаар зүйлийг хэрэгжүүлэх үүргээ биелүүлээгүй гэж тогтоосон байна.

<sup>38</sup> ЭЯГБХУТК-ийн хороо, Ерөнхий зөвлөмжүүд 35 НҮБ-ын баримт. CEDAW/C/CG/35, 2017, догол догол 11, 12, 23, 38 (b). Мөн Истанбулын конвенцийн зүйл3-ийг үз.

<sup>39</sup> Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, тэмцэх тухай Европын зөвлөлийн конвенци (Истанбулын конвенци), 2011 оны 5 сарын 11, Зүйл 5.2.

<sup>40</sup> ЭЯГБХУТК-ийн хороо, Ерөнхий зөвлөмжүүд 35, UN. Doc. CEDAW/C/CG/35, 2017, догол догол 24(b).

<sup>41</sup> М.С. Болгарын эсрэг, No. 39279/98, ECHR 2203XII догол .

<sup>42</sup> М.С. Болгарын эсрэг, No. 39279/98, ECHR 2203XII, догол догол .65

<sup>43</sup> М.С. Болгарын эсрэг, No. 39279/98, ECHR 2203XII, догол 169-187



### 3.1 ХҮЧИНГИЙН ТАЛААРХ ЕВРОПЫН ХУУЛЬ ТОГТООМЖИД «ЗӨВШӨӨРӨЛ» ХЭРХЭН ТУССАН БЭ

Нэгдсэн Үндэсний Байгууллагын Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах хороо нь (цаашид хороо гэх) сүүлийн 5 жилийн хугацаанд Европын хэд хэдэн оронд хүчингийн талаарх үндэсний хууль тогтоомжоо олон улсын стандартад нийцүүлэх, түүний дотор Истанбулын конвенцид нийцүүлэх, хүчинг тодорхойлохдоо зөвшөөрөлгүй бол гэмт хэрэг гэж үзэх талаар зөвлөмж гаргасан байна (жишээ нь, Румын<sup>44</sup>, Швед<sup>45</sup>, Португаль<sup>46</sup>, Хорват<sup>47</sup>, Финлянд<sup>48</sup>, Унгар<sup>49</sup>, Норвеги<sup>50</sup>).

Энэхүү судалгаанд хамрагдсан орнуудаас 23 улс Истанбулын конвенцид нэгдэн орсон (Австри, Бельги, Хорват, Кипр, Дани, Эстон, Финлянд, Франц, Герман, Грек, Исланд, Итали, Люксембург, Мальт, Нидерланд, Норвеги, Польш, Португаль, Румын, Словени, Испани, Швед, Швейцарь) бөгөөд 8 улс гарын үсгээ зурсан боловч хараахан нэгдээгүй байна (Болгар, Чех, Унгар, Ирланд, Латви, Литва, Словак, Их Британи. Европын зөвлөл нь Европын эдийн засгийн бүсээс өргөн хүрээтэй, 47 улсыг нэгтгэдэг бөгөөд 33 нь конвенцид нэгдэн ороод байна.) Европын холбоо 2017 онд конвенцид нэгдэн орсон<sup>51</sup>.

Энэхүү судалгаанд хамрагдсан улс орнуудын конвенцид нэгдсэн байдал

Нэгдэн орсон	Дэмжсэн ч хараахан нэгдээгүй байгаа
1. Австри	1. Болгар
2. Бельги	2. Чех
3. Хорват	3. Унгар
4. Кипр	4. Ирланд
5. Дани	5. Латви
6. Эстон	6. Литва
7. Финлянд	7. Словак
8. Франц	8. Их Британи
9. Герман	
10. Грек	
11. Исланд	
12. Итали	
13. Люксембург	
14. Мальт	
15. Нидерланд	
16. Норвеги	
17. Польш	
18. Португаль	
19. Румын	
20. Словени	
21. Испани	
22. Швед	
23. Швейцарь	

<sup>44</sup> Эмэгтэйчүүдийн эсрэг ялгаварлан гадуурхалтыг устгах тухай НҮБ-ын Хороо (ЭЯГУХороо), Ажиглалтыг дүгнэлт, Румын, 2017 оны 7 дугаар сар, CEDAW/C/ROU/CO/7-8, холбоос: [http://tbinternet.ohchr.org/\\_layouts/treatybodyexternal/Download.aspx?symbolno=CEDAW%2fC%2fROU%2fCO%2f7-8&Lang=en](http://tbinternet.ohchr.org/_layouts/treatybodyexternal/Download.aspx?symbolno=CEDAW%2fC%2fROU%2fCO%2f7-8&Lang=en), догол 19(b).

<sup>45</sup> ЭЯГХУТК-ийн хороо, Ажиглалтууд, Швед, 2016 оны 3 сар, CEDAW/C/SWE/CO/8-9, холбоос: [http://tbinternet.ohchr.org/\\_layouts/treatybodyexternal/Download.aspx?symbolno=CEDAW%2fC%2fSWE%2fCO%2f8-9&Lang=en](http://tbinternet.ohchr.org/_layouts/treatybodyexternal/Download.aspx?symbolno=CEDAW%2fC%2fSWE%2fCO%2f8-9&Lang=en), догол 15.

<sup>46</sup> ЭЯГХУТК-ийн хороо, Ажиглалтууд, Португали, 2015 оны 11 сар, CEDAW/C/PRT/CO/8-9, холбоос: [http://tbinternet.ohchr.org/\\_layouts/treatybodyexternal/Download.aspx?symbolno=CEDAW%2fC%2fPRT%2fCO%2f8-9&Lang=en](http://tbinternet.ohchr.org/_layouts/treatybodyexternal/Download.aspx?symbolno=CEDAW%2fC%2fPRT%2fCO%2f8-9&Lang=en), догол 25(a).

<sup>47</sup> ЭЯГХУТК-ийн хороо, Ажиглалтууд, Хорват, 2015 оны 7 сар, CEDAW/C/HRV/CO/4-5, холбоос: [http://tbinternet.ohchr.org/\\_layouts/treatybodyexternal/Download.aspx?symbolno=CEDAW%2fC%2fHRV%2fCO%2f4-5&Lang=en](http://tbinternet.ohchr.org/_layouts/treatybodyexternal/Download.aspx?symbolno=CEDAW%2fC%2fHRV%2fCO%2f4-5&Lang=en), догол 19(h).

<sup>48</sup> ЭЯГХУТК-ийн хороо, Ажиглалтууд, Финлянд, 2014 оны 3 сар, CEDAW/C/FIN/CO/7, холбоос: [http://tbinternet.ohchr.org/\\_layouts/treatybodyexternal/Download.aspx?symbolno=CEDAW%2fC%2fFIN%2fCO%2f7&Lang=en](http://tbinternet.ohchr.org/_layouts/treatybodyexternal/Download.aspx?symbolno=CEDAW%2fC%2fFIN%2fCO%2f7&Lang=en), догол 19(e).

<sup>49</sup> ЭЯГХУТК-ийн хороо, Ажиглалтууд, Унгар, 2013 оны 3 сар, CEDAW/C/HUN/CO/7-8, холбоос: [http://tbinternet.ohchr.org/\\_layouts/treatybodyexternal/Download.aspx?symbolno=CEDAW%2fC%2fHUN%2fCO%2f7-8&Lang=en](http://tbinternet.ohchr.org/_layouts/treatybodyexternal/Download.aspx?symbolno=CEDAW%2fC%2fHUN%2fCO%2f7-8&Lang=en), догол 20(g).

<sup>50</sup> ЭЯГХУТК-ийн хороо, Ажиглалтууд, Норвеги, 2012 оны 3 сар, CEDAW/C/NOR/CO/8, холбоос: [http://tbinternet.ohchr.org/\\_layouts/treatybodyexternal/Download.aspx?symbolno=CEDAW%2fC%2fNOR%2fCO%2f8&Lang=en](http://tbinternet.ohchr.org/_layouts/treatybodyexternal/Download.aspx?symbolno=CEDAW%2fC%2fNOR%2fCO%2f8&Lang=en), догол 24(b).

<sup>51</sup> Конвенцийг үзэглэсэн, соёрхон баталсан сүүлийн мэдээллийг Европын зөвлөлийн хуудаснаас харна уу. [www.coe.int/en/web/conventions/full-list/-/conventions/treaty/210/signatures](http://www.coe.int/en/web/conventions/full-list/-/conventions/treaty/210/signatures).

Сонирхолтой нь, Истанбулын конвенцид нэгдэн орсон улс орнуудын 6 орноос бусад нь (Бельгид зөвшөөрөл дээр үндэслэсэн хүчингийн тодорхойлолтыг 1989 оноос хойш ашигладаг, Кипр, Герман, Исланд, Швед) конвенцийн зөвшөөрөлд суурилсан хүчингийн тодорхойлолт ашиглах тухай стандартыг мөрдөхгүй байна. Жишээ нь Дани улс конвенцид 2014 онд нэгдэн орсон бөгөөд тус улсын Парламент 2017 оны 4 дүгээр сард хүчингийн тодорхойлолтыг өөрчлөх тухай хуулийн төслийг Улаан-Ногоон эвслээс өргөн барьсныг буцаасан бөгөөд ийм тодорхойлолт хэрэгтэй гэдгийг нотлох хангалттай баримт байхгүй байна гэжээ. Дани улс олон улсын хүний эрхийн хэм хэмжээг хүлээн зөвшөөрсөн, тэдгээрийг хэрэгжүүлэх үүргийнхээ дагуу хууль тогтоомжоо өөрчлөх үүрэгтэй гэдгээ мэдсээр байж ийм шийдвэр гаргасан нь хачирхалтай юм. Эмнести Интернэшнл гэх мэт олон төрийн бус байгууллагууд хуульд холбогдох өөрчлөлтийг оруулуулах талаар ухуулга нөлөөллийн ажил хийж байна. Исланд, Швед зэрэг улс хүчингийн тодорхойлолтдоо 2018 оны 3 дугаар сар, 5 дугаар сард тус тус өөрчлөлт оруулжээ<sup>52</sup>. Энэ нь Шведийн өөрчлөлт эмэгтэйчүүдийн эрхийн төлөөх байгууллагуудын олон жилийн нөлөөллийн ажлын үр дүнд гарсан байна. Финляндын төрийн бус байгууллагуудын эвсэл хүчингийн тодорхойлолтыг өөрчлөх хуулийн төслийг дэмжих ард нийтийн гарын үсгийг цуглуулах ажил хийж байгаа бөгөөд удахгүй Парламентад өргөн барина<sup>53</sup>.

Испани болон Португалийн засгийн газрын аль аль нь 2018 онд зөвшөөрөлгүй бэлгийн хавьтлыг хүчингийн гэмт хэрэгт тооцох хуулийн өөрчлөлтийг хийнэ гэдгээ мэдэгдсэн бөгөөд эдгээр улсад бүлэглэн хүчиндсэн томоохон хэргийн хохирогч нь гомдлоо барагдуулж чадаагүйд олон нийт дургүйцлээ илэрхийлсний үр дүнд ийм шийдвэрт хүрсэн байна. Испаний хувьд хүчингийн гэмт хэрэг үйлдсэн гэж сэжиглэгдсэн 5 эрэгтэй бэлгийн хүчирхийллийн арай зөөлөн зүйл ангиар шийтгэгдсэн, харин Португалид “өөрийгөө хамгаалах чадваргүй хүнтэй бэлгийн үйлдэл хийсэн” хоёр эрэгтэйд тэнсэн харгалзах ял өгчээ. Олон нийтийн дургүйцлийг хүргэсэн зүйл нь эдгээр хэргийг шүүсэн шүүгчид хохирогчийн талаар буруу ойлголтыг өгч, үг хэлээр доромжилсон бөгөөд ялангуяа Португалийн хэргийн хохирогчийн эрх, сонирхлыг шууд зөрчсөн шийдвэр гаргасан байна<sup>54</sup>.

Сонирхолтой нь Ирланд болон Их Британий бүрэлдэхүүнд ордог улсууд (Англи, Уэльс, Шотланд, Умард Ирланд) бүгд зөвшөөрөлд суурилсан хүчингийн тодорхойлолтыг ашигладаг бөгөөд эдгээр улс нь Истанбулын конвенцид хараахан нэгдэн ороогүй байгаа орнууд юм. Европын эдийн засгийн бүсийн 6 орон Бельги, Кипр (тус улсын хууль Английн хуулийг дагадаг), Герман, Исланд, Люксембург, Швед нь зөвшөөрөлд суурилсан хүчингийн тодорхойлолтыг ашигладаг бөгөөд хэрэгжилттэй холбоотой асуудлуудыг доор өгүүлэх болно.

Дүгнэхэд, энэхүү судалгаанд хамруулсан Европын 31 орноос (Их Британий бүрэлдэхүүнд байгаа улсыг хамруулвал 33 орон) зөвхөн **10** орон л зөвшөөрөлд суурилсан хүчингийн тодорхойлолтыг ашиглаж байна. Үүнд Англи, Уэльс, ба Ирланд нэг хуультай, Шотланд, Умард Ирланд, Бельги, Кипр, Герман, Исланд, Люксембург, Швед орно. Үүнээс гурван улсын хууль нь Их Британий хууль гэж үзвэл ердөө **8** улсыг л тооцож болохоор байна.

Германд зөвшөөрөлд үндэслэсэн хүчингийн тодорхойлолтыг 2016 оны 11 дүгээр сард нэвтрүүлжээ. Хүчиндүүлсэн гэдгээ нотлохын тулд хохирогч нь эсэргүүцэл үзүүлснээ батлах шаардлагыг авч хаясан байна<sup>55</sup>. Үнэхээр ч, 2017 оны Тэгш байдлын тайланд дурьдсанаар “эмэгтэй хүн зөвшөөрсөн учраас хүчиндэгчийг эсэргүүцэж тэмцээгүй гэж хэзээ ч ойлгож болохгүй”<sup>56</sup>. Германы хуулийн заалт “**үгүй гэсэн бол үгүй**” гэж олны дунд нэршсэн бөгөөд хохирогч биеийн үйлдэл, үг хэлээр эсэргүүцлээ илэрхийлээгүй бол зөвшөөрсөн гэж ойлгогдохоор байв. Энэ заалтыг авч хаяснаар

<sup>52</sup> Эрүүгийн хууль (Швед) Brottsbalk (1962: 700) [www.lagen.nu/1962:700#K6](http://www.lagen.nu/1962:700#K6); [www.amnesty.org/en/latest/news/2018/05/sweden-new-rape-law-is-historic-victory-for-metoo-campaigners/](http://www.amnesty.org/en/latest/news/2018/05/sweden-new-rape-law-is-historic-victory-for-metoo-campaigners/). Эрүүгийн хууль (Исланд), зүйл 194, холбоос: [www.althingi.is/lagas/nuna/1940019.html](http://www.althingi.is/lagas/nuna/1940019.html).

<sup>53</sup> [www.suostumus2018.fi/](http://www.suostumus2018.fi/).

<sup>54</sup> [www.elpais.com/politica/2018/07/10/actualidad/1531217547\\_930023.html](http://www.elpais.com/politica/2018/07/10/actualidad/1531217547_930023.html); Португалийн Эмнести Интернэшнл, “Португалийн Эмнести Интернэшнл Портогийн давж заалдах шүүхийн дүрэм дэх жендэрийн хоцрогдмол ойлголтыг шүүмжилж байна” 2018, [www.amnistia.pt/amnistia-internacional-portugal-preocupada-com-acordao-que-contem-estereotipos-de-genero-com-mensagem-prejudicial-as-vitimas-de-violencia-sexual/](http://www.amnistia.pt/amnistia-internacional-portugal-preocupada-com-acordao-que-contem-estereotipos-de-genero-com-mensagem-prejudicial-as-vitimas-de-violencia-sexual/); [www.publico.pt/2018/10/04/sociedade/noticia/governo-quer-alterar-leis-sobre-crimes-sexuais-1846186](http://www.publico.pt/2018/10/04/sociedade/noticia/governo-quer-alterar-leis-sobre-crimes-sexuais-1846186)

<sup>55</sup> Эрүүгийн хууль (Герман), Strafgesetzbuch in der Fassung der Bekanntmachung vom 13. November 1998 (BGBl. I S. 3322), das zuletzt durch Artikel 1 des Gesetzes vom 30. September 2017 (BGBl. I S. 3532) geändert worden ist, art 177, холбоос: [www.gesetze-im-internet.de/stgb/](http://www.gesetze-im-internet.de/stgb/).

<sup>56</sup> Өнөөгийн тэгш байдал, “Дэлхий ичиж байна. Дэлхийн хүчингийн гэмт хэргийн тархалт. Хуулийн хүрээнд эмэгтэйчүүд, охидыг бэлгийн хүчирхийллээс хамгаалж чадахгүй байна”, 2017 он, хуудас 13

зөвшөөрөхгүй байх тухай ойлголтыг бүрэн тусгаагүй ч, бэлгийн хавьталд орох хүсэлгүй байгаагаар илэрхийлэх, эс илэрхийлэх сонголтыг тусгасан байна. “Үгүй гэсэн бол үгүй” гэх санаа нь асуудал дагуулж байна, учир нь ямар нэгэн байдлаар эсэргүүцэл үзүүлээгүй, үг хэлээгүй тохиолдол болгоныг зөвшөөрсөн гэж тооцох бөгөөд энэ нь “харилцан зөвшөөрөл” буюу хоёр тал идэвхтэй ярилцаж, чөлөөтэй сонголт хийх утгыг алдагдуулж байв. Энэ ойлголтын дагуу эмэгтэйчүүд өөрөөр хэлээгүй л бол бэлгийн хавьталд ороход бэлэн байдаг гэсэн агуулгатай болж байв.

Эмэгтэйчүүдийн эсрэг болон гэр бүлийн хүчирхийллийн эсрэг үйл ажиллагааг дэмжих зөвлөхүүдийн баг (ГРЕВИО) нь Истанбулын конвенцийн хэрэгжилтийг хянах үүрэгтэй бөгөөд 2017 онд Австри улсын үнэлгээг хийжээ. Уг тайланд “хүний бэлгийн эрх чөлөөний эсрэг” үйлдсэн (үүнд “хүнийг хүсээгүй байхад” бэлгийн хавьтал хийх үйлдэл орж байгаа боловч, гэмт хэрэгт тооцдоггүй) гэмт хэргийн талаар дурьдахдаа “хүний хүслийн эсрэг бэлгийн хавьтал үйлдэх гэсэн Австрийн тодорхойлолт, зөвшөөрөлгүй бэлгийн хүчирхийлэл гэсэн конвенцийн тодорхойлолтын хооронд бага ч гэсэн ялгаа байна. Энэ тохиолдолд, жишээ нь, хохирогч эсэргүүцэл үзүүлээгүй ч, зөвшөөрөөгүй тохиолдолд хэргийг шүүхээр шийдэхгүй болж байна. Гэмт үйлдлийг Австрийн хуулийн дагуу шийдүүлэхийн тулд хохирогч дургүйцлээ үг хэлээр, эсвэл ямар нэгэн өөр байдлаар илэрхийлэх хэрэгтэй болно”<sup>57</sup>. Энэ ажиглалт Германы хуульд ч хамаатай болж байгаа бөгөөд Германы хэрэгжүүлж буй энэ тодорхойлолт нь конвенцийн санааг бүрэн тусгаж байгаа эсэхэд эргэлзээ төрүүлж байна.

### 3.1.1 ХУУЛЬД ЗӨВШӨӨРЛИЙГ ХЭРХЭН ТОДОРХОЙЛДОГ ВЭ

Олон улсын болон бүсийн хүний эрхийн аль ч бичиг баримтад зөвшөөрөх гэдэг ойлголтыг тодорхойлоогүй байдаг ба гишүүн орнууд ч тодорхой болгох тал дээр ямар нэгэн санаачлага гаргахгүй байна. Истанбулын конвенцийн тайлбар тайлангийн 193 дугаар зүйлд “... гэвч чөлөөтэй хийсэн сонголтын үр дүнд зөвшөөрөх гэдгийг хууль тогтоомжид ямар нэр томъёоллоор тусгах, ямар нөхцөл байдлыг ойлгох талаар гишүүн орнууд өөрсдөө шийдвэрээ гаргана гэж Конвенцийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан байгаа нь хүн өөрийн чөлөөтэй сонголтын үндсэн дээр сайн дураараа зөвшөөрөл өгөх ёстой гэдгийг л заасан бөгөөд тухайн нөхцөл байдал ямар байсан талаарх үнэлгээг харгалзаж үзэх хэрэгтэй” гэжээ<sup>58</sup>.

Харилцан зөвшөөрсөн, эсвэл зөвшөөрөөгүй гэдгийг хэрхэн ойлгох тухай зааварчилгааг (олон улсын зэвсэгт мөргөлдөөний үед үйлдэгдсэн гэмт хэргийг авч үзэх зорилготой) Олон улсын эрүүгийн шүүхийн Үйл ажиллагаа, нотолгооны дүрмийн 70 дугаар зүйлд зааж өгсөн байдаг. Үүнд:

- (а) Хохирогчид хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр айлгах, албадах, эсвэл түүнийг хүрээлж буй дарамттай нөхцөл байдлыг урвуулан ашиглаж чөлөөт сонголтыг нь хязгаарлаж, үгээр эсвэл үйлдлээр эсэргүүцэх боломжгүй болгосныг зөвшөөрсөн гэж үзэхгүй;
- (б) Хохирогч зөвшөөрөл өгч чадахааргүй нөхцөл байдалд байсан бол түүний хэлсэн үг, үйлдлийг зөвшөөрсөн гэж үзэхгүй;
- (в) Хохирогч болж өнгөрсөн бэлгийн хавьталын үед үг хэлээгүй, эсвэл хариу эсэргүүцэл үзүүлээгүйг зөвшөөрсөн гэж үзэхгүй;
- (г) Хохирогч, эсвэл гэрчийн бэлгийн өмнөх болон дараагийн амьдрал нь түүний нэр хүнд, зан чанар, эсвэл бэлгийн дур сонирхол зэргийг илэрхийлэхгүй<sup>59</sup>.

**Эмэгтэйчүүдийн эсрэг ялгаварлан гадуурхалтыг зогсоох хороо (CEDAW)-ноос Карен Таяаг Вертигогийн Филиппиний эсрэг хэмээх хэрэг дээр гаргасан 2010 оны шийдвэр нь зөвшөөрөл өгсөн үү гэдгийг үнэлэхэд чухал зааварчилгаа болдог.** НҮБ-ын Эдийн засаг нийгмийн асуудлаарх байгууллагаас эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх хууль эрх зүйн орчны талаарх ном гаргаснаас иш татан, хариуцагч улс орон бэлгийн хүчирхийллийн тодорхойлолтыг гаргах хэрэгтэй гэж зөвлөсөн бөгөөд үүнд:

<sup>57</sup> Эмэгтэйчүүдийн эсрэг болон гэр бүлийн хүчирхийллийн эсрэг үйл ажиллагааг дэмжих зөвлөхүүдийн баг (ГРЕВИО) “Австрийн суурь үнэлгээний тайлан” 2017, догол догол 141, холбоос: [www.rm.coe.int/grevio-report-austria-1st-evaluation/1680759619](http://www.rm.coe.int/grevio-report-austria-1st-evaluation/1680759619).

<sup>58</sup> Эмэгтэйчүүдийн эсрэг, гэр бүлийн хүчирхийллийн эсрэг тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай Европын зөвлөлийн Истанбулын конвенци, 2011, догол 193 догол .

<sup>59</sup> Олон улсын эрүүгийн шүүхийн Шалгах явц, нотлох дүрэм , Хоёрдугаар хэвлэлт 2013, Хаг хот, холбоос: [www.icc-cri.int/iccdocs/pids/legal-texts/rulesprocedureevidenceeng.pdf](http://www.icc-cri.int/iccdocs/pids/legal-texts/rulesprocedureevidenceeng.pdf).

- “Ямар ч эргэлзээгүй, сайн дурын зөвшөөрөл” байх хэрэгтэй бөгөөд хохирогч эсвэл гэрч үнэхээр зөвшөөрсөн гэдгийг баталгаажуулахын тулд сэжигтэн ямар арга хэмжээ авсан талаар нотлох шаардлагыг оруулах, эсвэл
- Бэлгийн хавьтал “албадлагын нөхцөлд” болсон гэдгийг батлах хэрэгтэй бөгөөд албадлагын нөхцөл гэдэгт юуг хамруулах талаар өргөн ойлголтуудыг оруулах хэрэгтэй гэсэн байна<sup>60</sup>.

Европт хэрэгжиж буй уламжлалт эрх зүйд (Англи, Уэльс, Шотланд, Умард Ирланд болон Ирланд) харилцан зөвшөөрөл гэдгийг тодорхойлж тусгасан байна<sup>61</sup>. Ирланд улсад 1981 оноос хойш хүчинг “харилцан зөвшөөрөлгүй бэлгийн хавьтал” гэж тодорхойлж ирсэн бөгөөд 2017 оны 2 дугаар сард харилцан зөвшөөрөл гэдгийн хууль ёсны тодорхойлолтыг нэвтрүүлжээ. 2017 оны Эрүүгийн хуулийн (Бэлгийн гэмт хэргийн тухай) 48(9) дүгээр зүйлд “(1) Тухайн хүн бэлгийн хавьталд орох эсэхээ чөлөөтэй сонгож, сайн дурын үндсэн дээр зөвшөөрсөн тохиолдолд харилцан зөвшөөрсөн гэж ойлгоно” гээд, бүрэн дүүрэн биш ч харилцан зөвшөөрөөгүй гэж тооцогдох нөхцөл байдлын жагсаалтыг өгсөн байна. Түүнчлэн, уг зүйлд “(4) Бэлгийн хавьтал эхлэхээс өмнө, бэлгийн хавьтал эхэлсэн ч хэзээ ч хамаагүй хавьтлаас татгалзах боломжтой”, мөн “(5) Тухайн хүн бэлгийн хавьталыг эсэргүүцэх үйлдэл хийгээгүй, дургүйцлээ илэрхийлээгүй нь бэлгийн хавьталд орохыг зөвшөөрсөн гэсэн үг биш” гэж заасан байна<sup>62</sup>.

Англи болон Уэльсд харилцан зөвшөөрөл гэх тодорхойлолтыг 2003 оноос хойш хуулиндаа нэвтрүүлсэн бөгөөд шүүгчид, мөрдөн байцаагчдад зориулсан шинэ журам, гарын авлага зэргийг Нийтийн прокурорын албанаас 2015 оны 3 дугаар сард гаргасан байна<sup>63</sup>. Шинэ журам, гарын авлага нь хуулийг тайлбарлах, мөрдөн байцаах ажилтнуудад 2003 оны хуулийн дагуу сэжигтнүүдээс харилцан зөвшөөрсөн гэдгийг хэрхэн баталгаажуулсан талаар нь асууж тодруулах хэрэгтэйг сануулах зорилготой юм. Мөн тухайн нөхцөл байдалд хохирогч харилцан зөвшөөрөл боломжтой байсан эсэхийг шалгахыг шаардаж байгаа бөгөөд үүнд хохирогчид сэтгэл мэдрэлийн эсвэл суралцах асуудалтай байсан уу, хохирогч согтууруулах ундаа, эсвэл мансууруулах бодисын нөлөөтэй унтах, ухаан алдах, эсвэл эсэргүүцэл үзүүлэх боломжгүй болсон байв уу, гэр бүлийн хүчирхийлэл болон бусад эрх мэдэл ашигласан хүчирхийллийн тохиолдолд хохирогч санхүү болон бусад зүйлээр хараат байв уу гэдгийг шалгах хэрэгтэй. Тухайн үед Англи, Уэльсийн Нийтийн прокурорын албаны захирал Алисон Сондерс хэлэхдээ:

“Эдгээр гарын авлагын тусламжтайгаар “үгүй гэсэн бол үгүй” хэмээх ойлголт бодит байдалд нийцэхгүй байгааг харлаа. Үнэндээ хүчингийн гэмт хэргийн хохирогчид өөрийгөө хамгаалах, **нөхцөл байдлыг даван туулахын тулд эсэргүүцэл үзүүлэх биш, харин хөшинги байдалд ордог нь тогтоогдоод байна.** Харилцан зөвшөөрсөн гэх асуудал яригдаж буй хэрэг болгон дээр **цагдаа, шүүхийн ажилтнууд хохирогч үнэхээр чөлөөтэй, ухамсартайгаар “тийм” гэж зөвшөөрснийг сэжигтэн яаж баталгаажуулсан бэ гэдгийг байнга асуугаасай гэж хүсэж байна**” гэжээ<sup>64</sup>.

Хэдийгээр хууль тогтоомж, бодлогын баримт бичиг цаасан дээр сайхан харагдаж байгаа боловч, харилцан зөвшөөрлийн талаархи ойлголт хуулийн мэргэжилтнүүдийн дунд ч хангалттай сайн биш байна. 2018 оны Гардиан сонины судалгаанаас харахад Англи, Уэльсд хүчингийн гэмт хэргийг шүүн шийдвэрлэж байгаа үйл ажиллагаанд нэлээд их асуудал гардаг бөгөөд хуулийг

<sup>60</sup> Вердито Филиппиний эсрэг, CEDAW Communication 18/2008, НҮБ-ын баримт CEDAW/C/46/D/18/2008 (2010), догол догол 8.9(b)(ii).

<sup>61</sup> Бүлэг 74 Бэлгийн гэмт хэргийн талаарх тогтоол 2003 (Англи, Уэльс), холбоос: [www.legislation.gov.uk/ukpga/2003/42/contents](http://www.legislation.gov.uk/ukpga/2003/42/contents); Хэсэг 2: Зөвшөөрөл ба боломжит итгэл үнэмшил, Бэлгийн гэмт хэрэг (Шотланд) тогтоол 2009, [www.legislation.gov.uk/asp/2009/9/contents](http://www.legislation.gov.uk/asp/2009/9/contents); Бүлэг 3 Бэлгийн гэмт хэрэг (Умарт Ирланд) Тушаал 2008, [www.legislation.gov.uk/nisi/2008/1769/contents](http://www.legislation.gov.uk/nisi/2008/1769/contents); Эрүүгийн хуулийн Бүлэг 48(9) (Бэлгийн гэмт хэрэг) Тогтоол 2017 (Ирланд), [www.irishstatutebook.ie/eli/2017/act/2/enacted/en/print.html](http://www.irishstatutebook.ie/eli/2017/act/2/enacted/en/print.html).

<sup>62</sup> Эрүүгийн хууль (Бэлгийн гэмт хэрэг) Тогтоол 2017, 2017 оны 3 дугаар сарын 27-нд хүчин төгөлдөр болсон

<sup>63</sup> Краун Прокурорын Алба, “Ман”Хүчин, бэлгийн гэмт хэргийн талаарх хуулийн удирдамж”, [www.cps.gov.uk/legal/p\\_to\\_r/rape\\_and\\_sexual\\_offences-ийг](http://www.cps.gov.uk/legal/p_to_r/rape_and_sexual_offences-ийг) үз. Холбогдох нийтлэл: [www.telegraph.co.uk/news/uknews/law-and-order/11375667/Men-must-prove-a-woman-said-Yes-under-tough-new-rape-rules.html?\\_sm\\_au\\_=iVVPDZjVnnHQfH66](http://www.telegraph.co.uk/news/uknews/law-and-order/11375667/Men-must-prove-a-woman-said-Yes-under-tough-new-rape-rules.html?_sm_au_=iVVPDZjVnnHQfH66); [www.independent.co.uk/news/uk/crime/the-ddps-tough-new-rape-guidelines-what-are-they-and-why-are-they-so-important-10011603.html?\\_sm\\_au\\_=iVVPDZjVnnHQfH66](http://www.independent.co.uk/news/uk/crime/the-ddps-tough-new-rape-guidelines-what-are-they-and-why-are-they-so-important-10011603.html?_sm_au_=iVVPDZjVnnHQfH66).

<sup>64</sup> “Хүчингийн талаарх үндэсний хуралд прокурор, цагдаагийн байгууллага хамтдаа зөвшөөрөлд анхаарч байна.”, 2015 оны 1 дүгээр сарын 28, холбоос: [http://www.cps.gov.uk/news/latest\\_news/cps\\_and\\_police\\_focus\\_on\\_consent\\_at\\_first\\_joint\\_national\\_rape\\_conference/](http://www.cps.gov.uk/news/latest_news/cps_and_police_focus_on_consent_at_first_joint_national_rape_conference/)

бүрэн дүүрэн хэрэгжүүлэхийн тулд сургалт, мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх үйл ажиллагаа чухал байна<sup>65</sup>.

## **3.2 ЕВРОПТ ХҮЧ ХЭРЭГЛЭСЭН ЭСЭХЭЭР ХҮЧИНГ ТОДОРХОЙЛОХ ХАНДЛАГА ТҮГЭЭМЭЛ БАЙНА**

Энэхүү судалгаанд авч үзсэн улс орнуудын дийлэнх буюу Европын 23 оронд хүчингийн хууль зүйн тодорхойлолтыг хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр айлгаж, албадсан гэдэгт үндэслэж гаргасан бөгөөд харилцан зөвшөөрөөгүй гэдгийг үндэс болгоогүй байна. Эдгээр улс оронд Австри, Болгар, Хорват, Чех, Дани, Эстон, Финлянд, Франц, Грек, Унгар, Итали, Латви, Литва, Мальт, Нидерланд, Норвеги, Польш, Португали, Румын, Словак, Словени, Испани, Швейцарь багтаж байна.

2013 оны “Хүчингийн барометр” судалгаанд харилцан зөвшөөрөлд үндэслэсэн хүчингийн тодорхойлолтыг яагаад ашиглахгүй байгаа шалтгаануудыг дурьдсан бөгөөд түүнээс жишээ авахад “харилцан зөвшөөрсөн эсэхийг нотлох хэцүү бөгөөд бодит байдал дээр гомдол гаргагч үнэхээр зөвшөөрөөгүй гэдгээ батлах гэх мэт сэтгэл санааны давхар хохирол амсахад хүрч болзошгүй. Ийм сэтгэл санааны давхар дарамтаас зайлсхийхийн тулд зарим улс орнууд харилцан зөвшөөрөл байсан эсэхэд үндэслэх биш, харин тодорхой нөхцөл байдалд үндэслэсэн хүчингийн тодорхойлолтыг сонгоод байна”<sup>66</sup>.

Дээр дурьдсан орнуудад хэрэглэж буй тодорхойлолтод хүний хүслийг үл харгалзсан бэлгийн хавьтал гэж дурьдсан боловч заавал хүч хэрэглэсэн гэсэн ойлголтыг хамт дагуулж байна. Жишээ нь, Эстонд “нөхцөл байдлыг урвуулан ашиглаж”<sup>67</sup> гэсэн үгийг ашигласан бол, бусад улсад хүч хэрэглэсэн тодорхойлолтод хохирогч “өөрийгөө хамгаалах чадваргүй байх” (Болгар)<sup>68</sup>, “өөрийнхөө хүсэл бодлыг илэрхийлэх боломжгүй байх” (Унгар)<sup>69</sup>, “бэлгийн хавьталд эсэргүүцэл үзүүлэх боломжгүй байх” (Дани)<sup>70</sup> гэх мэт нөхцлүүдийг хамруулсан байна.

### **3.2.1 «ЭНЭ БОЛ ХҮЧИН БИШ»**

Финляндад сургууль, эсвэл боловсролын байгууллагад ажилладаг, өөрийн албан тушаал байр суурийг ашиглан 16-18 настай хүний эсрэг бэлгийн гэмт үйлдлийг эртнээс төлөвлөж, үйлдсэн асуудлыг хүчин биш, харин бэлгийн доромжлол гэж ангилдаг бөгөөд арай хөнгөн ял (торгууль, хамгийн хүнд шийтгэл нь 4 жил хорих) оноож байна<sup>71</sup>. Түүнчлэн, хэрэв хүний өвчин эмгэг, хараат байдлыг ашиглан гэмт үйлдэл эмнэлэг, түүнтэй адилтгах газар болсон бол тус үйлдлийг бэлгийн доромжлол гэж үздэг байв. Финляндын Эмнести Интернэшнл олон жилийн турш зорилтот ухуулга нөлөөллийн ажлыг хийсний үр дүнд зарим нэг асуудалтай хуулийн заалтыг өөрчлүүлж чаджээ. Жишээ нь, хохирогч зөвшөөрсөн эсэхээ илэрхийлэх боломжгүй үед (хөгжлийн бэрхшээлтэй, мансуурсан, эсвэл унтаж байсан) үйлдсэн хэргийг бэлгийн доромжлол биш, харин бэлгийн хүчирхийлэл гэсэн ангилалтай болгохоор 2011 онд өөрчилсөн байна. 2014 онд “хүчингийн хөнгөн хэлбэр”, “бэлгийн хавьталд албадан уруу татах” гэх заалтуудыг устгуулж чаджээ.

Хорватад хүчинг тодорхойлохдоо зөвшөөрөлгүйгээс гадна хүч хэрэглэсэн байх ёстой<sup>72</sup> боловч 2013 онд Эрүүгийн хуулийн зарим зүйл, заалтад өөрчлөлт оруулснаар “харилцан зөвшөөрөлгүй бэлгийн хавьтал” гэсэн бас нэг ангилал гаргаж ирсэн байна. Энэ ангилал нь харилцан зөвшөөрөөгүй бэлгийн хавьтлыг хүчин биш, харин арай хөнгөн гэмт үйлдэл гэж үзэж, хамгийн

<sup>65</sup> [www.theguardian.com/law/2018/sep/26/rape-prosecutions-plummet-crown-prosecution-service-police](http://www.theguardian.com/law/2018/sep/26/rape-prosecutions-plummet-crown-prosecution-service-police).

<sup>66</sup> Европын эмэгтэйчүүдийн лобби бүлэг, “Хүчингийн барометр” 2013 он: [www.womenlobby.org/2013-EWL-Barometer-on-Rape-Report](http://www.womenlobby.org/2013-EWL-Barometer-on-Rape-Report), хуудас 7.

<sup>67</sup> Эрүүгийн хууль (Эстони) 2017 онд шинэчлэн батлагдсан, 141 зүйл: [www.legislationline.org/documents/section/criminal-codes](http://www.legislationline.org/documents/section/criminal-codes)

<sup>68</sup> Эрүүгийн хууль (Болгари) 2015 онд шинэчлэн батлагдсан, 152(1)(1) зүйл: <https://pravatami.bg/zakoni/nakazatelen-kodeksi>.

<sup>69</sup> Эрүүгийн хууль (Унгар), 2012 оны хууль, 197(1)(b) заалт: [www.refworld.org/docid/4c358dd22.html](http://www.refworld.org/docid/4c358dd22.html).

<sup>70</sup> Эрүүгийн хууль (Дани) 2016, Bekendtgørelse af straffeloven: [www.retsinformation.dk/Forms/R0710.aspx?id=192080](http://www.retsinformation.dk/Forms/R0710.aspx?id=192080).

<sup>71</sup> Эрүүгийн хууль (Финлянд) 2015 онд шинэчлэн батлагдсан: [www.legislationline.org/documents/section/criminal-codes/country/32](http://www.legislationline.org/documents/section/criminal-codes/country/32).

<sup>72</sup> Эрүүгийн хууль (Хорват) 2012 онд шинэчлэн батлагдсан: Kazneni zakon [www.wipo.int/wipolex/en/text.jsp?file\\_id=421367](http://www.wipo.int/wipolex/en/text.jsp?file_id=421367).



ихдээ 5 жилийн ял (хүчингийн гэмт хэрэгт 10 жилийн ял) оноож байгаа нь маш их асуудлыг дагуулж байна<sup>73</sup>. Энэ зүйл заалтыг 2015 онд CEDAW-аас шүүмжилсэн<sup>74</sup>. Эмэгтэйчүүдийн эрхийн төлөөх БаБе, Женска Соба буюу “Эмэгтэйчүүдийн өрөө –Бэлгийн эрхийн төлөө төв” төрийн бус байгууллагаас Хороонд ирүүлсэн сүүдэр тайланд энэхүү ангилал нь ямар их хор уршиг дагуулж байгааг 2013 оны хэргийг жишээ болгон харуулжээ. Тайланд дурьдсан хэрэгт насанд хүрээгүй хүнийг бүлэглэн хүчиндсэн үйлдлийг хохирогч ухаангүй, согтууруулах ундаа хэрэглэсэн байсан учраас “харилцан зөвшөөрөөгүй бэлгийн хавьтал” гэж тодорхойлсон байна. Үүнээс үүдсэн олон нийтийн дургүйцэл, бусад байгууллагуудын шахалтын үр дүнд хүчингийн хэрэг гэж ангилсан тухай ТББ-ууд тайландаа мэдээлсэн байна<sup>75</sup>.

Австрид 2016 оны 1 дүгээр сард хүчин төгөлдөр болсон хуулинд үүнтэй адилхан ангиллыг оруулсан байна. Хэдийгээр хүч хэрэглэсэн, айлган сүрдүүлсэн, эрх чөлөөг хязгаарласан гэх мэт хүч хэрэглэсэн нөхцлөөр хүчинг тодорхойлж, 1-10 жилийн ял оноож байгаа боловч, хөнгөрүүлэх нөхцөл<sup>76</sup> байгаа тохиолдолд хамгийн ихдээ 2 жилийн ял оногдуулдаг “хүний хүслийн эсрэг бэлгийн хавьтал” гэсэн зүйл заалтыг ашиглаж байна<sup>77</sup>.

### 3.3 ГЭРЛЭЛТИЙН ТУХАЙ ЗААЛТ

Истанбулын конвенцийн дагуу гишүүн улсууд нь “[бэлгийн хүчирхийллийг яллах тухай 36 дугаар зүйлийн 1 нь] дотоодын хуулиар тогтоосны дагуу одоогийн болон өмнөх гэр бүлийн хүнд ч хамаатай хэрэгжих хууль эрх зүйн болон бусад шаардлагатай зохицуулалтыг”<sup>78</sup> хийхийг шаарддаг.

Данид хэрэв сэжигтэн хохирогчтой гэрлэсэн тохиолдолд, сэжигтэнд арай хөнгөн ял оногдуулах, эсвэл ялыг нь хэрэгсэхгүй болгох заалтыг саяхан буюу 2013 онд хүчингүй болгосон бөгөөд энэ нь Эмнести Интернэшнл гэх мэт олон байгууллагын ухуулга нөлөөллийн ажлын үр дүн юм. Болгарт дээрхтэй ижил зүйл заалтыг (158 дугаар зүйл) саяхан 2015 онд хүчингүй болгосон. 2018 оны 3 дугаар сард Грекийн парламент Истанбулын конвенцийг соёрхон батлах, хэрэгжүүлэхтэй холбоотой үндэсний хууль тогтоомжийг конвенцид нийцүүлэх шийдвэр гаргасан. Эмнести Интернэшнл болон Грекийн 9 төрийн бус байгууллагын хамтарсан ухуулга нөлөөллийн ажлын үр дүнд “тохиролцооны үндсэн дээр гэрлэх” зүйл заалтыг хүчингүй болгожээ<sup>79</sup>. Грекийн эрүүгийн хуулиас хүчингүй болгосон (“насанд хүрээгүй хүнийг уруу татах”, 15 нас хүрээгүй хүүхдэд үйлдсэн “ёс бус үйлдэл”-тэй холбоотой) 339-ийн 3 дугаар заалт нь “Хэрэв хүчирхийлэгч хохирогчтой гэр бүл болсон бол, түүнийг эрүүгийн хэрэгт татахгүй бөгөөд, хэрэв эрүүгийн хэрэг үүссэн бол, шүүхээс хэргийг хэрэгсэхгүй болгосон тухай зарлана”<sup>80</sup> гэж заасан байв.

### 3.4 «НЭР ХҮНД», «ЁС СУРТАХУУНЫ» ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

Олон улсын хүний эрхийн тухай хуульд хүчин болон бусад харилцан зөвшөөрөөгүй бэлгийн үйлдлийг хүний бие болон бэлгийн эрх чөлөөний эсрэг үйлдсэн гэмт хэрэг гэж тодорхойлж яллах<sup>81</sup> бөгөөд ёс суртахуун, олон нийтийн өмнө биеэ авч явах байдал, гэр бүлийн эсвэл нийгмийн нэр

<sup>73</sup> Эрүүгийн хууль (Хорват) 2012 онд шинэчлэн батлагдсан Kazneni zakon 152(1) зүйл.

<sup>74</sup> ЭЯГБХУТК-ийн хороо, Ажиглалтууд, Хорват, 2015 оны 8 сар, CEDAW/C/HRV/CO/4-5, холбоос: [http://tbinternet.ohchr.org/\\_layouts/treatybodyexternal/Download.aspx?symbolno=CEDAW%2fC%2fHRV%2fCO%2f4-5&Lang=en](http://tbinternet.ohchr.org/_layouts/treatybodyexternal/Download.aspx?symbolno=CEDAW%2fC%2fHRV%2fCO%2f4-5&Lang=en), доголдог 18(h).

<sup>75</sup> Хорват: ЭЯГБХУТК-ийн хорооны 61 дүгээр хуралдаанд ирүүлсэн тайлан. Эмэгтэйчүүдийн эрхийн төлөөх БаБе, Эмэгтэйчүүдийн өрөө хэмээх ТББ-уудаас хороонд ирүүлсэн сүүдэр илтгэл: [http://tbinternet.ohchr.org/\\_layouts/treaty-bodyexternal/Download.aspx?symbolno=INT%2fCEDAW%2fNGO%2fCRO%2f20854&Lang=en](http://tbinternet.ohchr.org/_layouts/treaty-bodyexternal/Download.aspx?symbolno=INT%2fCEDAW%2fNGO%2fCRO%2f20854&Lang=en).

<sup>76</sup> Эрүүгийн хууль (Австри) 1974 шинэчлэн батлагдсан 201 зүйл: [www.legislationline.org/documents/section/criminal-codes](http://www.legislationline.org/documents/section/criminal-codes).

<sup>77</sup> Эрүүгийн хууль (Австри) 1974 шинэчлэн батлагдсан 205а зүйл

<sup>78</sup> Истанбулын конвенци 36(3) зүйл.

<sup>79</sup> Грекийн Эмнести Интернэшнл, “10 байгууллага Хууль зүйн сайдтай уулзлаа”, 2018: [www.amnesty.gr/news/articles/article/21284/10-organoseis-kaloynton-ypoyrgo-dikaiosynis-na-katargisei-ti-diataxi](http://www.amnesty.gr/news/articles/article/21284/10-organoseis-kaloynton-ypoyrgo-dikaiosynis-na-katargisei-ti-diataxi); мөн: [www.amnesty.gr/news/articles/article/21309/ellada-sholia-gia-proteinomeno-nomoshedio-gia-tin-epikyrosi-tis-symvasis](http://www.amnesty.gr/news/articles/article/21309/ellada-sholia-gia-proteinomeno-nomoshedio-gia-tin-epikyrosi-tis-symvasis); ээс үз

<sup>80</sup> Истанбулын конвенцид нэгдэн орох тухай хууль, [www.e-nomothesia.gr/law-news/demosieutheke-phek-nomos-4531-2018.html](http://www.e-nomothesia.gr/law-news/demosieutheke-phek-nomos-4531-2018.html).

<sup>81</sup> Истанбулын конвенци, 36(1) зүйл, CEDAW Committee, Ерөнхий зөвлөмж 35, догол догол 33; Вердито Филиппиний эсрэг, CEDAW Communication 18/2008, НҮБ-ын баримт CEDAW/C/46/D/18/2008 (2010), догол догол 8.9(b)(ii); Мөн Жендэрийн эрх тэгш байдал, эмэгтэйчүүдийг хүчирхэгжүүлэхийн төлөө НҮБ-ын албаны Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаарх эрх зүйн гарын авлагыг үз. 2012, хуудас 24; холбоос: [www.unwomen.org/en/digital-library/publications/2012/12/handbook-for-legislation-on-violence-against-women](http://www.unwomen.org/en/digital-library/publications/2012/12/handbook-for-legislation-on-violence-against-women).



хүндийн эсрэг гэмт хэрэг гэж үзэхгүй байхыг заасан байдаг<sup>82</sup>.

Европын хэд хэдэн оронд хүчин болон бэлгийн хүчирхийллийг бусдын “нэр хүнд”-д халдсан, эсвэл “ёс суртахууны” хэрэг гэж үзсэн хэвээрээ байгаа бөгөөд хүний биеийн болон бэлгийн эрх чөлөөнд халдсан гэж үзэхгүй байна. Жишээ нь, Мальтад бэлгийн хүчирхийллийг “Гэр бүлийн тогтвортой байдалд халдсан гэмт хэрэг” гэсэн ангилалд оруулсан байдаг. Гэвч өмнө нь ашигладаг байсан “Гэр бүлийн тайван байдал, нэр хүнд болон ёс суртахууны эсрэг гэмт хэрэг” гэсэн дэд ангиллыг өөрчилж “бэлгийн хүчирхийлэл” гэсэн томъёоллыг оруулжээ<sup>83</sup>. Бельги<sup>84</sup> болон Люксембургд<sup>85</sup> хүчинг “гэр бүлийн тайван байдал, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг” гэж ангилдаг, Нидерландад<sup>86</sup> “нийгмийн ёс суртахууны эсрэг”, харин Польшд<sup>87</sup> (хуулийн зүйл заалт нь “бэлгийн эрх чөлөө” гэсэн нэртэй байгаа боловч) “нэр хүндийн эсрэг” гэмт үйлдэл гэж тодорхойлдог.

2017 оны “Өнөөгийн тэгш эрхийн байдал” тайланд бэлгийн хүчирхийллийг “нэр хүнд”, эсвэл “ёс суртахууны” гэмт хэрэг гэж тодорхойлж байгаа нь:

- Гомдол гаргагчид шударга хандах байдлыг үгүйсгэх эрсдэл;
- Илүү “үнэ цэнэтэй” хохирогч гэх мэт ялгаварлан гадуурхалтын эрсдэлийг үүсгэхээс гадна;
- Эмэгтэйчүүдийн бие, тэдний амьдралыг хянах боломжтой мэт ойлголтыг бүрдүүлэх;
- Гэмт этгээдэд эмэгтэйчүүдийн эсрэг бэлгийн болон бусад төрлийн хүчирхийлэл үйлдээд шийтгүүлэхгүй үлдэж, харин хохирогчийг буруутан болгож болно гэсэн ойлголтыг бүрдүүлэх
- Нийгмийн “ёс суртахууныг” эмэгтэйчүүд авч явдаг юм шиг ойлголтыг бүрдүүлэх зэрэг сөрөг үр дагавартай юм<sup>88</sup>.

<sup>82</sup> НҮБ-ын Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн хууль эрх зүйн орчны тухай гарын авлага, 2012, хуудас 12: [www.un-women.org/en/digital-library/publications/2012/12/handbook-for-legislation-on-violence-against-women](http://www.un-women.org/en/digital-library/publications/2012/12/handbook-for-legislation-on-violence-against-women).

<sup>83</sup> Эрүүгийн хууль (Мальт) 2016: [www.legislationline.org/documents/section/criminal-codes](http://www.legislationline.org/documents/section/criminal-codes).

<sup>84</sup> Эрүүгийн хууль (Бельги), 8 juin 1867: [www.ejustice.just.fgov.be/cgi\\_loi/loi\\_a1.pl?language=fr&caller=list&cn=1867060801&la=f&fromtab=loi&tri=dd+as+rank#LNKR\\_0127](http://www.ejustice.just.fgov.be/cgi_loi/loi_a1.pl?language=fr&caller=list&cn=1867060801&la=f&fromtab=loi&tri=dd+as+rank#LNKR_0127)

<sup>85</sup> Эрүүгийн хууль (Люксембург) Titre VII: [www.legislationline.org/documents/section/criminal-codes](http://www.legislationline.org/documents/section/criminal-codes).

<sup>86</sup> Эрүүгийн хууль (Нидерланд), 1881: [www.legislationline.org/documents/section/criminal-codes](http://www.legislationline.org/documents/section/criminal-codes).

<sup>87</sup> Эрүүгийн хууль (Польш) Kodeks Karny 1997: [www.legislationline.org/documents/section/criminal-codes/country/10](http://www.legislationline.org/documents/section/criminal-codes/country/10).

<sup>88</sup> Өнөөгийн тэгш байдал, “Дэлхий ичиж байна. Дэлхийн хүчингийн гэмт хэргийн тархалт. Хуулийн хүрээнд эмэгтэйчүүд, охидыг бэлгийн хүчирхийллээс хамгаалж чадахгүй байна”, 2017 он, хуудас 22.

# 4. ШҮҮХЭД ХАНДАХАД ТУЛГАРЧ БҮЙ БЭРХШЭЭЛ. БОДИТ БАЙДАЛ

## 4.1 МӨРДӨН ШАЛГАХ АЖЛЫН ЧАНАР

Олон улсын хууль, хэм хэмжээний дагуу хууль сахиулах байгууллагынхан бүх төрлийн хүчирхийллийн хэргийг даруй шалган, зүй ёсоор нь шийдвэрлэх<sup>89</sup>, бүх төрлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хамгаалах ажиллагааг зохион байгуулах<sup>90</sup> үүргийг улс орнууд хүлээдэг. Цагдаагийн байгууллагаас мөрдөн шалгах үйл ажиллагааг чанартай явуулж буй эсэх нь хүчингийн хохирогчдод тулгардаг хамгийн том саад бэрхшээл юм. Норвегийн Нийтийн прокурорын газраас 2016 онд 275 хүчингийн хэргийг хамруулсан үндэсний хэмжээний судалгааг хийсэн бөгөөд судалгааны үр дүнд **цагдаагийн мөрдөн шалгах үйл ажиллагаанд гарсан алдаа дутагдал нь хүчингийн хэргийг шалган шийдвэрлэхэд гарч буй хамгийн том бэрхшээл болох нь тогтоогджээ**. Мөрдөн шалгах үйл ажиллагааны хамгийн эхний үе буюу нотлох баримтуудыг цуглуулах шатанд хамгийн их алдаа гардаг болохыг судалгааны тайланд тэмдэглэжээ. Судалгаанд хамрагдсан хэргийн 20 хувьд гар утасны холбогдох баримтуудыг цуглуулаагүй, 21 хувьд нь хэрэг гарсан газрын зургийг аваагүй, 20 хувьд нь нэмэлт гэрчүүдийн мэдүүлгийг авах хэрэгтэй байсныг хийгээгүй байна. Түүнчлэн, албадлагын шинжтэй нөхцөл байсан эсэхийг ихэнхдээ шалгаагүй орхидог бөгөөд бодит байдал дээр нийт хэргийн 63 хувьд нь ийм нөхцөл<sup>91</sup> агуулагдаж байдаг.

## 4.2 ШҮҮН ТАСЛАХ АЖИЛЛАГААНЫ ЯВЦАД ЗАРЦУУЛАХ ЦАГ ХУГАЦАА

Истанбулын конвенцийн дагуу “энэхүү конвенцийн агуулгын хүрээнд тодорхойлсон хүчирхийллийн бүх төрлийн гэмт хэргийг мөрдөн шалгах, шүүн таслах үйл ажиллагаа нь **шаардлагагүй урт хугацааг** хамруулахгүй байх, эрүүгийн шүүхийн бүхий л үйл явцад хохирогчийн эрхийг хүндэтгэх шаардлагатай”<sup>92</sup> гэж заасан байдаг. П. М. Болгарын эсрэг хэмээх хэрэгт насанд хүрээгүй охин хүчиндүүлсэн асуудлыг мөрдөн шалгахад 15 жил зарцуулсан бөгөөд Европын хүний эрхийн конвенцийн 3 дугаар зүйл буюу хүнлэг бус, гутаан доромжилсон хандлагыг хориглосон заалтыг зөрчсөн болохыг Европын хүний эрхийн шүүхээс<sup>93</sup> тогтоожээ.

Эмнести Интернэшнлийн салбарууд энэхүү судалгааг хийхдээ бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогчидтой тулж ажилладаг Англи, Ирланд, Умард Ирланд, Нидерландын зөвлөхүүдтэй ярилцлага хийсэн бөгөөд тэдний хэлж байгаагаар шүүн шийдвэрлэх үйл ажиллагаа маш их цаг авдаг нь (Ирланд болон Англид дунджаар 2 жилийн дараа шийдвэрлэгддэг бол Умард Ирландад нэг жил хагас болдог байна) хохирогчдод маш их дарамт учруулдаг байна<sup>94</sup>. Хохирогчид шүүн шийдвэрлэх үйл ажиллагаа маш их цаг авдаг гэдгийг мэддэг учраас олон жилийн турш тодорхойгүй байдалд байж, сэтгэл санаагаар дахин хохирч байснаас шүүхэд гомдол мэдүүлэхгүй байх замыг сонгодог байна. Сэтгэлийн шархаа эдгээж, амьдралаа цааш авч явахын хажуугаар (хэрэв азтай байгаад шүүх хурал болох юм бол) шүүх дээр ганц өдөр хэлэлцүүлэхийн тулд хэдэн жилийн турш өөрт тохиолдсон бараан явдлын хором болгоныг санаж явах нь хохирогчдод тохиолддог нэлээн том бэрхшээлийн нэг юм.

<sup>89</sup> НҮБ-ын Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн хууль эрх зүйн орчны тухай гарын авлага, 2012, хуудас 34-36;

Истанбулын конвенци, 50(2) зүйл; ЭЭЯГЗХ-ны Ерөнхий зөвлөмж 35, догол догол 38 (b)

<sup>90</sup> Истанбулын конвенци, 50(2) зүйл; ЭЭЯГУХ-ны Ерөнхий зөвлөмж 35, доголдогол 38 (b)

<sup>91</sup> Мөн Эмнести Интернэшнлийн НҮБ-ын Эмэгтэйчүүдийн эсрэг ялгаварлан гадуурхалтыг устгах хороонд өгсөн тайланг үз., 2017 оны 10 дугаар сар, хуудас 5, [www.amnesty.org/en/documents/eur36/7102/2017/en/](http://www.amnesty.org/en/documents/eur36/7102/2017/en/).

<sup>92</sup> Истанбулын конвенци, 49(1) зүйл.

<sup>93</sup> П.М. Болгарын эсрэг, No. 49669/07, ECHR 028 (2012), 2012 оны 1 сарын 24.

<sup>94</sup> Эмнести Интернэшнлтэй хийсэн ярилцлага, 2017 оны 5-аас 9 сарын хооронд Англи, Ирланд, Умард Ирланд, Нидерландад хийсэн ярилцлага

### 4.3 ШҮҮН ТАСЛАХ АЖИЛЛАГААНЫ ЯВЦ ДАХ ХОХИРОГЧИЙН ХАМГААЛАЛ

НҮБ-ын эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн эрх зүйн гарын авлагад<sup>95</sup> бэлгийн хүчирхийлэлтэй холбоотой шүүн шалгах үйл явцад хохирогчийг хэрхэн хамгаалах талаар чухал зөвлөмжүүдийг өгсөн байдаг. Үүнд жишээ нь, ялангуяа эрүүгийн шүүхийн үйл явцад үнэгүй хууль зүйн туслалцаа үзүүлэх; хохирогчид үйлчилгээ үзүүлэх чиглэлээр мэргэшсэн хүмүүсийг шүүн таслах хуралд хохирогчтой хамт оролцуулах, түүнчлэн шүүх дээр мэдүүлэг өгөх гэж ирэхдээ хариуцагчтай нүүр тулж уулзахгүй байх арга хэмжээг авч, видео бичлэгээр мэдүүлгээ өгөх боломж зэргийг хангах<sup>96</sup> хэрэгтэй юм. Хохирогчийн өмнөх бэлгийн амьдралын баримт нотолгоог эрүүгийн, эсвэл иргэний шүүхийн хуралд хэзээ ч дэлгэж болохгүй гэж гарын авлагад зөвлөсөн байна<sup>97</sup>.

Хэдийгээр энэхүү судалгааны хүрээнд бүсийн улс болгонд дээр дурьдсан асуудал хэрэгжиж буй эсэхийг судлах боломжгүй байсан ч, ярилцлагын үед олж авсан зарим мэдээллийг хуваалцах нь чухал болов уу. Жишээ нь, Ирланд ба Умард Ирландад улсаас зардлынхаа талыг гаргуулдаг хүчингийн гэмт хэргийн дараах хоргодох байр, эсвэл хохирогчийг дэмжих төвийн ажилтнууд хохирогчийг дагаж цагдаа, шүүхийн байгууллага дээр очдог ба шүүх хурал яаж явагдах талаар мэдээлэл өгдөг байна.

Умард Ирландын судалгаанд оролцогчид Англид хэрэгждэг туршлагыг сайн жишээ болгон ярьж байлаа. 2017 оны 4 дүгээр сарын хуулийн өөрчлөлтийн дагуу хэрэв хэргийн талаар тайлагнахад цаг их орсон, эсвэл биеэр болон үг хэлээр эсэргүүцэл үзүүлээгүй байх юм бол хүчингийн талаар буруу ойлголт, урьдчилсан таамаглал байгаа эсэхийг дахин шалгуулах заавар өгөх үүргийг шүүгчид өгсөн байна<sup>98</sup>. Эмнести Интернэшнлийн “Хэрэг хаагдлаа” тайланд авч үзсэн Скандинавын орнуудад (Дани, Финлянд, Норвеги, Швед) хохирогч үнэгүй зөвлөгөө авах эрхтэй<sup>99</sup> бөгөөд Нидерландад<sup>100</sup> ч гэсэн ийм байна.<sup>101</sup>

#### И. Словенийн эсрэг: Эмэгтэйчүүдийг хамгаалахын тулд байцаалтыг хязгаарлах арга

2010 онд Европын хүний эрхийн шүүхэд нэгэн эмэгтэй Словений эсрэг хандаж, түүний эсрэг үйлдэгдсэн бэлгийн гэмт хэргийг шийдвэрлэх шүүн таслах үйл ажиллагаа ямар ч шалтгаангүй хойшлогдож, шударга байдлыг дорд үзсэн таагүй үр дүнд хүргэсэн талаар<sup>102</sup> гомдол мэдүүлсэн байна.

Тухайн эмэгтэй Украйнд төрсөн боловч 2000 оноос хойш Словенид амьдарч байгаа бөгөөд түүнийг 14 настай байхад гэрийнхэнтэй нь нөхөрлөдөг нэгэн эрэгтэй 2001 оны 7 дугаар сараас 12 дугаар сарын хооронд удаа дараа бэлгийн хавьталд хүчээр оруулсан гэж шүүхэд гомдол гаргажээ. Түүний ээж анх гомдол гаргасан бөгөөд охин 2002 оны 7 дугаар сард цагдаад анхны мэдүүлгийг өгсөн байна. Мөрдөн шалгах үйл ажиллагаанд ахиц гарсан эсэх талаар ямар ч мэдээлэл цагдаагаас өгөөгүй болохоор ээж нь Улсын прокурорын газарт гомдол мэдүүлснийг 2003 оны 8 дугаар сард шалгах шийдвэр гарсан байна. 2006 оны 9 сард Марибор дүүргийн прокурорын газар 15 нас хүрээгүй хүүхдэд бэлгийн хүчирхийлэл үйлдсэн үндэслэлээр хариуцагч эрэгтэйг баривчилсан байна. Шүүх хурал бараг 2 жил үргэлжилжээ. Эмэгтэйн мэдүүлэгтэй зөрж байсан шүүх эмнэлгийн дүгнэлтэд үндэслэн шүүх хариуцагчид туслах шаардлага хангасан бүх баримтыг авч үзэх (in dubio pro reo) байр сууриар ажиллаж, эрэгтэйн хэргийг хэрэгсэхгүй болгожээ.

Европын хүний эрхийн шүүх эрэгтэйн буруутай эсэхэд дүгнэлт өгөөгүй боловч, тус улсын засаг захиргаа нь хохирогч эмэгтэйд шаардлагатай хамгаалалтыг үзүүлээгүй бөгөөд Европын хүний эрхийн конвенцийн 8 дугаар зүйлийг зөрчсөн гэж тогтоожээ. Шүүх тус улсын засаг захиргаа хохирогчид давхар сэтгэл санааны

<sup>95</sup> Эмнести Интернэшнлтэй хийсэн ярилцлага, Белфаст, 2017 оны 7 сарын 20.

<sup>96</sup> НҮБ-ын Эдийн засаг нийгмийн асуудлаарх байгууллага, Эмэгтэйчүүдийн дэвшүүлэх “Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаарх эрх зүйн гарын авлага” ST/ESA/329, 2009

<sup>97</sup> НҮБ-ын Эдийн засаг нийгмийн асуудлаарх байгууллага, Эмэгтэйчүүдийн дэвшүүлэх “Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаарх эрх зүйн гарын авлага” ST/ESA/329, 2009, р 40.

<sup>98</sup> НҮБ-ын Эдийн засаг нийгмийн асуудлаарх байгууллага, Эмэгтэйчүүдийн дэвшүүлэх “Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаарх эрх зүйн гарын авлага” ST/ESA/329, 2009, р 43

<sup>99</sup> Эмнести Интернэшнлтэй хийсэн ярилцлага, Белфаст, 2017 оны 7 сарын 21. Шотландын хуулийг харна уу [www.legislation.gov.uk/asp/2016/22/part/2/chapter/1/enacted](http://www.legislation.gov.uk/asp/2016/22/part/2/chapter/1/enacted). Шотландын кампанит ажлын талаар: [www.bbc.co.uk/news/uk-scotland-scotland-politics-39182779](http://www.bbc.co.uk/news/uk-scotland-scotland-politics-39182779).

<sup>100</sup> Эмнести Интернэшнл, “Хэргийг хаалаа. Скандинавын орнуудын хүчин, хүний эрхийн байдал. Товч тайлан” 2010 он: [www.amnesty.org/en/documents/ACT77/001/2010/en/](http://www.amnesty.org/en/documents/ACT77/001/2010/en/) хуудас 17.

<sup>101</sup> Эмнести Интернэшнлтэй хийсэн ярилцлага, Амстердам, 2017 оны 7 сарын 23; Эмнести Интернэшнлтэй хийсэн ярилцлага, Утрехт, 2017 оны 5 сарын 24

<sup>102</sup> Й. Словений эсрэг, No. 41107/10, 2015 оны 5 сарын 28.

дарамт эдлүүлэхээс хамгаалж, шүүх танхимд олон нийтийг оролцуулаагүй, түүнийг мэдүүлэг өгч байхад хариуцагчийг байлцуулаагүй гэх мэт арга хэмжээнүүдийг авсныг тэмдэглэсэн байна. Гэвч эдгээр арга хэмжээ нь түүнийг бүрэн хамгаалахад хангалтгүй байв. Шүүхийн үзэж байгаагаар хохирогч эмэгтэйн мэдүүлгийг 4 удаагийн хуралдаанаар сонсож, эдгээр хуралдаан нь хэдэн сарын турш үргэлжилсэн нь асуудал үүсгэж байна. Түүнчлэн, 2 удаагийн хуралдаанд хариуцагч эрэгтэй өөрөө хохирогчоос байцаалт авах боломж бүрдсэн байна. Тэдгээрийн нэгэнд хариуцагч эрэгтэй хохирогчоос бараг 100 орчим асуулт асуусан байгаа бөгөөд эмэгтэй худлаа уйлж чаддаг, эмэгтэй түүнтэй хамт байхыг илтэд хүсдэг байсан, эмэгтэй эрэгтэйчүүдтэй бэлгийн харилцаанд орохдоо давамгайлах сонирхолтой гэж ярьсан гэдгээ хүлээн зөвшөөрөхийг шаардсан байна. Мөн хариуцагч эрэгтэй хүчингийн гомдлыг бүсгүйн ээж зохиож гаргасан гэж мэдэгдээд түүнээс Словенийн талаар хэр сайн мэддэг, хүмүүс хоорондын харилцаа ямар байдгийг мэддэг эсэх талаар асуусан байна. Түүнчлэн, эмэгтэй маш их бухимдаж, уйлснаас болоод шүүх гурван ч удаа завсарлага авсан байна. Нэг ийм завсарлагын дараа хариуцагч эрэгтэй өмнөх шигээ бүгдээрээ хамтдаа оройн хоолонд орвол эмэгтэйн сэтгэл санаа арай дээрдэж, тэр ингэж их уйлахгүй байх болов уу гэж асуужээ<sup>103</sup>. Шүүх хэргийг шийдэхдээ хэдийгээр өмгөөлөх зорилгоор эмэгтэйн мэдүүлэгт гарсан зарим нэг асуудлыг хөндөх, түүний үнэн шударга байдалд тодорхой хэмжээгээр эргэлзэж болох ч, хохирогчийг айлгах, доромжлох зорилгоор харилцан байцаалтыг явуулж болохгүй. Шүүх “хохирогч худлаа уйлж хүмүүсийг өөрийн талд оруулдаг, түүний сэтгэл санааны хямрал хариуцагчтай хамт оройн хоолонд орсноор дээрдэнэ, эрэгтэйчүүдтэй бэлгийн хавьталд орохдоо давамгайлах үүрэгтэй орох хүсэлтэй гэж ярьсан гэх мэт ямар нэгэн баримт нотолгоогүй асуулт, дүгнэлт нь хохирогчийн үнэн ярьж байгаа эсэхэд төдийгүй түүний зан чанарт эргэлзээ үүсгэх зорилготой байжээ” гэсэн байна. Түүнчлэн, шүүх дүгнэхдээ “хариуцагч өөрийгөө өмгөөлөх хязгаарыг давсан гүтгэлэг, доромжлолыг хохирогчид хандан хэлсэн байгаа бөгөөд хариуцагч эрэгтэйд ийм өргөн хүрээний эрх мэдэл олгосон нь хохирогч эмэгтэгийн хувьд маш дарамттай явдал болжээ” гэсэн байна<sup>104</sup>. Шүүхээс хохирогч анх гомдол мэдүүлсэн өдрөөс шүүхийн шийдвэр гарах хүртэл яагаад 7 жил өнгөрсөн талаар тоймтой баримт, тайлбар олоогүй бөгөөд ийм хожимдол нь шуурхай шийдвэрлэх зарчимтай нийцэхгүй байгааг харгалзан, хариуцагч улс ковенцийн (хүнлэг бус, доорд үзэх хандлагыг хориглох тухай) 3 дугаар зүйлийн хүрээнд хүлээсэн үүргээ зөрчсөн гэж үзсэн байна.

#### 4.4 ЦАГДАА, ПРОКУРОР, ШҮҮГЧ, АНХНЫ ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭГЧДИЙН СУРГАЛТ

Хүчирхийллийн бүх төрлийн хэлбэрээс урьдчилан сэргийлэх, хамгаалахын тулд ийм төрлийн гэмт хэргийн хохирогч, хариуцагч нартай ажиллаж буй холбогдох мэргэжилтнүүдэд ийм төрлийн гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх, хэрэг гарсныг олж тогтоох, зөв шат дамжлагын дагуу шийдэх, жендэрийн тэгш байдал ба ялгаварлан гадуурхалт, хохирогчийг давхар сэтгэл санааны дарамтад оруулахгүй байх үүднээс тэдний эрх, хэрэгцээ шаардлага юу байх талаар сургалтад хамруулах ёстой<sup>105</sup>.

Энэхүү судалгаанд оролцсон мэргэжилтнүүд болон шинжээчид бүгд санал нэгтэй байсан санал нь шүүх цагдаагийн ажилтнууд, прокурор болон шүүгчид, ирээдүйд хуулийн мэргэжилтэн болох хуулийн оюутнуудыг байнга сургалтад хамруулж, мэдлэг ойлголтыг нь нэмэгдүүлэх нь эмэгтэйчүүд хүчирхийллийн асуудлыг шийдүүлэхээр шүүх цагдаад хандах тохиолдлыг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой гэсэн юм. Бэлгийн халдлагаар мэргэшсэн 800 гаруй мөрдөн байцаагчтай Нидерландад ч гэсэн цагдаагийн ажилтнуудыг сургалтад хамруулахад байдал сайжрах тухай хуульчид<sup>106</sup> нь ярьж байна. Хамгийн анхны туслалцаа, үйлчилгээ үзүүлдэг хүмүүс (жишээ нь, эмч, сувилагч болон бусад эмнэлгийн ажилтнууд) бас сургалтад хамрагдах ёстой<sup>107</sup> гэсэн санал бас гарч байсан.

Судалгаанд оролцогчид цагдаагийн байгууллагад анх гомдол гаргаснаас хойш мэдээлэл авч чаддаггүй талаар санал их гаргасан. Хохирогчид урт удаан хугацааны туршид тэдний асуудал ямар шатанд явж байгаа талаар, цаашдаа яах талаар мэдээлэл бараг авдаггүй бөгөөд өгсөн мэдээлэл нь ойлгомжгүй<sup>108</sup> байдаг байна. Цагдаагийн байгууллагаас хэргийн талаархи бүх мэдээллийн хуулбарыг өгч, тэдний хэрэг шийдэгдэхэд хэр их цаг хугацаа орох талаар мэдээлэл өгч байвал энэ байдал сайжирна гэж ихэнх хохирогч үзэж байна<sup>109</sup>.

<sup>103</sup> Й Словений эсрэг, No. 41107/10, 2015 оны 5 сарын 28, догол догол 34-37.

<sup>104</sup> Й Словений эсрэг, No. 41107/10, 2015 оны 5 сарын 28, догол догол 108

<sup>105</sup> Истанбулын конвенци, 15(1) зүйл; ЭЯГУХ-ны, Ерөнхий зөвлөмж 35, догол 38 (b).

<sup>106</sup> Эмнести Интернэшнлтэй хийсэн ярилцлага, Амстердам, 2017 оны 5 сарын 23, Эмнести Интернэшнлтэй хийсэн ярилцлага, Утрехт, 2017 оны 5 сарын 24.

<sup>107</sup> Эмнести Интернэшнлтэй хийсэн ярилцлага, Нидерланд, Ирланд 2017 оны 5-7 сар .

<sup>108</sup> Эмнести Интернэшнлтэй хийсэн ярилцлага, Ирланд, Умард Ирланд, Англи ба Уэльс 2017 оны 7-9 сар..

<sup>109</sup> Эмнести Интернэшнлтэй хийсэн ярилцлага, Белфаст, 2017 оны 7 сарын 21

2016 онд Кипрт болсон хэрэг хууль эрх зүйн орчин нь хүний эрхийн хэм хэмжээнд нийцсэн, хүчинг зөвшөөрөл дээр үндэслэж тодорхойлдог боловч хохирогч шүүхээр шударгаар шийдүүлэх боломжоор хязгаарлагдаж болохыг харуулсан жишээ юм. Уг хэрэгт 2 эрэгтэй нэг эмэгтэйг бүлэглэн хүчиндсэн байна. Киприйн Дээд шүүх тэдний ялын хэмжээг 12 жилээс 10 жил болгож бууруулсан бөгөөд бусад харгалзан үзэх хүчин зүйлүүдийн дотор хохирогчид хүч хэрэглэсэн баримт олоогүйг үндэслэл болгожээ. Шүүгчийн хэлсэн үгийг англи хэл рүү орчуулж үзэхэд “айлгах, нэг удаа алгадахаас өөрөөр хохирогчид хүч хэрэглээгүй байна”<sup>110</sup> гэжээ. Энэ шийдвэр нь олон нийтийн дургүйцлийг хүргэж, эсэргүүцлийн жагсаал хийхэд хүргэж байв.

## 4.5 ХОХИРОГЧИД ҮЗҮҮЛЭХ ДЭМЖЛЭГ

Олон улсын хүний эрхийн хуулийн дагуу төр засаг нь хохирогчийг эрүүл мэндийн болон сэтгэл зүйн хувьд сэргээн эдгэрэхэд дэмжлэг үзүүлэх гэх мэт үр дүнтэй шийдлийг хэрэгжүүлэх үүргийг хүлээдэг<sup>111</sup>. Истанбулын конвенцийн дагуу хүчирхийллийн үр дүнг арилгах арга хэмжээг<sup>112</sup> төрөөс авах ёстой бөгөөд үүнд хүчингийн дараах хоргодох байр<sup>113</sup> гэх мэт дэмжлэгт үйлчилгээг бий болгох зэрэг багтана. Хүрэлцээний хувьд Европын зөвлөлийн Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх ажлын хэсгийн 2008 оны ажлын тайланд 200,000 эмэгтэй тутамд 1 хорогдох байр, 50,000 эмэгтэй тутамд нэг зөвлөгөө өгөх төв байх нь тохиромжтой гэж зөвлөсөн бөгөөд төв хоорондын зайг хүн ам зүйн тоонд тохируулан байршуулах нь зүйтэй гэжээ. Мөн ийм төвүүд нь бүх эмэгтэйчүүдэд ямар нэгэн гарал угсаа, хууль эрх зүйн болон эдийн засгийн байдлаар ялгалгүй үйлчилгээ үзүүлэх хэрэгтэй гэж тэмдэглэсэн байна<sup>114</sup>.

Хэдийгээр энэ судалгааны хүрээнд Европын улс орнуудад хохирогчдод үзүүлэх өргөн хүрээний үйлчилгээний хэрэгжилт ямар байгааг үнэлэх ажил багтаагүй боловч, судалгаанд оролцогчдын өгсөн зарим мэдээллийг хуваалцах нь зүйтэй болов уу. Уламжлалт хууль эрх зүйн орчинтой орнуудад дэмжлэг туслалцаа үзүүлэх төвүүдийг 1970-аад онд эмэгтэйчүүдийн эрхийн төлөөх байгууллагын хүчтэй тэмцлийн үр дүнд байгуулж эхэлсэн байна. Тэдний үйл ажиллагааны санхүүжилтийн талыг төр даадаг бөгөөд бусад санхүүжилтийг олон нийтийн хандиваар бүрдүүлдэг байна. Төвүүдийн зарим нь зардлаа хэт танах байдлаар үйл ажиллагаа явуулж байгаа бол заримынх нь төсөв хасагдсан байдалтай байна. Эдгээр төвүүдийн үйл ажиллагаа хэзээ ч төрөөс анхаарал хандуулах тэргүүлэх чиглэлд багтдаггүй учраас санхүүжилт нь байнга хасагддаг<sup>115</sup>. Судалгаанд оролцогчдын мэдээлснээр эдгээр төвүүдийн хэрэгцээ тэдний үзүүлж чадах тусламжаас байнга давдаг<sup>116</sup> бөгөөд хувь хүмүүсийн өгөх хандивийн төлөө нэг нэгэнтэйгээ өрсөлдөх хэрэг гардаг нь шүүмжлэл дагуулж<sup>117</sup> байлаа. Эмнести Интернэшнлээс 2008 онд гаргасан “Хэрэг хаагдлаа” тайланд Скандинавын орнуудад, ялангуяа Финляндад хохирогчдод үзүүлэх үйлчилгээ ямар байгаа талаар нэлээд шүүмжлэлтэй хандсан байна<sup>118</sup>.

<sup>110</sup> Cyprus Mail Online, Хүчингийн ялыг бууруулсны эсрэг жагсаал, 2016 оны 7 сарын 18, холбоос: [www.cyprus-mail.com/2016/07/18/protest-rape-sentence-reduction/](http://www.cyprus-mail.com/2016/07/18/protest-rape-sentence-reduction/).

<sup>111</sup> ЭЯГУТХ-ны, Ерөнхий зөвлөмж 35, НҮБ-ын баримт. CEDAW/C/CG/35, 2017, догол 23, 24 (b), 26 (a), (b), 43, 46, 47

<sup>112</sup> Истанбулын конвенци, 20 зүйл. Ерөнхий зөвлөмж. 35 эмэгтэйчүүдийн эсрэг жендэрт суурилсан хүчирхийлэл, шинэчилсэн ерөнхий зөвлөмж 19, НҮБ-ын баримт. CEDAW/C/CG/35, 2017, догол 40 (c). НҮБ-ын жендэрийн эрх тэгш байдал, эмэгтэйчүүдийг хүчирхэгжүүлэхийн төлөө байгууллагын Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн эрх зүйн гарын авлага; 2012, хуудас 29, холбоос: [www.unwomen.org/en/digital-library/publications/2012/12/handbook-for-legislation-on-violence-against-women](http://www.unwomen.org/en/digital-library/publications/2012/12/handbook-for-legislation-on-violence-against-women). догол .

<sup>113</sup> Истанбулын конвенци, 25 зүйл. Ерөнхий зөвлөмж. 35 эмэгтэйн эсрэг жендэрт суурилсан хүчирхийлэл, шинэчилсэн ерөнхий зөвлөмж 19, НҮБ-ын баримт. CEDAW/C/CG/35, 2017, догол 40 (c). НҮБ-ын жендэрийн эрх тэгш байдал, эмэгтэйчүүдийг хүчирхэгжүүлэхийн төлөө байгууллагын Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн эрх зүйн гарын авлага ; 2012, хуудас 30. догол

<sup>114</sup> Европын зөвлөлийн Эмэгтэйчүүдийн эсрэг, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх комисс (EG-TFV), “Үйл ажиллагааны эцсийн тайлан” 2008, р 84, холбоос: [www.coe.int/t/dg2/equality/domesticviolencecampaign/Source/Final\\_Activity\\_Report.pdf](http://www.coe.int/t/dg2/equality/domesticviolencecampaign/Source/Final_Activity_Report.pdf) догол

<sup>115</sup> Эмнести Интернэшнлтэй хийсэн ярилцлага, Лондон, 2017 оны 9 сарын 6. Мөн: [www.drcc.ie/wp-content/uploads/2011/03/DRCC-UNCAT-Submission-final-July-2017.pdf](http://www.drcc.ie/wp-content/uploads/2011/03/DRCC-UNCAT-Submission-final-July-2017.pdf), хуудас 6. pdf

<sup>116</sup> Эмнести Интернэшнлтэй хийсэн ярилцлага, Лондон, 2017 оны 9 сарын 6; Эмнести Интернэшнлтэй хийсэн ярилцлага, Умард Ирланд, 2017 оны 7 сар

<sup>117</sup> Эмнести Интернэшнлтэй хийсэн ярилцлага, Лондон, 2017 оны 9 сарын 6;

<sup>118</sup> Эмнести Интернэшнл, “Хэрэг хаагдлаа. Скандинавын орнуудын хүчин, хүний эрхийн байдал. Товч тайлан” 2010 он. хуудас 21.

## 4.6 БЭЛГИЙН ХАРИЛЦАА, БЭЛГИЙН АМЬДРАЛЫН БОЛОВСРОЛ

Хүчинг дэмжсэн соёлыг устгаж, хүчин болон бэлгийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд бэлгийн харилцаа болон бэлгийн амьдралын цогц боловсрол, мэдлэг ойлголтыг (тухайлбал харилцан зөвшөөрөл, биеийн өгүүлэмж, бэлгийн бие даасан байдал гэх мэт) түгээх нь хамгийн чухал юм. НҮБ-ын Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн хууль эрх зүйн гарын авлагад боловсролын тогтолцоо нь “жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй холбоотой ялгаварлан гадуурхсан хандлагыг халахад хамгийн үр дүнтэй гарц” болох<sup>119</sup> талаар тэмдэглэсэн байна. Истанбулын конвенцийн дагуу улс орнууд “эрэгтэй эмэгтэй хүмүүсийн тэгш эрх, жендэрийн талаарх шинэлэг ойлголт, харилцан хүндлэл, хувь хүмүүсийн харилцаанд хүчирхийллээс бусад арга замаар маргааныг шийдвэрлэх, эмэгтэйчүүдийн эсрэг жендэрт суурилсан хүчирхийлэл, хувь хүний халдашгүй байдал гэх мэт асуудлыг тусгасан, суралцагчийн мэдлэг чадвар нэмэгдэх хэрээр өөрчлөх боломжтой хөтөлбөр, гарын авлагыг албан болон бүх түвшний боловсролын тогтолцоонд нэвтрүүлэх үүрэгтэй”<sup>120</sup>. Ийм боловсролыг олгох багш, мэргэжилтнүүдийг цогц сургалтад хамруулах нь бүр ч чухал юм. Бүсийн зарим улс орнуудын боловсролын тогтолцоонд ийм сургалтанд ач холбогдол өгөөгүйгээс болж, сургалт нь тасалдах, төрийн бус байгууллагууд, хувийн заримдаа шашны байгууллагуудаар хичээлийг заалгах гэх мэт тохиолдол гарч байна. Хэдийгээр бэлгийн боловсрол албан хөтөлбөрт орсон ч гэсэн, харилцан зөвшөөрлийн талаар орхигдуулсан (жишээ нь, Дани болон Нидерландад<sup>121</sup>) байгаа бөгөөд хөтөлбөрийн үргэлжлэх хугацаа, хичээл орж байгаа байдал зэргийг сайжруулах хэрэгцээ байсаар байна. Жишээ нь, сүүлийн үеийн судалгаанаас харахад Норвегийн 17-19 насны хүүхдүүдийн 42 хувь нь л бэлгийн боловсролын хичээлээр биеийн өгүүлэмжийн тухай, хүчин болон бэлгийн хүчирхийллийн талаар мэдээлэл авсан гэж хариулсан байна<sup>122</sup>.

Зарим оронд бэлгийн болон бэлгийн харилцааны тухай хичээлийн чанар, агуулгад тухайн сургуулийн шашны үзэл баримтлалын нөлөө (Ирланд, Умард Ирланд) их орсон байгаа бөгөөд дээр дурьдсанчлан шашны байгууллагаар хичээлийг заалгах, эсвэл тухайн улсад баримталж буй шашны үзэл баримтлалаас (тухайлбал Польшид залуучуудад “Гэр бүлийн амьдралын бэлтгэл” гэдэг хичээл ордог) болж ихээхэн өөр байна.

## 4.7 ЖЕНДЭРИЙН ХЭВШМЭЛ ОЙЛГОЛТЫН СӨРӨГ ҮР ДАГАВАР

Олон улсын хүний эрхийн хуулийн дагуу улс орнууд жендэрт суурилсан хэвшмэл, хуучинсаг ойлголтууд, эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах хандлагыг устгах үүрэгтэй бөгөөд ингэснээр жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх үр дүнтэй арга зам болох юм.

### ***Истанбулын конвенцийн 12(1) дүгээр зүйлд гишүүн орнууд нь:***

... эмэгтэйчүүд нийгэмд хоёрдагч үүрэгтэй, эсвэл эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн гүйцэтгэх үүргийн талаар хуучинсаг ойлголтод үндэслэсэн гадуурхал, зан заншил, уламжлал зэргийг халах зорилгоор нийгэм соёлын амьдралд өөрчлөлт хийх, дэмжих, шаардлагатай арга хэмжээг авах үүрэгтэй гэж заасан байна<sup>123</sup>.

### ***НҮБ-ын Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн дагуу, төр засаг нь:***

... аль нэг хүйсийг дорд, эсхүл дээрд үзэх, эсхүл эрэгтэй, эмэгтэйчүүдийн үүргийн талаархи хэвшсэн үзэлд тулгуурласан хохиролтой үйл ажиллагаа, заншил болон бусад бүх дадлыг устгах зорилгоор эрэгтэй, эмэгтэйчүүдийн зан төлөвийн нийгэм, соёлын хэв шинжийг

<sup>119</sup> НҮБ-ын эдийн засаг\_нийгмийн хэрэг эрхлэх газар, Эмэгтэйчүүдийг дэмжих салбар, “Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаарх эрх зүйн гарын авлага” ST/ESA/329, 2009, хуудас 30.

<sup>120</sup> Истанбулын конвенци, 14(1) зүйл.

<sup>121</sup> Данийн Эмнести Интернэшнлтэй хийсэн зөвлөгөөн; Эмнести Интернэшнлтэй хийсэн утасны ярилцлага, 2017 оны 8 дугаар сарын 30.

<sup>122</sup> [www.nrk.no/norge/unge-misfornoyde-med-seksualundervisninga\\_-\\_-laerer-ikke-om-voldtekt-pa-skolen-1.13503309](http://www.nrk.no/norge/unge-misfornoyde-med-seksualundervisninga_-_-laerer-ikke-om-voldtekt-pa-skolen-1.13503309).

Эмнести Интернэшнлийн НҮБ-ын Эмэгтэйчүүдийн эсрэг ялгаварлан гадуурхалтыг зогсоох тухай хороонд өгсөн тайланг үз ц, 2017 оны 10дугаар сар, хуудас 5, [www.amnesty.org/en/documents/eur36/7102/2017/en/](http://www.amnesty.org/en/documents/eur36/7102/2017/en/).

<sup>123</sup> Истанбулын конвенци, 12(1) зүйл.



өөрчлөхөд чиглэсэн бүх арга хэмжээг авах үүрэгтэй<sup>124</sup>.

### **Вердито Филиппиний эсрэг хэрэгт НҮБ-ын конвенцийн хороо оролцогч улсад:**

Хүчин болон бэлгийн бусад хүчирхийлэлтэй холбоотой хэргийг шийдвэрлэхэд шударга, алагчлалгүй хандаж, жендэрийн хуучинсаг ойлголтоор хандаж байгаа эсэхэд үнэлэлт өгч байх хэрэгтэй. Үүний тулд өргөн хүрээний арга хэмжээг авч хэрэгжүүлэх хэрэгтэй бөгөөд үүнд хуулийн тогтолцоог өөрчлөх, хүчингийн хэргийг шийдвэрлэхэд шүүгчийн гаргаж байгаа хандлага, эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхсан хандлагыг өөрчлөх сургалт, боловсролын үйл ажиллагаа зэрэг орно<sup>125</sup>.

Эмнести Интернэшнлийн салбар байгууллагууд ч өөрийн улс оронд бэлгийн хүчирхийллийн талаар түгээмэл байгаа ойлголтуудын талаар судалгаа явуулж байсан байна. Тэдгээр судалгааны зарим нь бэлгийн хүчирхийллийн хувь хүн дээр хэрхэн тусдаг талаар чухал мэдээллийг агуулж байгаа бөгөөд ийм төрлийн гэмт хэрэг хэр түгээмэл байгааг үзүүлжээ. Жишээ нь Англи<sup>126</sup> (2005), Швед<sup>127</sup> (2008), Финлянд<sup>128</sup> (2010), Норвеги<sup>129</sup> (2013), Бельги<sup>130</sup> (2014), Дани<sup>131</sup> (2015) улсын салбар Эмнести байгууллагынхан ийм судалгааг хийжээ.

Европын холбооны жендэрт суурилсан хүчирхийллийн Евробарометр судалгааны тайланг 2016 оны 11 дүгээр сард хэвлэж гаргасан бөгөөд бэлгийн хүчирхийллийн талаарх хэвшмэл, хуучинсаг ойлголт амь бөхтэй байсаар байгааг харуулж байна. Судалгаанд оролцогчдын 27 хувь буюу дөрвөн хүн тутмын нэг нь зарим тохиолдолд (жишээ нь, тухайн хүн согтууруулах ундаа, эсвэл мансууруулах бодис хэрэглэсэн, хэн нэгэнтэй сайн дураар гэр рүү нь цуг явсан, хэтэрхий задгай хувцас өмссөн, “үгүй” гэж тодорхой хэлээгүй, эсэргүүцэл үзүүлээгүй гэх мэт) харилцан зөвшөөрөөгүй бэлгийн хавьтал байж болох зүйл гэж үзсэн байна. Таван хүн тутмын нэг нь (22%) эмэгтэйчүүд бэлгийн хүчирхийлэл, эсвэл доромжлолын талаар худлаа, эсвэл хэтрүүлэн мэдээлдэг гэж үзсэн байна<sup>132</sup>. Оролцогчдын 11 гаруй хувь нь бэлгийн хамтрагчтайгаа хүчээр бэлгийн хавьталд орохыг хуулиар шийтгэх үйлдэл биш гэж үзэж байна<sup>133</sup>.

## **4.8 ОЙЛГОЛТ НЭМЭГДҮҮЛЭХ АЯН**

Судалгаанд оролцсон хэд хэдэн шинжээч бэлгийн хүчирхийллийн талаарх ойлголт хүчирхийлэгч, анхны тусламж үзүүлж буй хүмүүс төдийгүй хохирогч нарын дунд ч хангалттай сайн биш байна. (Жишээ нь, Ирланд, Умард Ирланд болон Нидерландад). Гэр бүлийн хүчирхийлэл болон дотно харилцааны бусад хүчирхийлэл түгээмэл байгааг онцлон тэмдэглэж байлаа<sup>134</sup>. Ийм нөхцөл байдалд байгаа эмэгтэйчүүд бэлгийн хүчирхийлэлд өртөж байгаагаа мэддэггүй; эсвэл мэддэг мөртлөө мэргэжлийн хүмүүстэй уулзах, гомдол гаргахдаа биеийн болон сэтгэл санааны хүчирхийллийг хэлдэг болохоос бэлгийн хүчирхийллийн талаар ярихаас ичдэг учраас дурьдахгүй өнгөрдөг. Умард Ирландын нэгэн оролцогчийн хэлснээр гэрлэлтийн хүчингийн ойлголт “хүмүүсийн дунд сайн суугаагүй байна”<sup>135</sup>. Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн хохирогчдод дэмжлэг

<sup>124</sup> НҮБ ЭЯГБХУК, 1979, зүйл. 5(а).

<sup>125</sup> Вердито Филиппиний эсрэг, CEDAW Communication 18/2008, НҮБ-ын баримт CEDAW/C/46/D/18/2008 (2010), догол догол 8.9(b)

<sup>126</sup> Их Британи: Шинэ судалгаагаар гурван хүний нэг нь эрчүүдтэй сээтэгнэсэн эмэгтэй хүчиндүүлсэнд буруутай гэж итгэдэг гэжээ, 2005. [www.amnesty.org.uk/press-releases/uk-new-poll-finds-third-people-believe-women-who-flirt-partially-responsible-being](http://www.amnesty.org.uk/press-releases/uk-new-poll-finds-third-people-believe-women-who-flirt-partially-responsible-being).

<sup>127</sup> Шведийн Эмнести Интернэшнл, “Var ger grdensen? En attityundersckning om veldtdkt” 2008, холбоос: [www.amnesty.se/upload/files/2011/05/04/Valdtakt-Var%20gar%20gransen-En%20attitysundersokning%20om%20valdtakt-Amnesty.pdf](http://www.amnesty.se/upload/files/2011/05/04/Valdtakt-Var%20gar%20gransen-En%20attitysundersokning%20om%20valdtakt-Amnesty.pdf).

<sup>128</sup> Финляндын Эмнести Интернэшнл, “Asenne Esiin! Mieliipidekysely seksuaalisesta vdkivallasta” 2010, холбоос: [www.amnesty.fi/asenne-esiin-mieliipidekysely/](http://www.amnesty.fi/asenne-esiin-mieliipidekysely/).

<sup>129</sup> Норвегийн Эмнести Интернэшнл, “Undersokelse om voldtekt Laget for Amnesty International Norge” 2013, холбоос: [www.amnesty.no/aktuelt/flere-nyheter/skolen-svikter-i-kampen-mot-voldtekt-0](http://www.amnesty.no/aktuelt/flere-nyheter/skolen-svikter-i-kampen-mot-voldtekt-0).

<sup>130</sup> Эмнести Интернэшнл ба SOS Viol байгууллага, “Etude des opinions et des comportements de la population belge en matière de violences sexuelles” 2014, холбоос: [www.amnesty.be/IMG/pdf/enquete\\_synthese\\_final.pdf](http://www.amnesty.be/IMG/pdf/enquete_synthese_final.pdf).

<sup>131</sup> Холбоос: [www.amnesty.dk/nyhedsliste/2015/kan-en-kvindes-paaklaedning-goere-hende-ansvarlig-for-at-blive-voldtaget](http://www.amnesty.dk/nyhedsliste/2015/kan-en-kvindes-paaklaedning-goere-hende-ansvarlig-for-at-blive-voldtaget).

<sup>132</sup> Европын холбоо, “Евробарометр 449, Жендэрт суурилсан хүчирхийллийн тайлан, 2016: [https://data.europa.eu/odp/data/dataset/S2115\\_85\\_3\\_449\\_ENG/resource/d9160123-8dad-4400-bbb3-ffa35daca2cb](https://data.europa.eu/odp/data/dataset/S2115_85_3_449_ENG/resource/d9160123-8dad-4400-bbb3-ffa35daca2cb), хуудас 7.

<sup>133</sup> Европын холбоо, “Евробарометр 449, Жендэрт суурилсан хүчирхийллийн тайлан, 2016: хуудас 44.

<sup>134</sup> Эмнести Интернэшнлтэй хийсэн ярилцлага, Умард Ирланд, 2017 оны 7 сар.

<sup>135</sup> Эмнести Интернэшнлтэй хийсэн ярилцлага, Белфаст, 2017 оны 7 сарын 21.

үзүүлдэг олон төрлийн байгууллагатай улс орнуудад ч гэсэн мэргэжилтнүүд бэлгийн хүчирхийлэл гарсан эсэх, гарсан бол ямар туслалцаа үзүүлэх талаар хангалттай бэлтгэгдээгүй байна<sup>136</sup>. Умард Ирланд гэх мэт бусад оронд ийм гэмт үйлдэл гарсан бол, эсвэл гарч болзошгүй гэж үзэж байвал цагдаад мэдээлэх ёстой. Ингэснээр хохирогч дараагийн сөрөг үр дагавараас айгаад бэлгийн хүчирхийллийн талаар хэзээ ч мэдээлдэггүй, учир нь тэдэнд шүүх тогтолцооны үр дүнд гэмтэнг шийтгэж, хохирогчийг хамгаална гэсэн итгэл үнэмшил байдаггүй.

Европын жендэрийн тэгш байдлын талаарх 2013 оны судалгаанд “эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд кампанит ажил чухал нөлөөтэй бөгөөд хүчирхийлэл гэж юу юм бэ, яагаад хүлээн зөвшөөрч болохгүй талаар ойлголт өгөөд зогсохгүй, үүнийг дэмжсэн далд хандлага, зан үйлтэй тэмцэхэд хувь нэмэр оруулдаг”<sup>137</sup> гэж тэмдэглэсэн байна. Судалгаанд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх зорилгоор Европын янз бүрийн оронд хэрэгжүүлсэн 30 гаруй кампанит ажлын тоймыг оруулжээ. Үүнээс 10 оронд бэлгийн хүчирхийллийн тодорхой сэдвийн хүрээнд кампанит ажил явуулсан байгаа бөгөөд үүнд болзооны хүчин (Дани), гэрлэлтийн хүчин (Франц), мөн хэн нэгнийг хүчиндэхийн тулд мансууруулах бодис хэрэглэх асуудлыг (Герман) хөндсөн байна<sup>138</sup>.

Хэд хэдэн улс оронд (тухайлбал Швед, Ирландад) залуучууд бэлгийн хүчирхийлэл, бэлгийн харилцаанд хүндэтгэл, зөвшөөрөл байх талаар илүү их зүйлийг хүсэж байгаа бөгөөд тэд хуучирсан ойлголтуудыг өөрчлөх, ерөнхий мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх чиглэлээр идэвхтэй ажиллаж байна. Жишээ нь, зөвшөөрлийн асуудлаар дотуур байранд кампанит ажил өрнүүлэх, сургалтын хөтөлбөр боловсруулж<sup>139</sup>, оюутнуудын дунд бэлгийн хүчирхийлэл ямар байгаа талаар мэдээлэл олгох оролцооны аргад тулгуурласан судалгааг явуулсан байна<sup>140</sup>.

Зарим оронд, жишээ нь Умард Ирландад мэдлэг ойлголт өгөх ажил нь өөрийгөө хэрхэн бэлгийн хүчирхийллээс хамгаалах тал дээр төвлөрч голдуу охид эмэгтэйчүүдийг чиглэсэн байх бөгөөд хүчинг хүлээн зөвшөөрөх соёлтой тэмцэх, эрэгтэйчүүдийг оролцуулах тал дээр дутагдалтай байна. Данид цагдаагийн байгууллагаас санаачлага гаргаж бэлгийн болон бусад хүчирхийллийг цагдаад мэдээлэх байдлыг нэмэгдүүлэх зорилготой кампанит ажил явуулсан байна<sup>141</sup>. Энэхүү судалгааны хүрээнд энэ асуудлаар голчлон ажилладаг нэгэн оролцогч бэлгийн хүчирхийллийн кампанит ажилд эерэг мессеж чухал үүрэгтэй болохыг тэмдэглэсэн юм. Түүний ажигласнаар хүчирхийллийн хохирогч нар тэдэнд тохиолдсон хэргийг мэдээлэхэд хэвлэл мэдээллийнхэн хэргийг нь сенсаац болгодог. Үүний оронд “Энэ надад тохиолдсон ч би одоо сайн байна” гэсэн утгатай мессеж өгвөл илүү сайн, эерэг утгыг илэрхийлэх<sup>142</sup> болно. 2017 оны 10 сард эхэлж, удалгүй дэлхийн нийтийн хөдөлгөөн болж хувирсан #MeToo (Би ч бас) кампанит ажил ч энэ санааг нотолж байна.

<sup>136</sup> Эмнести Интернэшнлтай хийсэн ярилцлага, Амстердам, 2017 оны 5 сарын 23.

<sup>137</sup> Европын жендэрийн тэгш байдлын хүрээлэн, “ЕХ-ны бүсэд жендэрийн тэгш байдал, бэлгийн хүчирхийллийн талаарх одоо байгаа мэдээллийг тодорхойлох, зураглах судалгаа” 2013 он: <http://eige.europa.eu/rdc/eige-publications/study-identify-and-map-existing-data-and-resources-sexual-violence-against-women-eu-report>, р 10.

<sup>138</sup> Европын жендэрийн тэгш байдлын хүрээлэн, “ЕХ-ны бүсэд жендэрийн тэгш байдал, бэлгийн хүчирхийллийн талаарх одоо байгаа мэдээллийг тодорхойлох, зураглах судалгаа” 2013 он хуудас 10.

<sup>139</sup> SMART зөвшөөрөл. Бэлгийн зөвшөөрлийг ойлгож, харилцах нь, Ирландийн Үндэсний Галвей Их сургууль, [www.nuigalway.ie/smartconsent/](http://www.nuigalway.ie/smartconsent/)

<sup>140</sup> тухайлбал, SCORE (Оюутны зөвшөөрлийн талаарх судалгааны хамтын ажиллагаа) “Хамтдаа мэдээл”, Квинз Их сургуулийн Белфастын Оюутны Холбоо, 2016, холбоос: [www.qubconsentni.wordpress.com/](http://www.qubconsentni.wordpress.com/); Дублин Их сургууль, Коллеж, Үүний төлөө асуухгүй кампанит ажил: <https://www.ucdsu.ie/getinvolved/campaigns/consent/>; Ирландийн Үндэсний Галвей Их сургууль, SMART зөвшөөрөл (тайлан, сургалт, кино): [www.nuigalway.ie/smartconsent/](http://www.nuigalway.ie/smartconsent/).

<sup>141</sup> [www.politi.dk/da/aktuelt/nyheder/Selvom+det+startede+godt+kan+det+stadig+v%C3%A6re+voldt%C3%A6gt.htm?W-BCMODE=presentationunpubl](http://www.politi.dk/da/aktuelt/nyheder/Selvom+det+startede+godt+kan+det+stadig+v%C3%A6re+voldt%C3%A6gt.htm?W-BCMODE=presentationunpubl).

<sup>142</sup> Эмнести Интернэшнлтай хийсэн ярилцлага, Белфаст, 2017 оны 7 сарын 21.

ХҮСНЭГТ

Асуулт В10. Тодорхой нөхцөлд харилцан зөвшөөрөөгүй ч бэлгийн хавьталд орох нь байх зүйл гэж зарим хүмүүс итгэдэг. Доор дурдсан аль нөхцөлд энэ нь байж болох зүйл вэ? (Олон сонголтыг дугуйлж болно.) (%)

Улс	Архи уусан, эсвэл мансууруулах бодис хэрэглэсэн	Сайн дураар бусдыг дагаж гэрт нь очих (жишээ нь үдэшлэг, болзооны дараа)	Хэтэрхий задгай, өдсөн, биеэ ил гаргасан хувцас өмссөн	Үгүй гэдгийг тодорхой хэлээгүй, өөдөөс нь эсрэгүүлэл үзүүлээгүй	Өмнө нь сэтгэнэж байсан	Бэлгийн олон хавьтагчтай байх	Орой үдшийн цагаар ганцаараа гадуур явах	Хүчирхийлэгч нь юу хийж байгаагаа мэдэхгүй байх	Хүчирхийлэгч нь дараа нь гэмшсэн бол	Эдгээрийн аль ч биш	Татгалзах (шууд)	Мэдэхгүй
EU28	12	11	10	10	7	7	7	4	2	68	1	4
BE	18	16	15	14	11	11	12	8	5	57	0	2
BG	21	17	13	16	14	5	8	8	2	49	1	7
CZ	12	18	10	19	17	10	9	3	2	54	1	2
DK	2	7	2	6	4	2	1	2	1	83	1	2
DE	9	13	9	14	7	6	4	2	1	67	1	5
EE	13	11	10	11	8	4	4	3	1	67	1	6
IE	11	9	9	8	7	7	7	3	3	76	0	3
EL	11	15	11	16	8	8	4	2	1	67	0	1
ES	2	3	2	3	2	1	1	1	0	89	1	2
FR	15	7	16	12	6	8	9	10	3	64	0	4
HR	19	11	16	9	15	6	4	5	2	54	1	8
IT	14	15	10	7	6	7	10	4	1	69	1	2
CY	18	15	15	14	9	9	5	4	2	64	0	1
LV	20	20	16	11	13	8	12	4	3	56	1	6
LT	14	12	10	10	12	8	7	3	2	66	1	5
LU	17	15	17	15	7	10	10	9	2	58	1	3
HU	24	20	21	14	19	18	18	4	3	50	1	2
MT	18	13	20	11	13	11	5	5	3	62	0	1
NL	5	7	6	8	7	4	4	4	2	84	0	0
AT	15	11	9	12	6	10	8	6	4	62	3	3
PL	12	10	10	9	7	7	9	3	2	62	1	7
PT	19	15	12	10	5	13	15	3	1	66	0	4
RO	30	26	25	22	17	20	16	11	4	40	0	4
SI	8	8	7	5	4	4	4	3	1	76	2	3
SK	14	14	16	13	13	10	9	6	3	53	3	5
FI	2	7	3	6	4	4	2	1	0	88	0	1
SE	2	3	2	4	2	2	2	3	2	93	0	0
UK	12	5	6	6	6	4	5	4	3	72	1	5

Хамгийн өндөр хувь, орноор

Хамгийн бага хувь, орноор

Хамгийн өндөр хувь, хариултаар

Хамгийн бага хувь, хариултаар

Сан: Судалгаанд хамрагдсан бүх оролцогч (N=27818)

Эх сурвалж: Европын холбоо, Евробарометр 449, Жендэрт суурилсан хүчирхийлэл- Тайлан, 2016 он, хуудас 64

Умард Ирландад бэлгийн хүчирхийллийн хохирогч нартай тулж ажилладаг нэгэн мэргэжилтний ярьснаар хүчин, эсвэл бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогчийг дараа нь биеэ яаж авч явах нь вэ гэдгийг түүний гэр бүлийнхэн, хэрэв энэ хэрэг нийтэд илэрсэн бол олон нийт, шүүх

тогтолцоонд ажиллаж буй хүмүүс анхааралтай харж, ажиглаж байдаг<sup>143</sup>. Эмэгтэйчүүд, охид “үлгэр жишээ” хохирогч байх түгээмэл хүлээлт байдаг: **эмзэг, гомдоллосон, өрөвдмөөр**. Энэ талаар Эмнестигээс гаргасан “Хэргийг Хаасан” тайланд Шведийн жишээг дурьдаж болохоор байна. Үүнд “энэ тохиолдолд хохирогчийн өөрийгөө үгээр илэрхийлэх чадвар, нийгмийн байдал чухал үүргийг гүйцэтгэдэг. “Гэмгүй хохирогч”-ийн дүр зурганд залуу, тэгээд архи ууж согтсон эмэгтэй нийцэхгүй. Үүний үр дүнд тэд дотно харилцааны хүчинд өртсөн ч, эсвэл болзооны хүчинд өртсөн ч бай тэдний хэргийг шүүхээр авч хэлэлцсэн нь маш ховор байна. Хүчинг мөрдөн шалгах үйл явцад эрх нь зөрчигдөж болзошгүй бусад эмэгтэйчүүдэд, жишээ нь, Швед эрэгтэйтэй бэлгийн харилцаатай Ази, эсвэл Зүүн Европын орноос ирсэн эмэгтэйчүүд, биеэ үнэлэгчид, орон гэргүй эмэгтэйчүүд, мансууруулах бодис хэрэглэдэг, эсвэл оюун ухааны хомсдолтой эмэгтэйчүүд, өмнө нь хүчиндүүлж байсан эмэгтэйчүүд орно”<sup>144</sup>. Түүнчлэн, биеэ яаж ч авч явсан эмэгтэйчүүд охид байнга шүүмжлэлд өртдөг бөгөөд хэзээ ч бусдад таалагддаггүй. Зарим нь “ийм юм болчихоод байхад хэтэрхий тоомжиргүй байна” гэж байхад, нөгөө хэсэг нь “хэт сэтгэлийн хөдөлгөөнөөр хандаж сүр бадрууллаа” гэнэ. Эсвэл бүр сэтгэл мэдрэлийн өвчтэй болно, эсвэл “амьдарлаа бод”, “хэтэрхий зоригтой байна” гэж хэлэх бөгөөд хүүхэд байхдаа туулсан хүчирхийллийг ийм олон жилийн дараа сөхөж яадаг юм гэж буруутгагдана<sup>145</sup>.

Судалгаанд оролцсон олон орны оролцогчид хүчин болон бэлгийн хүчирхийлэлтэй холбоотой буруу ойлголт, үг ярианаас болгоомжлоод эмэгтэйчүүд уг хэргийг шүүхэд мэдээлдэггүй гэсэн юм. Хэвлэл мэдээллээр гарч буй мэдээ, хүмүүсийн тарааж байгаа цуу яриа зэрэг нь хүний нэр хүндийг гутаан буруу ойлголтыг бүрдүүлэхэд нөлөөлж байдаг. Хэрэв шүүхээс хэргийг хэрэгсэхгүй болговол хохирогч худлаа хүн гүтгэсэн гэж ойлгогдох бөгөөд ийм төрлийн мэдээллийг хэвлэл мэдээллийнхэн маш их сурвалжилж, бичдэг. Хэвлэлээр гарч буй мэдээлэл нь хохирогч ямар хувцас өмссөн байсан, архи уусан байсан уу гэдэг дээр заавал төвлөрдөг бөгөөд энэ нь хүчин болон зөвшөөрөлтэй холбоотой буруу зөрүү ойлголтыг өөгшүүлж, эмэгтэйчүүдийн өөрт нь итгэж, шүүх шударгаар шүүнэ гэдэгт найдах итгэлийг үгүй хийж байна.

Нийгмийн бүхий л хүрээнд мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, бэлгийн болон харилцааны цогц боловсролыг олгох, хуучинсаг буруу ойлголтуудыг халах зэрэг нь хүчинг хүлээн зөвшөөрөх соёлыг устгах, цаашлаад эмэгтэйчүүд охидын эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, ийм хэргийг шийтгэлгүй өнгөрүүлэхгүй байхад чухал нөлөөтэй.

<sup>143</sup> Эмнести Интернэшнлтэй хийсэн ярилцлага, Белфаст, 2017 оны 7 сарын 21.

<sup>144</sup> Эмнести Интернэшнл, “Хэрэг хаагдлаа. Скандинавын орнуудын хүчин, хүний эрхийн байдал. Товч тайлан” 2010 он: [www.amnesty.org/en/documents/ACT77/001/2010/en/](http://www.amnesty.org/en/documents/ACT77/001/2010/en/). Шведийн тухай мэдээлэл: “гэр бүлийн хүчирхийлэл ба бэлгийн хүчирхийлэл – Стоколм мужийн дүүргийн цагдаагийн комиссуудыг зохион байгуулалт, мөрдөн байцаалтын чанарын хамаарлыг харьцуулсан судалгаа”, Дунд шатны тайлан, 2006 Стоколм мужийн дүүргийн цагдаагийн комиссуудыг зохион байгуулалт, мөрдөн байцаалтын чанарын хамаарлыг харьцуулсан судалгаа”, Дунд шатны тайлан, 2008.

<sup>145</sup> Эмнести Интернэшнлтэй хийсэн ярилцлага, Белфаст, 2017 оны 7 сарын 21.

## 5. СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ. БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ТАРХАЛТ БА ШҮҮХЭЭР ШИЙДҮҮЛСЭН ХУВЬ

Хэдийгээр хүчин бол ноцтой гэмт хэрэг гэж хүлээн зөвшөөрөгддөг, Истанбулын конвенцийн дагуу статистик мэдээллийг цуглуулах шаардлагатай<sup>146</sup> боловч хүчингийн талаарх гомдол, мөрдөн шалгасан, эцэслэн шийдвэрлэсэн талаарх тоон мэдээлэл хангалтгүй байна. Энэхүү судалгаанд ашигласан ном зүйг бичсэн зохиогчдын нэгэнт дурьдсанаар энэ байдал Европын зарим улсад гайгүй байгаа боловч заримд нь тоон мэдээлэл олдохгүй байна<sup>147</sup>. 2013 оны Европын Жендэрийн тэгш байдлын хүрээлэнгийн судалгаанаас харахад зарим оронд бэлгийн хүчирхийлэлтэй холбоотой статистик мэдээллийг хэд хэдэн байгууллага цуглуулдаг төвлөрсөн мэдээллийн сан байхгүй, үүний улмаас найдвартай тоо баримт олж авах, статистик мэдээллийг харьцуулах боломжгүй байна<sup>148</sup>. Жишээ нь, Ирландад статистик мэдээллийг цагдаагийн газар, Нийтийн прокурорын газар, шүүх, тэгээд Статистикийн төв газар гэх мэт 4 байгууллага дээр цуглуулдаг бөгөөд нэгдсэн тоон мэдээлэл гаргадаггүй. Судалгаанд Ирландаас оролцож, мэдээлэл өгсөн шинжээчид энэ байдал нь найдвартай мэдээлэл олж авахад хүндрэл учруулж байгаатай санал нэгдэж байлаа.

Европын Жендэрийн тэгш байдлын хүрээлэнгийн үзэж байгаагаар бэлгийн хүчирхийллийн ойлголт Европын улс хооронд өөр байдаг учраас статистик мэдээллийг нь Европын холбооны түвшинд ашиглах, харьцуулахад нэлээн бэрхшээлтэй, бараг боломжгүй байна<sup>149</sup>.

Эмнести Интернэшнлээс 2008 онд гаргасан “Хэрэг хаагдлаа” тайланд Дани, Финлянд, Норвеги, Шведийн бэлгийн хүчирхийллийн статистик мэдээллийг хооронд нь харьцуулах боломжгүй байгааг тэмдэглэсэн байна: “Эдгээр орны эрүүгийн гэмт хэргийн статистикийн хооронд харьцуулах боломжгүй байна. Хүн амын тооны ялгаанаас гадна, цагдаад хүчингийн гэмт хэргийг мэдээлэх аргууд нь өөр өөр байна. Дани, Норвегид статистик мэдээлэл нь хэргийн тоогоор (нэг хэрэг, нэг хохирогч) байдаг бол Шведэд хүчингийн тоог бүртгэдэг байна. Жишээ нь, хэрэв хохирогч эмэгтэйг нэг өдрийн дотор нэг хүн олон дахин хүчиндсэн бол тэр хавьтал болгоныг бүртгэдэг гэсэн үг юм. Хэрэв бүлэглэн хүчиндсэн бол мөн адил хэдэн удаа хүчиндсэн тоогоор хэрэг үүсдэг. Тэгэхээр Дани, Норвегид хүчиндүүлсэн хүний тоогоор бүртгэл мэдээлэл явдаг бол, Шведэд хүчингийн тохиолдлоор нь бүртгэж мэдээлдэг байна<sup>150</sup>”. Тийм болохоор Лиз Келли, Жо Ловетт нарын 2009 онд хийсэн судалгаанд Шведийн 2006 оны бүртгэгдсэн хүчингийн тоо бусад бүх орныхоос өндөр байсан нь гайхмаар зүйл биш болж байна. Шведийн статистик мэдээлэл Англи, Уэльсийнхээс 2 дахин, Финляндынхаас 4 дахин, Унгарынхаас 35 дахин өндөр байжээ<sup>151</sup>.

**Түүнчлэн бүртгэгдсэн хүчингийн тохиолдлуудын өсөлт, бууралт нь үнэхээр хүчингийн гэмт хэргийн гаралттай холбоотой юу, эсвэл бүртгэх дүрэм журмын өөрчлөлттэй холбоотой юу гэдгийг хэлэхэд хэцүү байна.** Жишээ нь, шүүн шалгах тогтолцоонд итгэх итгэл нэмэгдсэнээс болж бүртгэгдсэн тохиолдлын тоо өссөн үү, эсвэл цагдаагийн газраас бүртгэлийн шинэ арга нэвтрүүлснээр нэмэгдсэн үү гэдгийг ялгаж салгах хүндрэлтэй байна. Нөгөө талаас, бүртгэгдсэн хэргийн тоо бага байх нь бэлгийн хүчирхийллийн гаралт буурч байна, тэгэхээр хүчингийн дараах дэмжлэг үзүүлдэг төвүүдийн санхүүжилтийг бууруулах хэрэгтэй гэсэн ойлголтыг засаг захиргаанд өгч болзошгүй. Жишээ нь, судалгаанд Ирландаас оролцсон оролцогчид 2014 оны судалгаагаар

<sup>146</sup> Истанбулын конвенци, 11 зүйл.

<sup>147</sup> Келли Л., Ловетт Ж. нарын “Өөр тогтолцоо, ижил үр дүн?” 2009 оны судалгааг харна уу. Холбоос: [www.cwasu.org/resource/different-systems-similar-outcomes-tracking-attribution-in-reported-rape-cases-in-11-european-countries/](http://www.cwasu.org/resource/different-systems-similar-outcomes-tracking-attribution-in-reported-rape-cases-in-11-european-countries/), хуудас 17; Европын жендэрийн тэгш байдлын хүрээлэн, “ЕХ-ны бүсэд жендэрийн тэгш байдал, бэлгийн хүчирхийллийн талаарх одоо байгаа мэдээллийг тодорхойлох, зураглах судалгаа” 2013 он хуудас 11.

<sup>148</sup> Европын жендэрийн тэгш байдлын хүрээлэн, “ЕХ-ны бүсэд жендэрийн тэгш байдал, бэлгийн хүчирхийллийн талаарх одоо байгаа мэдээллийг тодорхойлох, зураглах судалгаа” 2013 он хуудас 11.

<sup>149</sup> Европын жендэрийн тэгш байдлын хүрээлэн, “ЕХ-ны бүсэд жендэрийн тэгш байдал, бэлгийн хүчирхийллийн талаарх одоо байгаа мэдээллийг тодорхойлох, зураглах судалгаа” 2013 он хуудас 9.

<sup>150</sup> Эмнести Интернэшнл, “Хэргийг хаалаа. Скандинавын орнуудын хүчин, хүний эрхийн байдал. Товч тайлан” 2010 он: хуудас 20.

<sup>151</sup> Келли Л., Ловетт Ж. нарын “Өөр тогтолцоо, ижил үр дүн?” 2009 оны судалгааг харна уу. Холбоос: [www.cwasu.org/resource/different-systems-similar-outcomes-tracking-attribution-in-reported-rape-cases-in-11-european-countries/](http://www.cwasu.org/resource/different-systems-similar-outcomes-tracking-attribution-in-reported-rape-cases-in-11-european-countries/), хуудас 19.

Ирландад бэлгийн хүчирхийллийн тархалт харьцангуй бага үзүүлэлттэй (8 хувьтай гарсан бөгөөд Европын холбооны дундаж 11 хувь байв) гарсныг төр засаг нь амжилт гэж зарлан тунхаглаж<sup>152</sup> байсан тухай ярьсан. Дээр дурьдсан хүндрэл бэрхшээлүүд байгаа хэдий ч, доорх дэд бүлгүүдэд харьцуулах боломжтой тоо баримтын дүн шинжилгээний тоймыг багтаасан байгаа.

## 5.1 БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ТАРХАЛТ

Европын эдийн засгийн бүсийн улс орнуудад хүчин болон бэлгийн хүчирхийллийн тархалт ямар байгаа талаархи мэдээлэл шүүхээр шийдүүлсэн хэргийн мэдээллээс илүү олдоцтой байна. Тархалт мэдээж маш өндөр байна. Европ даяар хийгдсэн хамгийн сүүлийн үеийн судалгаанаас<sup>153</sup> харахад ЕХ-нд арван эмэгтэй тутмын нэг (11%) нь 15 нас хүрээд бэлгийн хүчирхийллийн аль нэг хэлбэрт өртөж байсан ба голдуу бэлгийн хамтрагч<sup>154</sup> (судалгаанд ороцлогчдын дийлэнх олонхи нь эсрэг хүйстнээ сонирхдог байсан бөгөөд эсрэг хүйсийн хамтрагчаа ярьж байна), эсвэл бусад хүмүүсээс<sup>155</sup> гэж тэмдэглэсэн байна. Ойролцоогоор 3.7 сая хүн судалгаа хийгдэхээс 12 сарын өмнө хүчирхийлэлд өртсөн гэжээ. ЕХ-ны 20 эмэгтэй тутмын нэг нь (5%)<sup>156</sup> 15 нас хүрээд хүчиндүүлсэн байна. Энэ нь ЕХ даяар 9 сая гаруй эмэгтэй<sup>157</sup> 15 нас хүрээд хүчиндүүлсэн гэдэг тооцооллын тайлан хийсэн байна.

Оролцогчдийн дөнгөж 15% нь бэлгийн хамтрагчийнхаа үйлдсэн хамгийн ноцтой хүчирхийллийн талаар цагдаад мэдэгдсэн бөгөөд бусад хүмүүсийн үйлдсэн хүчирхийлэл 14%-ийг<sup>158</sup> эзэлж байна. Хамтрагчаас өөр хүн бэлгийн хүчирхийллийг үйлдсэн тохиолдлуудад 10 эмэгтэй тутмын нэг<sup>159</sup> нь нэгээс олон хүн бүлэглэн үйлдсэн гэж мэдүүлсэн байна.

### 15-аас дээш насны эмэгтэйчүүдийн эсрэг үйлдсэн бэлгийн хүчирхийллийн тархалт, ЕХ (2014)

- 3 эмэгтэй тутмын 1 нь биеийн болон бэлгийн хүчирхийлэлд өртжээ
- **10 эмэгтэй тутмын 1 (11%) бэлгийн хүчирхийлэлд өртсөн байна**
- 20 эмэгтэй тутмын 1 нь (5%) нь хүчиндүүлсэн байна
- **18-74 насны 9 сая орчим эмэгтэй хүчиндүүлсэн байна.**
- 6% нь хүчиндүүлэх дөхсөн.
- 10 тохиолдол болгоны 1-д нэгээс олон хүн бүлэглэн хүчирхийлсэн байна.

Судалгааны бүс, улс орноор ангилсан **мэдээллийн санг**<sup>160</sup> ашиглаж сонирхсон асуулт, улс орон, ЕХ-ны дундажтай харьцуулж болно.

<sup>152</sup> Эмнести Интернэшнлтэй хийсэн ярилцлага, Дублин, 2017 оны 7 сарын 18. Хуудас 24 дээр байгаа хүснэгтийг харна уу.

<sup>153</sup> Европын Холбооны Суурь эрхийн төлөөх байгууллага. "Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл Европын Холбоог хамарсан судалгааны тайлан" 2014 он

<sup>154</sup> Европын Холбооны Суурь эрхийн төлөөх байгууллага. "Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл Европын Холбоог хамарсан судалгааны тайлан" 2014 он

<sup>155</sup> Европын Холбооны Суурь эрхийн төлөөх байгууллага. "Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл Европын Холбоог хамарсан судалгааны тайлан" 2014, хуудас 48.

<sup>156</sup> Дээрх судалгаанд 18-74 насны эмэгтэйчүүд хамрагдсан.

<sup>157</sup> Европын Холбооны Суурь эрхийн төлөөх байгууллага. "Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл Европын Холбоог хамарсан судалгааны тайлан" 2014, хуудас 41.

<sup>158</sup> Европын Холбооны Суурь эрхийн төлөөх байгууллага. "Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл Европын Холбоог хамарсан судалгааны тайлан" 2014, хуудас 59.

<sup>159</sup> Европын Холбооны Суурь эрхийн төлөөх байгууллага. "Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл Европын Холбоог хамарсан судалгааны тайлан" 2014, хуудас 21.

<sup>160</sup> Холбоос: [www.fra.europa.eu/en/publications-and-resources/data-and-maps/survey-data-explorer-violence-against-women-survey?mdq1=theme&mdq2=3506](http://www.fra.europa.eu/en/publications-and-resources/data-and-maps/survey-data-explorer-violence-against-women-survey?mdq1=theme&mdq2=3506).



## 5.2 БҮРТГЭГДСЭН БОЛОН ШҮҮХЭЭР ШИЙДВЭРЛҮҮЛСЭН ХЭРГИЙН ХУВЬ

### 5.2.1 ЦАГДААД МЭДЭЭЛЖ БҮРТГҮҮЛЭХ

Дээр дурьдсан 2014 оны судалгаанд ЕХ-ны гишүүн орнуудад бэлгийн хүчирхийллийг цагдаад мэдээлэх, бүртгүүлэх байдал ямар байгаа талаар чухал мэдээлэл орсон бөгөөд Дани, Финляндад цагдаад мэдээлэх хувь хамгийн бага (7%), харин Кипрт хамгийн өндөр (27%) байна. ЕХ-ны дундаж нь 14% байна<sup>161</sup>.

Судалгааны үр дүнгээс харахад оролцогчдын 15% нь бэлгийн хамтрагчийнхаа үйлдсэн хамгийн ноцтой хүчирхийллийг цагдаад мэдээлсэн гэсэн бол 14% нь бусад хүмүүсийн үйлдсэн ноцтой хүчирхийллийг мэдээлсэн байна<sup>162</sup>. Хохирогчдын дөрөвний нэг орчим хувь нь ноцтой бэлгийн хүчирхийллийг цагдаа болон бусад холбогдох байгууллагад мэдэгдээгүй шалтгаанаа ичиж санаа зовсон<sup>163</sup> гэж хариулсан байна.

Биеийн болон бэлгийн хүчирхийллийг цагдаад мэдэгддэггүй бусад шалтгааныг доорхи хүснэгтэд харуулав.

**Хүснэгт 3.6** 15 нас хүрснээсээ хойш хамгийн ноцтой бэлгийн хүчирхийллийн дараа цагдаад мэдэгдээгүй шалтгаан, хүчирхийллийн хэлбэр, үйлдэгчээр (%)

	Бэлгийн хамтрагч (өмнөх эсвэл одоогийнх)		Бусад хүмүүс	
	Бие махбодын хүчирхийлэл	Бэлгийн хүчирхийлэл	Бие махбодын хүчирхийлэл	Бэлгийн хүчирхийлэл
Өөрөө шийдсэн, найз тусласан, гэр бүлийн асуудал	41	33	36	26
Хэтэрхий бага асуудал, тийм ч ноцтой биш, надад хэзээ ч тохиолдоогүй	34	17	38	16
Тэд ямар нэгэн юм хийнэ гэж бодоогүй	7	13	6	12
Тэд ямар нэгэн юм хийж чадна гэж бодоогүй	5	12	6	9
Хэрэг үйлдэгчээс айсан, сүрдүүлсэн	11	20	6	14
Хэн нэгэн намайг зогсоосон, боль гэж ятгасан	2	3	1	2
Ичиж, санаа зовсон	11	23	5	26
Миний буруу гэж бодсон	4	6	4	13
Бусад хүмүүс битгий мэдээсэй гэж бодсон, нууцалсан	11	21	4	18
Цагдаад очиход хэтэрхий сэтгэл санаагаар унасан байсан	4	5	3	7
Үйлдэгчийг цагдаад битгий баригдаасай, асуудалд оролцуулаад яахав гэж хүссэн	5	5	3	2
Надад итгэхгүй	2	9	2	14
Хүүхдүүдээ алдахаас айсан	2	4	n/a	n/a
Бидний харилцаа түүгээр битгий дуусаасай гэж хүссэн	4	6	n/a	n/a
Шууд цагдаа, прокурорын газарт очиж мэдэгдсэн	(0)	(0)	(0)	(0)
Хэн нэгэн мэдэгдсэн байсан, цагдаа өөрсдөө олоод мэдчихсэн байсан	1	2	3	3
Тусламж авахаар өөр газар очсон	2	2	3	4
Бусад шалтгаан	7	13	11	13
	4.606	1.562	3.709	1.615

2013 онд Европын эмэгтэйчүүдийн лобби бүлгээс нийтлүүлсэн “Хүчингийн барометр” судалгаанд “өмнө хийгдсэн бусад судалгаа, олон нийтийн санал асуулга, гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн хохирогч нартай тулж ажилладаг төрийн бус байгууллагуудын туршлагаас харахад хүчингийн цөөн тохиолдлыг цагдаад мэдээлдэг бөгөөд мэдээлээгүй үлдсэн хүчингийн тоо хамаагүй өндөр байгаа”<sup>164</sup> гэж тэмдэглэжээ. 2009 онд Лиз Келли, Жо Ловетт нарын хийсэн

<sup>161</sup> Европын Холбооны Суурь эрхийн төлөөх байгууллага. “Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл Европын Холбоог хамарсан судалгааны тайлан” 2014

<sup>162</sup> Европын Холбооны Суурь эрхийн төлөөх байгууллага. “Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл Европын Холбоог хамарсан судалгааны тайлан” 2014, хуудас 59.

<sup>163</sup> Европын Холбооны Суурь эрхийн төлөөх байгууллага. “Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл Европын Холбоог хамарсан судалгааны тайлан” 2014, хуудас 55.

<sup>164</sup> Европын эмэгтэйчүүдийн лобби бүлэг, “Хүчингийн барометр” 2013 он, хуудас 7.

судалгаанд<sup>165</sup> хүчингийн болон бэлгийн халдлагын маш бага хувийг цагдаад мэдэгдэж бүртгэгддэг гэсэн дүгнэлтийг баталсан байна. Дээр дурьдсан “Хүчингийн барометр” судалгаа нь бүртгэгдсэн хүчингийн тоо цөөн байгаа нь айдаст автсан, боломжтой үйлчилгээ, дэмжлэгүүдийн талаар хохирогч нар мэддэггүй, мөн хохирогчдод итгэхгүй байх гэсэн болгоомжлолоос шалтгаалдаг гэжээ. Тайланд “жендэрийн хэвшмэл ойлголт, эрэгтэй эмэгтэй хүмүүс ямар зан үйл гаргах ёстой талаархи нийгмийн хүлээлт (жендэрийн үүрэг) зэрэг нь болзооны хүчинг байж болох зүйл төдийгүй байдаг л зүйл мэт ойлголтыг төрүүлэх уршигтай”<sup>166</sup> гэж тэмдэглэсэн байна.

## 5.2.2 ШҮҮХЭЭР ШИЙДВЭРЛҮҮЛСЭН ХЭРГИЙН ХУВЬ

Бүсийн улс орнуудад шүүхээр шийдвэрлүүлсэн хэргийн хувийн талаар цөөн судалгаа хийгдсэн байна. Хамгийн өргөн хүрээнд гүнзгийрүүлсэн дүн шинжилгээг хийсэн судалгаа нь Лиз Келли, Жо Ловетт нарын 2009 оны судалгаа бөгөөд хоорондоо ялгаатай хууль эрх зүйн тогтолцоотой 11 орны (Австри, Бельги, Англи ба Уэльс, Франц, Герман, Грек, Унгар, Ирланд, Португаль, Шотланд, Швед) гүнзгийрүүлэн судалж, бусад 22 орны (Болгар, Хорват, Чех, Кипр, Дани, Эстони, Финлянд, Исланд, Итали, Мальт, Латви, Литва, Люксембург, Нидерланд, Польш, Румын, Словак, Словени, Испани, Швейцарь, Турк) тухай тодорхой мэдээлэл, тоо баримтыг өгчээ<sup>167</sup>.

Хууль эрх зүйн тогтолцоо, бэлгийн хүчирхийлэл гэж юуг хэлэх тухай тодорхойлолт, статистик мэдээлэл цуглуулах арга, мэдээллийн чанар гэх мэт нь бүгд ялгаатай учир шүүхээр шийдвэрлэсэн хэргийн хувийг улс орноор харьцуулах нь амаргүй байсныг судалгааны тайланд тэмдэглээд “ашигласан тоон мэдээллийг дотоод, гадаадад хүлээн зөвшөөрөгдсөн гэх баталгаагүй”<sup>168</sup> гэж анхааруулсан байна. Судалгаанд анхааруулснаар шүүхээр шийдвэрлэсэн хэргийн хувийг тооцохдоо ихэнх улс орнууд бүртгэгдсэн хэргийн дотор буруутай нь нотлогдоогүй хэргийн хувийг тооцох аргыг ашиглаж байна. Заримдаа бүртгэгдсэн хэрэгт мөрдөн шалгасан хэргийн эзлэх хувиар тооцож байна<sup>169</sup>. Гэвч хэргийн мөрдөн шалгах үйл явцад прокурорын байгууллагын гүйцэтгэх үүрэг, тэдний байнга ашигладаг дүрэм журам зэрэг нь улс орнуудын хувьд их ялгаатай учир судалгаа нь мөрдөн шалгасан хэргийн тоог авч үзэлгүй, гэм буруутай нь нотлогдсон хэргийн тоон дээр үндэслэсэн байна. Судалгаанд голчлон 2006 оны тоон мэдээллийг ашигласан байгаа бөгөөд түүнээс ч урт хугацааг (ихэнх тохиолдолд 1997-2007 он байна) хамруулсан.

Шүүхээр шийдвэрлэгдэх хувь Европт ерөнхийдөө 4 янзын хандлагаар явагдаж байна гээд, бүсийн ихэнхи орнууд (68%) “сонгодог” хувилбараар явж байна гэж дүгнэжээ. Энэ нь (Австри, Бельги, Кипр, Англи ба Уэльс, Эстони, Финлянд, Герман, Грек, Исланд, Ирланд, Итали, Литва, Латви, Шотланд, Швед, Швейцарь)-т тодорхой хугацааны туршид бүртгэгдсэн хэргийн хувь өсөж, гэм буруутай нь тогтоогдсон хэргийн хувь буурах хандлагатай гэсэн үг юм. Зөвхөн 3 оронд (Дани, Франц, Люксембург) бүртгэгдсэн хүчингийн хувь өсөж, түүний хэрээр буруутай нь нотлогдсон хэргийн эзлэх хувь өссөн хандлагатай байна. Судалгаанд хамрагдсан 4 оронд (Чех, Унгар, Португаль, Румын) бүртгэгдсэн гэмт хэргийн тоо буурах тусам буруутай нь нотлогдсон хэргийн тоо<sup>170</sup> дагаад буурсан хандлага ажиглагдсан бөгөөд нэг улсын хувьд (Польш) гэм буруутай нь нотлогдсон хэргийн хувь бүртгэгдсэн хэргийн хувиас өндөр<sup>171</sup> буюу “хэвийн биш” үр дүн гарчээ. Хэдийгээр судалгаа хийгдээд 10 орчим жил өнгөрсөн, судалгаанд хамрагдсан улс орнуудад хууль зүйн болон хэрэгжилттэй холбоотой өөрчлөлттэй уялдан шүүхээр шийдвэрлүүлсэн хэргийн эзлэх хувьд өөрчлөлт орсон байж болзошгүй ч, судалгааны дүгнэлт нь одоо ч анхаарал татсан хэвээрээ байна. Тухайлбал:

- Умард, Баруун Европын орнуудад бүртгэгдсэн хэргийн тоо өссөн;
- 100,000 хүн ам тутамд бүртгэгдсэн хэргийн эзлэх хувь нэлээд их ялгаатай;
- Цаг хугацаа болон улс орнуудын хооронд гэм буруутай нь нотлогдсон хэргийн эзлэх хувьд ялгаатай;
- Гэм буруутай нь нотлогдсон хэргийн эзлэх хувь, бүртгэгдсэн хэргийн эзлэх хувийн

<sup>165</sup> Келли Л., Ловетт Ж. нарын “Өөр тогтолцоо, ижил үр дүн?” 2009 оны судалгааг харна уу, хуудас 17.

<sup>166</sup> Европын эмэгтэйчүүдийн лобби бүлэг, “Хүчингийн барометр” 2013 он, хуудас 11.

<sup>167</sup> Келли Л., Ловетт Ж. нарын “Өөр тогтолцоо, ижил үр дүн?” 2009 оны судалгааг харна уу.

<sup>168</sup> Келли Л., Ловетт Ж. нарын “Өөр тогтолцоо, ижил үр дүн?” 2009 оны судалгааг харна уу, хуудас 17.

<sup>169</sup> Келли Л., Ловетт Ж. нарын “Өөр тогтолцоо, ижил үр дүн?” 2009 оны судалгааг харна уу, хуудас 17.

<sup>170</sup> Келли Л., Ловетт Ж. нарын “Өөр тогтолцоо, ижил үр дүн?” 2009 оны судалгааг харна уу, хуудас 22.

<sup>171</sup> Келли Л., Ловетт Ж. нарын “Өөр тогтолцоо, ижил үр дүн?” 2009 оны судалгааг харна уу, хуудас 25.

- хооронд коррелаци;
- Европын олонхи улс орнуудад сүүлийн арван жилийн туршид шүүхээр шийдвэрлүүлсэн хэргийн эзлэх хувь “уламжлал” хандлагаар явж байна<sup>172</sup>.

## 6. ОЛОН УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ХЭМ ХЭМЖЭЭ

Хүчингийн тухай олон улсын хууль, хэм хэмжээг жендэрт суурилсан хүчирхийлэл, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн асуудлын хүрээнд боловсруулсан байна<sup>173</sup>. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл нь урт удаан түүхтэй эмэгтэй, эрэгтэй хүний эрх мэдлийн тэнцвэргүй харьцаанаас үүдэлтэй<sup>174</sup> бөгөөд “эрэгтэйчүүдийн нэгэн адил эрх, эрх чөлөөг эдлэх боломжийг нь ноцтой зөрчиж байдаг”<sup>175</sup>. Ийм хүчирхийлэлд “биеийн, сэтгэл санааны, эсвэл бэлгийн хор уршиг, зовлон эдлүүлэх үйлдэл, ийм үйлдэл хийнэ гэж айлган сүрдүүлэх, дарамтлах, эрх чөлөөг нь боогдуулах”<sup>176</sup> зэрэг хамрагдана. НҮБ-ын Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцид “эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах аливаа үзлийг хориглох”, эмэгтэйчүүдийг алагчилсан хууль, зохицуулалт, заншил, дадлыг өөрчлөх буюу хүчингүй болгох талаар”<sup>177</sup> арга хэмжээ авахыг гишүүн орнуудад үүрэг болгосон байдаг. Түүнээс гадна, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалттай цаг алдалгүй хурдан тэмцэх үүрэгтэй бөгөөд эдгээр арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэхгүй байгаа эдийн засгийн, соёлын, болон шашны шалтаг шалтгааныг уучлах<sup>178</sup> боломжгүй юм. Жендэрт суурилсан хүчирхийллийн үйлдлээс урьдчилан сэргийлэх, төрийн байгууллагаар мөрдөн шалгуулах ажлыг төр хариуцах<sup>179</sup> бөгөөд “эмэгтэйчүүдийн эсрэг жендэрт суурилсан хүчирхийлэл болж хувирч буй төрийн бус байгууллагуудын үйлдэл, эсвэл алдаанаас урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах, яллах, гомдлыг барагдуулах бүхий л арга хэмжээг”<sup>180</sup> авах үүргийг мөн хүлээнэ.

Цаашлаад Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн асуудлаархи НҮБ-ын тусгай төлөөлөгчийн хэлснээр эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс сэргийлэх, хариу үйлдэл үзүүлэх үүргээ **ЗОХИХ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭНД** биелүүлэх нь олон улсын хуулийн салшгүй нэг хэсэг<sup>181</sup> болоод байна. Тусгай илтгэгч “хүчирхийллийн үйлдлийг төрийн, эсвэл төрөөс ангид байгууллага үйлдсэн ч ялгаагүй түүнээс сэргийлэх, шалгах, яллах, шийдвэрлэх үүргийг төр хүлээсээр байх болно”<sup>182</sup> гэж тэмдэглэсэн байна. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, тэмцэх тухай Европын хорооны конвенцийн (Истанбулын конвенци) эмэгтэйчүүдийн

<sup>172</sup> Келли Л., Ловетт Ж. нарын “Өөр тогтолцоо, ижил үр дүн?” 2009 оны судалгааг харна уу, хуудас 25.

<sup>173</sup> Энэ үйл ажиллагааны хүрээнд хуульчилсан ЭЯГБХУК, Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, шийтгэх, устгах тухай Америк тивийн конвенци (Белем ду Парагийн конвенци) Африкийн Холбооноос баталсан Африкийн Хүний эрхийн дүрмийн Африкийн эмэгтэйчүүдийн эрхийн тухай нэмэлт протокол (Мапутогийн протокол) Европын Зөвлөлийн “Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, тэмцэх тухай конвенци” (Истанбулын конвенци) багтсан болно. Мөн захирамжилсан НҮБ-ын ЭЯГУХ-ны эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаархи Ерөнхий зөвлөмж No.19 (1992), Конвенцийн Зүйл –ийн дагуу улс орны хүлээх үндсэн үүргийн талаарх No. 28, НҮБ-ын баримт НҮБ-ын баримт. CEDAW/C/GR/28, (2010), эмэгтэйчүүд шүүхэд хандах хүртээмжийн талаарх No. 33, НҮБ-ын баримт. CE-DAW/C/GR/35, (2017), болон улс орнуудын талаарх ажиглалтын олон дүгнэлт, ; Бээжингийн тунхаглал ба Үйл ажиллагааны төлөвлөгөө зэрэг олон улсын бодлогын баримт бичгүүд; ЭЯГУХорооны шийдвэр (ж.ш. АТ Унгарын эсрэг (2005), Фатима Йлдрим Австрийн эсрэг (2007); Вердито Филиппиний эсрэг (2010), СВП Болгарын эсрэг (2011); РПБ Филиппиний эсрэг (2011) зэрэг хэргүүд); Америк тивийн хүний эрхийн комисс, Америк тивийн шүүх Европын хүний эрхийн шүүх, (ж.ш. Мария да Пена Маяа Фернандес Бразилийн эсрэг(2000); Валеск-Родригес Хондурасын (1988), Раквел Марти де Межа Перугийн эсрэг 1996); Айдин Туркийн эсрэг (1997); Опуз Туркийн эсрэг (2009) зэрэг хэргүүд.

<sup>174</sup> Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, шийтгэх, устгах тухай Америк тивийн конвенцийн удиртгал; Protocol to the Африкийн Хүний эрхийн дүрмийн Африкийн эмэгтэйчүүдийн эрхийн тухай нэмэлт протоколын удиртгал; Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, тэмцэх тухай конвенцийн удиртгал.

<sup>175</sup> ЭЯГБХУК--ийн хороо, Ерөнхий зөвлөмж 19, догол догол 1.

<sup>176</sup> ЭЯГБХУК--ийн хороо, Ерөнхий зөвлөмж 19, догол догол 6.

<sup>177</sup> ЭЯГБХУК, Зүйл 1(e), (f).

<sup>178</sup> ЭЯГБХУК--ийн хороо, Ерөнхий зөвлөмж 35, UN. Doc. CEDAW/C/CG/35, догол 21.

<sup>179</sup> ЭЯГБХУК--ийн хороо, Ерөнхий зөвлөмж 35, догол s 21 and 22.

<sup>180</sup> ЭЯГБХУК--ийн хороо, Ерөнхий зөвлөмж 19, догол 9; ЯГБХУК--ийн хороо, Ерөнхий зөвлөмж 35, догол 24(b).

<sup>181</sup> Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаарх Тусгай Илтгэгчийн Тайлан (Якин Эртурк), “ Хүний эрхийг Эмэгтэйчүүд, Жендэрийн асуудалд уялдуудах нь: Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл – Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг устгахад заавал мөрдөх хэм хэмжээг хэрэгсэл болгох нь”, НҮБ-ын баримт. E/CN.4/2006/61.

<sup>182</sup> Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаарх Тусгай Илтгэгчийн Тайлан (Якин Эртурк), “ Хүний эрхийг Эмэгтэйчүүд, Жендэрийн асуудалд уялдуудах нь: Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл – Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг устгахад заавал мөрдөх хэм хэмжээг хэрэгсэл болгох нь”, НҮБ-ын баримт. E/CN.4/2006/61, догол догол 19.

эсрэг жендэрт суурилсан хүчирхийллийг шийдвэрлэхэд төрийн хүлээх үүргийг хуульчилж өгсөн бөгөөд үүнд мөрдөн шалгах, сэргийлэх, хамгаалах, хохирогчид дэмжлэг үзүүлэх, гомдлыг нь барагдуулах асуудлууд тусчээ<sup>183</sup>. Доорхи дэд бүлгүүдэд энэ хэм хэмжээтэй холбоотой тусгай заалтуудыг тайлбарласан байгаа.

## 6.1 БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ХОЛБООТОЙ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ

Истанбулын конвенцийн дагуу **хүчин болон бусад харилцан зөвшөөрөлгүй бэлгийн шинжтэй үйлдлийг гэмт хэрэгт тооцох** шаардлагатай<sup>184</sup>. Хүчин болон бэлгийн бусад хэлбэрийн хүчирхийллийг ёс суртахуун, нийгмийн хүлээлт, нэр хүнд, гэр бүл, нийгмийн эсрэг гэмт хэрэг гэж үзэхээс илүүтэйгээр хувь **хүний биеийн эрх чөлөө, бэлгийн бие даасан байдалд халдсан гэмт хэрэг**<sup>185</sup> гэж үзнэ. Хүчирхийллийн хохирогч эмэгтэйчүүд, охидын үзэж туулсан зүйлс, хэрэгцээнд нийцсэн жендэр нейтрал эсхүл жендэрийн хувьд тусгайлсан хууль эрх зүйн хүрээ шаардлагатай бөгөөд эрэгтэйчүүд, хөвгүүдийн эсрэг үйлдсэн жендэрт суурилсан болон бэлгийн хүчирхийллийг ч шалгах боломжтой байх ёстой<sup>186</sup>.

Бэлгийн хүчирхийллийг хувь хүний бэлгийн бие даасан байдалд халдсан хэрэг гэж хүлээн зөвшөөрсний<sup>187</sup> улмаас **бэлгийн харьцаанд зөвшөөрөлгүй орсныг бэлгийн хүчирхийлэл, хүчин гэж тодорхойлох** хандлага олон улсын хүний эрхийн хэм хэмжээнд гараад байна<sup>188</sup>. Цаашлаад, хувь хүн өөрийн хүрээлэн буй орчин, нөхцөл байдлыг үнэлж, сайн дурын сонголтоо хийсний үндсэн дээр эсэхээ шийднэ<sup>189</sup>. Бэлгийн тодорхой үйлдэл хийхээр сайн дураар шийдэж байгаа учраас ямар ч цагт болих, татгалзах эрхтэй<sup>190</sup>. Хоёр талын аль аль нь албадлагаас ангид байж, зөвшөөрөх эсэхээ шийдэх бүрэн боломжтой тохиолдолд л бэлгийн харилцааг чөлөөтэй, сайн дурын үндсэн дээр харилцан зөвшөөрсөн гэж үзэх хандлага олон улсын эрүүгийн хуульд газар авч байна<sup>191</sup>. Тийм учраас, бэлгийн хүчирхийллийг тогтоохдоо албадлагын чанартай өргөн хүрээний нөхцөл байдлыг оруулах хэрэгтэй бөгөөд тэдгээр нөхцөлд тохирохгүй тохиолдолд хохирогч тал үнэхээр бэлгийн хавьталд орохыг зөвшөөрсөн эсэхийг хариуцагч тал хэрхэн баталгаажуулснаа нотлох шаардлагыг тавьж байна<sup>192</sup>. НҮБ-ын Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн тухай хууль эрх зүйн гарын авлагад “Бодит байдал дээр (зөвхөн) зөвшөөрөлгүй бэлгийн хүчирхийлэл нь

<sup>183</sup> Европын Зөвлөлийн “Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, тэмцэх тухай конвенци” (Истанбулын конвенци) үз. “Айдсаас ангид-Хүчирхийллээс ангид”, 2014, р 3, холбоос: <https://edoc.soe.int/en/violence-against-women/6138-leaflet-safe-from-fear-istanbul-convention.html>

<sup>184</sup> Истанбулын конвенци, Зүйл 36 (1). Сайд нарын хороогоор 2002 оны 4 сарын 30-нд баталсан Европын зөвлөлийн сайд нарын хорооны зөвлөмж R (2002) 5, Тайлбар Меморандум H/Inf (2004), догол догол 35. Үүгээр хохирогч эсэргүүцэл үзүүлээгүй ч бүх зөвшөөрөөгүй хүчингийн хэргийг шийтгэхийг шаарджээ. Мөн хүчинг, гэрлэлтийн хүчинг ч гэмт хэрэгт тооцохыг уриалсан РАСЕ шийдвэр 1691 (2009), догол догол 5.2.1, үз.”

<sup>185</sup> ЭЯГБХУК-ийн хороо, Ерөнхий зөвлөмж 35, догол догол 33; Вердито Филиппиний эсрэг, CEDAW Communication 18/2008, НҮБ-ын баримт CEDAW/C/46/D/18/2008 (2010), догол 8.9(b)(ii); НҮБ-ын эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг эрх зүйн гарын авлага.; 2012, р 24; холбоос: [www.unwomen.org/en/digital-library/publications/2012/12/handbook-for-legislation-on-violence-against-women](http://www.unwomen.org/en/digital-library/publications/2012/12/handbook-for-legislation-on-violence-against-women).

<sup>186</sup> Истанбулын конвенци, 50(2) зүйл; ЭЯГБХУК-ны Ерөнхий зөвлөмж 35, догол 38 (b) хуудас 12, <http://www.unwomen.org/en/digital-library/publications/2012/12/handbook-for-legislation-on-violence-against-women>.

<sup>187</sup> Бээжингийн тунхаглал ба Үйл ажиллагааны төлөвлөгөө, Эмэгтэйчүүдийн талаарх Дэлхийн IV чуулганы тайлан, НҮБ-ын баримтA/CONF.177/20/Add.1 (1995), догол 96; М.С. Болгарын эсрэг (2003) ECHR 651, догол s 164-166.

<sup>188</sup> М.С. Болгарын эсрэг (2003) ECHR 651, 164-166. Олон улсын эрүүгийн шүүх, “Гэмт хэргийн элементүүд” (2011), хүчин хүн төрөлхөтний эсрэг гэмт хэрэг болох тухай элемент 1, 2 Зүйл 7(1)(g)-1, хуудас 8, олон улсын болон олон улсын бус зэвсэгтмөргөлдөөнд хүчин дайны гэмт хэрэг болох тухай Зүйл8(2)(b)(xxii)-1 (хуудас 28) Зүйл 8(2)(e)(vi)-1, хуудас 36-37 Вердито Филиппиний эсрэг, догол 8.9(b)(ii); Истанбулын конвенци, зүйл 36; ЭЯГБХУК-ийн хороо, Ерөнхий зөвлөмж 35, догол 33.

<sup>189</sup> М.С. Болгарын эсрэг (2003) ECHR 651, 163. Вердито Филиппиний эсрэг, CEDAW Communication 18/2008, НҮБ-ын баримт CEDAW/C/46/D/18/2008 (2010), догол 8.9(b)(ii). Истанбулын конвенци, зүйл 36 (2); ЭЯГБХУК-ийн хороо, Ерөнхий зөвлөмж 35, догол 33; НҮБ-ын эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг эрх зүйн гарын авлага, 2012, хуудас 24.

<sup>190</sup> Үүнийг тухайлбал Английн дээд шүүх зэрэг үндэсний шүүхээр баталана [2013] EWHC 945 (Admin), холбоос: [www.judiciary.gov.uk/wp-content/uploads/JCO/Documents/Judgments/f-v-dpp-judgment.pdf](http://www.judiciary.gov.uk/wp-content/uploads/JCO/Documents/Judgments/f-v-dpp-judgment.pdf); Supreme Court of California, 29 Cal. 4th 756, 60 P.3d 183, 128 Cal. Rptr. 2d 783, 2003 Cal, холбоос: <http://caselaw.findlaw.com/ca-supreme-court/1330844.html>.

<sup>191</sup> Олон улсын эрүүгийн шүүх, “Гэмт хэргийн элементүүд” (2011), хүчин хүн төрөлхөтний эсрэг гэмт хэрэг болох тухай элемент 1, 2 Зүйл 7(1)(g)-1, х 8 олон улсын болон олон улсын бус зэвсэгтмөргөлдөөнд хүчин дайны гэмт хэрэг болох тухай Зүйл 8(2)(b)(xxii)-1 (х 28) зүйл 8(2)(e)(vi)-1, х 36-37. Олон улсын эрүүгийн шүүх, “Нотлох дүрэм журам”, НҮБ-ын баримтICC-ASP/1/3 (2002), Дүрэм 70(a), (b), (c).

<sup>192</sup> Vertido v The Philippines, CEDAW Communication 18/2008, НҮБ-ын баримтCEDAW/C/46/D/18/2008 (2010), догол 8.9(b)(ii).193 UN Handbook for Legislation on Violence against Women, 2012, p 25.

хохилогчийг бэлгийн хавьталд орохыг зөвшөөрөөгүй гэдгээ батлах шаардлагыг тулгаж болзошгүй тул хохирогчийг сэтгэл санааны давхар дарамтад оруулах магадлалтай” гэж анхааруулсан байна<sup>193</sup>. Тухайн үед хүч, эсвэл хүчирхийлэл ашиглаж бэлгийн хавьталд орсон эсэхэд анхаарал хандуулахгүйгээр “албадлагын шинжтэй нөхцөл байдлын” өргөн хүрээний жагсаалтыг гаргахыг зөвлөсөн байна<sup>194</sup>.

Олон улсын хүний эрхийн хууль, хэм хэмжээний дагуу **хүчинг** хүний үтрээ, шулуун гэдэс, эсвэл аманд нөгөө хүн зөвшөөрөлгүй өөрийн эрхтэн болон бусад эд зүйлсийг шургуулах үйлдэл гэж **өргөн хүрээнд тодорхойлсон**<sup>195</sup> байна. Түүнчлэн, жендэрт суурилсан, эсвэл бэлгийн хүчирхийллийн шинжтэй гэмт үйлдэл нь “хэр ноцтой гэдгээс шалтгаалан шүүхээр үр дүнтэй, тэнцвэртэй, аль нэг талыг баримтлахгүйгээр шийдэгдэнэ” гэсэн баталгааг гаргадаг<sup>196</sup> хууль эрх зүйн тогтолцоо гаргах хэрэгтэй. Хууль эрх зүйн тогтолцоо нь хүндрүүлэх нөхцөл байдлыг харгалзаж үзэх ёстой бөгөөд үүнд хохирогчийн нас, үйлдэгч болон хохирогчийн өмнөх харилцаа, хүч, хүчирхийлэл хэрэглэсэн эсэх, олон хүн бүлэглэж хүчирхийлсэн эсэх, энэ халдлагаас болж хохирогчид биеийн болон сэтгэл зүйн ноцтой хохирол учирсан эсэхийг харгалзана<sup>197</sup>. Цаашлаад, төр “ялангуяа гэр бүлийн харилцаанд гарч буй хүчирхийллийг гэмт хэрэгт тооцож яллах хэрэгтэй (үүнийг “гэрлэлтийн хүчирхийлэл” гэдэг ба хариуцагч ба хохирогчийн “хоорондын харилцаанаас үл хамааран” гэх заалтыг оруулах, эсвэл “хуулийн дагуу бэлгийн хүчирхийллийг шийтгэхэд гэрлэлт болон бусад харилцаа хамаарахгүй” гэсэн заалтыг оруулж болно)”<sup>198</sup> гэж тэмдэглэсэн байна.

Хэрэв цагдаа, эсвэл хууль сахиулах байгууллагын ажилтан ажлын болон ажлын бус цагийн алинд<sup>199</sup> нь ч байсан хүчирхийлэл үйлдсэн бол энэ үйлдлийг **бусдыг тамлан зовоосон нэг хэлбэр**<sup>200</sup> гэж үзнэ. Төрийн алба хаагчид гэдэгт “төрийг төлөөлдөг, төрийн өмнөөс үүрэг гүйцэтгэдэг, төртэй холбоотой, түүний шууд хяналт, үүргийн дагуу ажилладаг, эсвэл хуулиар тийм үүрэг хүлээсэн”<sup>201</sup> хууль сахиулах байгууллага, хорих, цэргийн байгууллага болон бусад ажилтнуудыг хэлнэ<sup>202</sup>. Эрүүдэн шүүх болон бусад зүй бусаар харьцах үйлдлээс сэргийлэх, шалгах, ял оноох, шийтгэх үүргийг төр хүлээдэг бөгөөд хэрэв энэ үүргээ биелүүлэхгүй байгаа нь “байж болшгүй үйлдлийг хүлээн зөвшөөрч, өөгшүүлж байгаа хэрэг”<sup>203</sup> болох юм. Төрөөс ангид байгууллагаас хохирогчийг эрүүдэн шүүсэн тохиолдол гарсныг таслан зогсоож, шийтгэж, хохирогчийн асуудлыг шийдвэрлэж чадаагүй тохиолдолд төр тэдгээр байгууллагуудад ийм үйлдлийг ямар нэгэн шийтгэлгүй үргэлжлүүлэх боломжийг олгоод зогсохгүй, төрөөс энэ асуудлыг тоохгүй, шийдвэрлэхгүй байх нь ийм хэрэг гарах нөхцөлийг бүрдүүлж, нэг ёсны талд нь ажиллаж байгаа хэрэг юм. Энэхүү зарчмын дагуу хэрэв төр “жендэрт суурилсан хүчирхийллийн хэлбэр болох хүчин, гэр бүлийн хүчирхийлэл, эмэгтэйчүүдийн бэлгэ эрхтнийг зэрэмдэглэх зан үйл, хил дамнуулан хүний наймаа хийх гэх мэт гэмт хэргээс хохирогчдыг хамгаалж, сэргийлж” чадахгүй байвал буруутгагдах болно. Түүнчлэн, хүчиндүүлсэн хохирогч үр хөндүүлэх үйлчилгээ авч чадахгүй байх нь эрүүдэн шүүх болон бусад төрлийн хүнийг зовоосон гэмт үйлдлийг хориглосон зарчмыг зөрчиж<sup>204</sup> байгаа хэрэг юм.

<sup>193</sup> НҮБ-ын эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн эрх зүйн гарын авлага, 2012, хуудас 25

<sup>194</sup> НҮБ-ын эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн эрх зүйн гарын авлага, 2012, хуудас 25

<sup>195</sup> Истанбулын конвенци, 36 зүйл.

<sup>196</sup> Истанбулын конвенци, 45(1) зүйл.

<sup>197</sup> НҮБ-ын эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн эрх зүйн гарын авлага, 2012, хуудас 24.

<sup>198</sup> НҮБ-ын эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн эрх зүйн гарын авлага, 2012, хуудас 24.

<sup>199</sup> Айдин Туркийн эсрэг (1997) ECHR 75, догол s 74-76, 86. Мигуэл Кастро, Кастро Шорон Перугийн эсрэг, Амеик тивийн хүний эрхийн шүүх, 2006оны 11 сарын 25 November, догол 310-312.

<sup>200</sup> Тухайлбал ВЛ Швецарийн эсрэг, ЭШЭК, НҮБ-ын баримт. CAT/C/37/D/262/2005 (2007) догол 8.10; Фернандес Ортега ба бусад Мексикийн эсрэг, Америктивийн комисс (2010) догол 128; Эл-масри хуучин Югослав Македоны БНУ-ын эсрэг (39630/09), Европын шүүхийн дээд танхим (2012) догол 205-11; Раквел Марти де Межя Перугийн эсрэг, Америк тивийн хүний эрхийн хэргийн талаарх комисс 10.970, Тайлан. 5/96 (1996 оны 3 сарын 1).

<sup>201</sup> ЭШЭК Ерөнхий санал 2, НҮБ-ын баримт. CAT/C/GC/2, догол 15.

<sup>202</sup> ЭШЭК Ерөнхий санал 2, НҮБ-ын баримт. CAT/C/GC/2, догол 15.

<sup>203</sup> ЭШЭК Ерөнхий санал 2, НҮБ-ын баримт. CAT/C/GC/2, догол 15.

<sup>204</sup> Истанбулын конвенци, 7.1 зүйл.



## 6.2 ЖЕНДЭРТ СУУРИЛСАН БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЛЭЭС СЭРГИЙЛЭХ, ТЭМЦЭХЭД ХОХИРОГЧ ТӨВТЭЙ, ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ БОДЛОГО ХЭРЭГТЭЙ

**Due diligence** буюу заавал мөрдөх хэм хэмжээний дагуу эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн бүхий л хэлбэрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх өргөн хүрээний бодлогын зохицуулалтыг баталж, хэрэгжүүлэх үүрэгтэй<sup>205</sup>. Ийм бодлого нь бүх арга хэмжээний төвд хохирогчийг тавих ёстой бөгөөд хүний эрхийн үндэсний комисс, иргэний нийгмийн байгууллага гэх мэт хамааралтай бүх байгууллага, институцыг хамрах шаардлагатай<sup>206</sup>. Түүнчлэн жендэрт суурилсан хүчирхийллийн асуудлыг авч үзэх тогтолцоо нь ялгаварлан гадуурхалтыг таслан зогсооход хүргэх олон төрлийн, харилцан хамааралтай арга хэмжээ, эмэгтэйчүүдийн хүчирхийллийг даван туулсан байдал, тэдний хэрэгцээ, ялангуяа ялгаварлан гадуурхалтын олон төрлийн хэлбэрийг туулж өнгөрүүлсэн эмэгтэйчүүдийн хүсэл шаардлага юу байна гэдгийг харгалзаж үзэх шаардлагатай<sup>207</sup>. Доорх хэсгүүдэд хохирогч төвтэй, жендэрийн мэдрэмжтэй бодлогод юуг тусгах талаар тайлбарласан байгаа.

### 6.2.1 ЯЛЛАХ ҮЙЛ ЯВЦ

Олон улсын хууль, хэм хэмжээний дагуу холбогдох хууль хэрэгжүүлэгч байгууллагууд хүчирхийллийг цаг алдалгүй зүй зохистой шийдвэрлэх<sup>208</sup>, түүнээс урьдчилан сэргийлэх, нотлох баримтыг цуглуулах гэх мэт хүчирхийлээс хамгаалах бүхий л арга хэмжээг авахыг төрд үүрэг болгосон байна<sup>209</sup>. Тийм учраас, хүчирхийллийн гэмт хэргийн хохирогч болон үйлдэгч нартай ажилладаг мэргэжилтнүүдийг сургах, тусламж үйлдчилгээг зөв шат дарааллаар үзүүлэх, жендэрийн тэгш байдал, салбар хоорондын хүчирхийллийн хохирогчийг сэтгэл санааны давхар дарамтанд оруулахгүй байх тал дээр сэргийлэх арга хэмжээ авах гэх мэт өргөн хүрээний сэдвийг хамруулах хэрэгтэй<sup>210</sup>. Түүнчлэн, “хүчирхийллийн гэмт хэргийг зөвхөн хохирогчийн гомдол дээр үндэслэж шалгахаар хязгаарлахгүй, хэрэв гэмт хэрэг тухайн улсын нутаг дэвсгэр дээр үйлдэгдсэн бол гомдол гаргасан, татаж авсан эсэхээс үл хамааран мөрдөн шалгах ажлыг үргэлжлүүлж болно” гэж тэмдэглэсэн байна<sup>211</sup>. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл гарсан тохиолдолд тухайн гэмт хэргийн түвшин, ноцтой байдал зэргийг үл харгалзан цагдаа болон бусад мөрдөн шалтгалт явуулах эрхтэй байгууллага мөрдөн шалгах үйл ажиллагааг эхлүүлнэ<sup>212</sup>. Ийм мөрдөн шалгах ажиллагааг хийгээгүй цагдаа, эсвэл мөрдөн байцаагчийг өөрсдийг нь шалгадаг, учир зүйг нь тогтоох шүүхийн нээлттэй үйл явц байж байх хэрэгтэй<sup>213</sup>.

### 6.2.2 ХОХИРОГЧИЙН ХАМГААЛАЛ

Олон улсын хууль, хэм хэмжээний дагуу төр **мөрдөн шалгах болон шүүх шатны үйл ажиллагаанд хохирогчийг хамгаалах, түүний эрх, хэрэгцээ шаардлагыг хангах** бүхий л арга хэмжээг авах үүргийг хүлээнэ<sup>214</sup>. Энэ үүргийн дагуу улс орнууд хохирогчийн эрх, ашиг сонирхолыг хамгаалах зарим бодлогын шийдлийг гаргах шаардлагатай. Үүнд: хуулийн өмгөөлөл тусламжийг цаг алдалгүй, үр дүнтэй үзүүлэх; хохирогчоос ямар нэгэн төлбөр, шүүхийн хураамж зэргийг авахгүй байх<sup>215</sup>; хохирогч нарт зориулсан дэмжих үйлчилгээ, хуулийн өмгөөллийн тухайн хангалттай мэдээллийг цаг алдалгүй өгөх<sup>216</sup>; хуулийн зөвлөгөө, орчуулга, хараат бус зөвлөгөө,

<sup>205</sup> Истанбулын конвенци, 7.2 ба 7.3 зүйл.

<sup>206</sup> ЭЯГБХУК-ийн хороо, Ерөнхий зөвлөмж 35, догол 41, 43, 47, 48, 49, 50; Истанбулын конвенци, 3 зүйл

<sup>207</sup> НҮБ-ын гарын авлага, 2012, хуудас 34-36; Истанбулын конвенци, зүйл 50(1);

<sup>208</sup> ЭЯГБХУК-ийн Ерөнхий зөвлөмж, догол 38 (b).

<sup>209</sup> Истанбулын конвенци, 50(2) зүйл ; ЭЯГБХУК-ийн Ерөнхий зөвлөмж 35, догол 38 (b)

<sup>210</sup> Истанбулын конвенци, 15(1) зүйл; ЭЯГБХУК-ийн Ерөнхий зөвлөмж 35, догол 38 (b).

<sup>211</sup> Истанбулын конвенци, 55 зүйл; Опуз Туркийн эсрэг (2009) ECHR 870, догол 138-139.

<sup>212</sup> Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, эрүүгийн хэргийн шүүхийн талбарт эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг устгах талаар жишиг стратеги, практик арга хэмжээ, Ерөнхий ассамблейн шийдвэр 65/228 (2010), догол 14(b).

<sup>213</sup> Европын парламент ба зөвлөлийн чиглэл 2012/29/EU 2012 оны 10сарын 25 October, “гэмт хэргийн хохирогчийн эрх, хамгаалал, дэмжлэгийн наад захын стандарт, Зөвлөлийн үйл ажиллагааны хүрээний шийдвэр 2001/220/JHA-ийг орлох, зүйл 11.

<sup>214</sup> НҮБ-ын эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн эрх зүйн гарын авлага, 2012, хуудас 37.

<sup>215</sup> НҮБ-ын эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн эрх зүйн гарын авлага, 2012, хуудас 37; ЭЯГБХУК-ийн Ерөнхий зөвлөмж 35, догол 44.

<sup>216</sup> Истанбулын конвенци, 19.



зуучлах үйлчилгээ гэх мэт шүүхийн үйлчилгээг үнэгүй үзүүлэх<sup>217</sup> зэрэг орно. Шүүн таслах үйл явцын үед хохирогчийн эрх ашгийг хамгаалахад анхаарал тавих хэрэгтэй бөгөөд шүүх хуралд биеэр оролцох эсэх, мэдүүлэг өгөх эсэх, хэрэв биеэр очиж өгөхгүй гэвэл өөр ямар аргаар мэдүүлэг өгч болох гарцууд, өмгөөлөгчид итгэмжлэлийг өгөх<sup>218</sup> боломжтой бол аль болох хохирогчийг хариуцагчтай нүүр тулж уулзуулахгүй байхаар шүүх хурлыг зохион байгуулах<sup>219</sup>; хохирогчийн хувийн нууц, нэр хүндийг хамгаалах арга хэмжээг<sup>220</sup> авах хэрэгтэй юм. Хохирогч, гэрчийг хамгаалах асуудалд нотлох баримтыг цуглуулах, бүрдүүлэх үйл ажиллагаа бас хамрах бөгөөд мэргэжилтнүүдийг анхан шатны баримт нотолгоог цаг алдалгүй цуглуулах, хадгалах талаар болон мөрдөн шалгалт, протокол үйлдэх зэрэг асуудлаар сургалтад хамруулах<sup>221</sup>, хохирогчид эмнэлгийн туслалцаа хэрэгтэй бол шүүх эмнэлгийн дүгнэлтийг гаргуулах<sup>222</sup>, хохирогчийг заавал байлцуулахгүйгээр мөрдөн шалгах үйл ажиллагааг явуулах боломжийг бүрдүүлэх<sup>223</sup> хэрэгтэй байна. Хууль тогтоомж нь хэргийг анх мэдээлсэн үе болон шүүн таслах үйл ажиллагаа дуусгавар болох хүртэлх явцад хугацааг хойшлуулах, сунжруулах гэх мэт сөрөг үйл ажиллагааг шүүхээс хэрэгжүүлэх боломжийг хаасан байх хэрэгтэй<sup>224</sup>.

Олон улсын хууль, хэм хэмжээний дагуу улс орнууд ялгаварлан гадуурхалд хүргэж болзошгүй бүх дүрэм, журмыг хүчингүй болгох үүрэгтэй бөгөөд үүнд “эмэгтэйчүүдийг хүчирхийллээс хамгаалахын тулд тэдний эрх чөлөөг хязгаарласан журам, “онгон” байхад чиглэсэн заншил, соёл, шашин, эсвэл “нэр төрөө хамгаалах эрх”, хохирогч/хариуцагчийн гэр бүлийн уучлал хүсэх уламжлал, үүнээс үүдээд хохирогч хариуцагч нар хоорондоо гэрлэх, чулуугаар шидэх, зодох, амь насыг нь бүрэлгэх гэх мэт хамгийн хүнд шийтгэлийг голдуу эмэгтэйчүүдэд ногдуулсаар байгаа гэх мэт эрэгтэйчүүдэд давуу талыг олгосон хуулийн заалт, эсвэл гэм хорыг бууруулах хүчин зүйлс, эмэгтэй өмгөөлөгч нарын хүчин чармайлтыг үгүйсгэсэн уламжлалт жендэрт суурилсан хүчирхийллийн уламжлалтыг харгалзаж үзээгүй шүүхийн үйл ажиллагаа зэргийг авч үзнэ”<sup>225</sup>. Хуулийн тогтолцооноос авч хаях ялгаварлан гадуурхалтын шинжтэй үйл ажиллагаанд дараах орно: хүчин болон бусад бэлгийн хүчирхийллийн хэргийг бүхий л шатанд шийдвэрлэхэд шүүх хурлын хараат бус, шударга байдалд нөлөөлж болох жендэрийн хэвшмэл ойлголт, буруу хандлага<sup>226</sup>; шүүхээс нэмэлт баримт нотолгоогүйгээр зөвхөн дан ганц хохирогчийн мэдүүлэг дээр үндэслэж шийдвэр гаргаж болохгүй талаар шүүх бүрэлдэхүүн болон төлөөлөгч нарт анхааруулах нь эмэгтэйчүүдийг гомдол гаргагч, гэрч, өмгөөлөгчийнх нь хувьд гадуурхсан, бэлгийн хүчирхийллийн тохиолдолд гэм бурууг нотлох, эсвэл шийдвэр гаргуулахын тулд эрэгтэйчүүдээс илүү их нотолгоо, баримт бүрдүүлэх шаардлагыг үүсгэх<sup>227</sup>; иргэний болон эрүүгийн шүүн таслах ажиллагаанд хохирогчийн бэлгийн амьдарлын түүх, зан үйлийн талаарх баримтыг зайлшгүй шаардлагатай<sup>228</sup>, хэрэгцээтэй үед л ашиглах боломжтой бөгөөд зөвхөн хаалттай хуралдаанд сонсоно<sup>229</sup>; эмнэл зүйн хувьд найдваргүй, анагаахын ёс зүйг зөрчиж байгаа “онгоныг шалгах” арга нь үндсээрээ ялгаварлан гадуурхсан шинжтэй, хохирогчид бие болон сэтгэл санааны ихээхэн зовлон, өвдөлтийг мэдрүүлсэн арга хэмжээ бөгөөд энэ арга хэмжээг хүчээр, хохирогчийн үтрээнд шургуулах замаар хийсэн бол энэ асуудал нь бэлгийн хүчирхийлэл буюу хүчин, тамлан зовоосон, эсвэл хүнлэг бус, харгис хандлага гэж тооцогдох магадлалтай.<sup>230</sup>

<sup>217</sup> НҮБ-ын эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн эрх зүйн гарын авлага, 2012, хуудас 38; Истанбулын конвенци, 56 (d), (e), (h), 57.

<sup>218</sup> НҮБ-ын эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн эрх зүйн гарын авлага, 2012, хуудас 39; Истанбулын конвенци 56 (i).

<sup>219</sup> НҮБ-ын эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн эрх зүйн гарын авлага, 2012, хуудас 39; Истанбулын конвенци, 56 (g).

<sup>220</sup> НҮБ-ын эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн эрх зүйн гарын авлага, 2012, хуудас 39; Истанбулын конвенци, 56 (f), ЭЯГБХУК-ийн хороо, Ерөнхий зөвлөмж 33, догол 18(f).

<sup>221</sup> ЭЯГБХУК-ийн хороо, Ерөнхий зөвлөмж 33, НҮБ-ын баримт CEDAW/C/GC/33 (2015), догол 51(i).

<sup>222</sup> ХЭДКГ, “Истанбулын протокол: Эрүүдэн шүүх, харгис, хүнлэг бус, хүний нэр төрийг доромжлон харьцах, шийтгэхийг үр дүнтэй мөрдөж, баримтжуулах тухай гарын авлага”, НҮБ-ын тухай гарын авлага. HR/P/PT/8Rev.1 (2004), догол 270, ICJ, “Жендэрт суурилсан хүчирхийллийг эмэгтэйчүүд шүүхээр шийдвэрлүүлэх нь, хэрэгжүүлэгч нарт удирдамж.”, 2016.

<sup>223</sup> НҮБ-ын эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн эрх зүйн гарын авлага, 2012, хуудас 40.

<sup>224</sup> НҮБ-ын эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн эрх зүйн гарын авлага, 2012, хуудас 41; ЯГБХУК-ийн хороо, Ерөнхий зөвлөмж 35, догол 33.

<sup>225</sup> ЭЯГБХУК-ийн хороо, Ерөнхий зөвлөмж 35 догол 31b

<sup>226</sup> Вердито Филиппиний эсрэг Vertido v The Philippines, CEDAW Communication 18/2008, НҮБ-ын баримт CE-DAW/c/46/d/18/2008(2010) догол 8.9 b

<sup>227</sup> НҮБ-ын эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн эрх зүйн гарын авлага, 2012, хуудас 41-42

<sup>228</sup> НҮБ-ын эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн эрх зүйн гарын авлага, 2012, хуудас 42

<sup>229</sup> ОУЭШ-ийн Нотолгооны дүрэм журам, Дүрэм 70d

<sup>230</sup> Хараат бус шүүхийн шинжээчдийн бүлэг (2015)33 J Forensic Leg Med 121-124, хуудас 5

Түүнчлэн улс орнууд хүчирхийллийн гэмт хэргийг мэдээлэхэд саад учруулж болох хууль эрх зүйн заалтуудыг авч хаях хэрэгтэй бөгөөд үүнд “хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн хууль эрх зүйн чадамжийг үгүйсгэсэн, тэдний шүүхэд мэдүүлэг өгөх боломжийг хязгаарласан асран хамгаалагчийн тухай хууль; “аюулгүй байдлыг хангах зорилгоор саатуулах” үйл ажиллагаа явуулдгаа зогсоох;<sup>231</sup> эмэгтэйчүүд, түүний дотор гэрийн үйлчлэгч цагаач эмэгтэйчүүд энэ төрлийн гэмт хэргийг мэдээлэх боломжийг хязгаарласан цагаачлалын тухай хууль, гэр бүлийн хүчирхийллийн тохиолдолд аль аль талыг баривчлан саатуулдаг хууль, мөн хариуцагчийг гэм буруугүй гэж тогтоосон үед гэрчийг шийтгэдэг хууль гэх мэт олон нөхцөлүүдийг дурьдсан байна<sup>232</sup>. Энэ асуудал нь олон төрлийн, харилцан хамааралтай ялгаварлан гадуурхалтыг туулж буй эмэгтэйчүүдэд нэн чухал бөгөөд тэд “хууль сахиулах байгууллагуудын ажилтнууд болон бусад хүмүүст гутаан доромжлуулах, баривчлагдах, хөөгдөх, шийтгүүлэхээс, эсвэл өөр ямар нэгэн хэлбэрийн хүчирхийлэлд өртөхөөс айдаг учраас” хүчирхийллийн гэмт хэргийг бараг мэдээлдэггүй юм.<sup>233</sup> Улс орнууд ийм төрлийн асуудлууд гарахаас сэргийлэх арга хэмжээг авах ёстой бөгөөд “шударга шүүхийг эрэлхийлсэн эмэгтэйг нэмэлтээр гадуурхаж, нэр хүндийг нь гутаахаас илүүтэйгээр тэдэнд итгэх, хүлээн зөвшөөрөх соёл, нийгмийн орчинг бүрдүүлэх” хэрэгтэй.<sup>234</sup>

### 6.2.3 ХҮЧИРХИЙЛЛИЙН ХОХИРОГЧДОД ҮЗҮҮЛЭХ ДЭМЖИХ ҮЙЛЧИЛГЭЭ

Олон улсын хууль, хэм хэмжээний дагуу **хүчирхийллийн хохирогчдод өргөх хүрээний, нэгдсэн дэмжих үйлчилгээг** үзүүлэх үүрэгтэй<sup>235</sup>. Үүнд ийм үйлчилгээнд хүн бүр, ялангуяа хотын болон хөдөөний гэж ялгалгүйгээр тэгш хамруулах боломжийг бий болгох, хүртээмжийг стандартын хамгийн доод хэмжээ хүртэл нэмэгдүүлэх хэрэгтэй байна. Хэм хэмжээний хүчирхийллийн хохирогч, гэрч нарт зохих шатны үйлчилгээ, тусламжийн төвтэй холбож өгөх утсаар зөвлөгөө өгөх төв 24 цагийн байнгын үйл ажиллагааг үнэ төлбөргүй явуулах ёстой; 10,000 иргэн тутамд нэг хамгаалах байр ажиллах ёстой бөгөөд хохирогчийг түр хугацаанд байрлуулах сэтгэл зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлэх, цаашид байнга амьдрах газар олоход нь туслах зэрэг үйлчилгээг үзүүлэх хэрэгтэй; 50,000 эмэгтэй тутамд нэг ухуулга нөлөөлөл, зөвлөгөө өгөх төв байх хэрэгтэй бөгөөд тэдгээр төвүүд нь хохирогч нарт зориулсан идэвхтэй дэмжлэг, хууль зүйн зөвлөгөө туслалцаа, хохирогчдод цаашид амьдралаа үргэлжлүүлэхэд шаардлагатай тусламж зөвлөгөө, шилжин суурьшигч, хүн наймаалах гэмт хэргийн хохирогч гэх мэт эмэгтэйчүүдийн тусгайлсан бүлгүүдэд тусламж дэмжлэг үзүүлдэг; 200,000 эмэгтэй тутамд хүчингийн дараах тусламж дэмжлэг үзүүлэх нэг төвийг ажиллуулах хэрэгтэй<sup>236</sup>. Мөн хүчингийн гэмт хэргийн хохирогч нарт чиглэсэн өргөн хүрээний нэгдсэн үйлчилгээг үзүүлэх үр дүнтэй арга хэмжээг цаг алдалгүй авах хэрэгтэй байна. Үүнд жирэмсний сорил, жирэмслэхээс яаралтай сэргийлэх эм, аюулгүй үр хөндөх үйлчилгээг хуулийн хүрээнд үзүүлэх, бэлгийн замаар дамжих халдварыг эмчлэх, гэмтэл бэртлийг эмчлэх, гэмт халдлагын дараах зөвлөгөө, сэтгэл зүйн тусламж зэргийг хохирогч нарт үзүүлэх бөгөөд зардал төсвийг нь улсаас гаргах хэрэгтэй<sup>237</sup>. Ийм үйлчилгээ тусламжийг авахын тулд хохирогч заавал гэмт үйлдлийг цагдаад мэдээлсэн байх шаардлагагүй юм<sup>238</sup>.

### 6.2.4 ГОМДОЛ БАРАГДУУЛАХ

Олон улсын хууль, хэм хэмжээнд тодорхой заасны дагуу төр жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогч эмэгтэйчүүд, охидын гомдлыг барагдуулах үйл ажиллагаа явуулах үүрэгтэй бөгөөд энэ ажил нь цаг хугацаандаа, хүнд учирсан хохирлын түвшинд нийцэхүйц, тохиромжтой байх ёстой<sup>239</sup>. Гомдол барагдуулах гэдэгт олон үйл ажиллагаа хамаарах бөгөөд үүнд “хохирогчийн

<sup>231</sup> ЭЯГБХУК-ийн хороо, Ерөнхий зөвлөмж 35, догол 31

<sup>232</sup> НҮБ-ын эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн эрх зүйн гарын авлага, 2012, хуудас 42

<sup>233</sup> ЭЯГБХУК-ийн хороо, Ерөнхий зөвлөмж 338 догол 10

<sup>234</sup> ЭЯГБХУК-ийн хороо, Ерөнхий зөвлөмж 3533, догол 35(d).

<sup>235</sup> НҮБ-ын эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн эрх зүйн гарын авлага, 2012, хуудас 29.

<sup>236</sup> НҮБ-ын эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн эрх зүйн гарын авлага, 2012, хуудас 29.

<sup>237</sup> НҮБ-ын эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн эрх зүйн гарын авлага, 2012, хуудас 30; Истанбулын конвенци, 25.

<sup>238</sup> НҮБ-ын эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн эрх зүйн гарын авлага, 2012, хуудас 30; Истанбулын конвенци, 25.

<sup>239</sup> Олон улсын хүний эрхийн хууль, Олон улсын хүмүүнлэгийн тухай хуулийг ноцтой зөрчсөний төлөө хохирогчийн эрхийг сэргээх үндсэн зарчим, Ерөнхий Ассамблейн шийдвэр 60/147, 2005 оны 12 сарын 16. ЭЯГБХУК-ийн хороо, Ерөнхий зөвлөмж 35, догол s 46-47; Истанбулын конвенци 5.2. тусгай илтгэгчийн тайлан, НҮБ-ийн баримт. А/ HRC/14/22, (2010), догол 12-85.

бэлгийн, нөхөн үржихүйн, сэтгэл санаанд учирсан хохирол бүрэн эдгэх, хохиролгүй болсон гэж үзэх хүртэлх бүх арга хэмжээ, тухайлбал санхүүгийн тусламжаас гадна, хуулийн, нийгмийн, эрүүл мэндийн тусламж, дахин ийм явдал гаргахгүй байх итгэл үнэмшил бий болгох” зэрэг орно<sup>240</sup>. Улс орнууд “гомдол барагдуулах тусгайлсан санг бүрдүүлэх, эсвэл хууль эрх зүйн одоогийн тогтолцоонд жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэхэд зориулсан төсвийг суулгах”; “шүүхээр гомдлоо шийдвэрлүүлэх сонголт хийсэн хохирогч, гэрч нарыг ялгалгүй гомдлыг барагдуулах механизмыг бүрдүүлэх”, “хохирогчийн хүсэл, эрх ашиг, шийдвэр, хамгаалалт, нэр төрийг” нэн тэргүүнд тавих замаар “хүчирхийлэл гарахад нөлөөлсөн хувь хүний, институцийн болон бүтцийн асуудлууд, далд шалтгаан нь болсон ялгаварлан гадуурхалт, тэгш бус байдлыг шийдвэрлэхэд туслах, нөлөөлөх механизмыг дэмжих”<sup>241</sup> хэрэгтэй байна.

## 6.2.5 УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖИЛ

Олон улсын хууль, хэм хэмжээний дагуу төр нь “эмэгтэйчүүдийг дорд үзсэн, эсвэл эрэгтэй эмэгтэй хүмүүсийн гүйцэтгэх үүргийн талаар буруу ташаа ойлголтыг түгээсэн үзэл бодол, уламжлал, ёс заншлыг өөрчлөх зорилгоор эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн зан үйлийн талаарх нийгэм, соёлын хүлээлтийг өөрчлөх ажлыг хийх” үүрэгтэй юм<sup>242</sup>. Мөн төрөөс “хүчирхийллийн олон хэлбэрийг таниулах чиглэлээр олон нийтийн мэдлэг хандлагыг нэмэгдүүлэх”, “хүчирхийллийн гэмт үйлдлээс сэргийлэх ямар үйлчилгээ, арга хэмжээ байгаа талаар мэдээлэл түгээх” зорилготой кампанит ажлыг явуулах үүрэг хүлээнэ<sup>243</sup>. Төрөөс “насны онцлогт тохирсон, нотолгоонд суурилсан, шинжлэх ухааны үндэстэй өргөн хүрээний бэлгийн боловсролын хичээлийг эрэгтэй эмэгтэй хүүхдүүдэд олгох” хэрэгтэй<sup>244</sup> бөгөөд “ерөнхий боловсролын сургуулийн бага ангиас эхлээд бүх түвшний боловсролын хөтөлбөрийг хүний эрхэд суурилсан хандлагатай болгож, жендэрийн тэгш байдлын агуулгыг суулгах” замаар<sup>245</sup> “жендэрийн хэвшмэл, хуучирсан ойлголтуудыг үгүй хийж, жендэрийн тэгш байдал, үл ялгаварлан гадуурхах үзлийг төлөвшүүлэхэд” анхаарах хэрэгтэй<sup>246</sup>. Эцэст нь, хэвлэл мэдээллийн хэрэгслээр “эмэгтэйчүүдийн хүний эрхийн төлөө тэмцэгчид гэх мэт эмэгтэйчүүдийн тодорхой бүлэг, эмэгтэйчүүдийг нийтээр нь дорд үзсэн, гадуурхсан хандлагыг гаргахгүй” байхад дэмжлэг үзүүлэх хэрэгтэй байна<sup>247</sup>.

<sup>240</sup> ЭЯГБХУК-ийн хороо, Ерөнхий зөвлөмж 35, догол 44.

<sup>241</sup> ЭЯГБХУК-ийн хороо, Ерөнхий зөвлөмж 35, догол 47. Истанбулын конвенци, 30.2 ба 30.3 зүйл.

<sup>242</sup> Истанбулын конвенци, 12(1) зүйл. ЯГБХУК, 5 (а).

<sup>243</sup> Истанбулын конвенци, 13(2) зүйл

<sup>244</sup> ЭЯГБХУК-ийн хороо, Ерөнхий зөвлөмж 35, догол 35 (а).

<sup>245</sup> ЭЯГБХУК-ийн хороо, Ерөнхий зөвлөмж 35 догол 35 (b).

<sup>246</sup> ЭЯГБХУК-ийн хороо, Ерөнхий зөвлөмж 35, догол 35 (а).

<sup>247</sup> ЭЯГБХУК-ийн хороо, Ерөнхий зөвлөмж 35, догол 37.

## 7. ЗӨВЛӨМЖ

**(Холбогдох) Европын улс орнуудад:**

**Хууль тогтоомжтой холбоотой:**

1. Европын Зөвлөлийн Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, тэмцэх тухай конвенци (Истанбулын конвенци)-ийг цаг алдалгүй баталж, бүрэн хэрэгжүүлэх;
2. Үндэсний хууль тогтоомжид Олон улсын эрүүгийн шүүхээс гаргасан хүчингийн тодорхойлолт, ЭЯБХУТК-ийн хорооны Ерөнхий зөвлөмж 35, Вертидо Филиппины эсрэг хэрэгт ЭЯБХУТК-ийн хорооны өгсөн тайлбар, Истанбулын конвенци, Европын хүний эрхийн шүүхийн хууль эрх зүйн баримт бичиг гэх мэт олон улсын хүний эрхийн хэм хэмжээний дагуу хүчинг тодорхойлох томъёоллыг оруулах. Энэ томъёолол нь харилцан зөвшөөрөлгүй гэсэн утга санааг илтгэх;
3. Хүчин болон бэлгийн бусад хүчирхийлэл нь ёс суртахуун, нийгмийн хэв журам, нэр хүнд, эсвэл гэр бүл, нийгмийн эсрэг үйлдсэн гэмт хэрэг гэхээс илүү хүний бие, бэлгийн бие даасан байдлын эсрэг үйлдэгдсэн гэмт хэрэг гэж үзэх;
4. Хариуцагч ба хохирогчийн “хоорондын харилцаанаас үл хамааран” гэх заалтыг оруулах, эсвэл “хуулийн дагуу бэлгийн хүчирхийллийг шийтгэхэд гэрлэлт болон бусад харилцаа хамаарахгүй” гэсэн заалтыг оруулах замаар гэрлэсэн хүмүүсийн дундах хүчин, бэлгийн хүчирхийллийг гэмт хэрэгт тооцох<sup>248</sup>;
5. Албан тушаал, эрх мэдлээ урвуулан ашиглаж үйлдсэн хүчинг яллах хэрэгтэй бөгөөд үүнд хохирогчийг хамгаалах асуудлыг шийдвэрлэх.

**Бодлого, тэдгээрийн хэрэгжилттэй холбоотой:**

1. Шүүн таслах ажиллагааны түргэн шуурхай, үр дүнтэй байдлыг нэмэгдүүлж, анх цагдаад мэдэгдсэн, шүүхээр шийдвэрлүүлэх хүртэлх цаг хугацааг богиносгох;
2. Мөрдөн шалгах явцад хохирогчийг хамгаалах үр дүнтэй арга хэмжээг авч, хууль зүйн үнэгүй зөвлөгөө, сэтгэлзүйн зөвлөгөө, шүүх танхимд хамт байх, шүүх хуралд очихдоо хариуцагчтай нүүр тулан уулзахгүй байх арга хэмжээ, мэдүүлгийг нь бичлэг болгож хадгалах, шүүх хуралд хохирогчийн бэлгийн амьдралын мэдээллийг дэлгэхгүй байх гэх мэт арга хэмжээ орж байна;
3. Бэлгийн хүчирхийллээс сэргийлэх, олж тогтоох хүрээнд хохирогч, эсвэл үйлдэгчтэй ажиллах арга, тусламж үйлчилгээний зөв дараалал, жендэрийн тэгш байдал, салбар хоорондын ялгаварлан гадуурхалт, хохирогчийг сэтгэл санааны давхар дарамтад оруулахаас сэргийлэх үүднээс тэдний эрх, хэрэгцээг хангах гэх мэт чиглэлээр сургалтыг байнга явуулж, анхны тусламж үзүүлдэг мэргэжилтнүүдийг (өрхийн эмч гэх мэт эмнэлгийн ажилтнууд) бэлгийн болон гэр бүлийн хүчирхийллийн шинж тэмдгүүдийг таних талаар сургалтад хамруулах;
4. Сургуулийн сурагчид болон оюутнуудад насных нь онцлогт тохирсон, жендэрийн мэдрэмжтэй, нотлогоонд суурилсан, аль нэг талыг баримтлаагүй бэлгийн боловсролын хичээлийг заавал оруулах хэрэгтэй бөгөөд харилцан зөвшөөрөл, биеийн болон бэлгийн

<sup>248</sup> НҮБ-ын эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн эрх зүйн гарын авлага, 2012, хуудас 24.

өгүүлэмж, биеийн өгүүлэмжийн эрх гэх мэт сэдвийг хамруулах;

5. Бэлгийн хохирогчдыг дэмжих үйлчилгээг улс даяар байгуулах, цагдаад мэдэгдээгүй хохирогч ч үйлчилгээ авах боломжийг бүрдүүлэх хангалттай санхүүжилтийг тогтвортой хуваарилах;
6. Жендэрийн хуучирсан ойлголтоос үүдэх хор хохирол, бэлгийн хүчирхийллийн талаарх буруу ойлголт зэргийг устгах чиглэлээр эрэгтэй, эмэгтэй, бүх хүйсийн хүмүүсийн нийгмийн болон соёлын хандлагыг өөрчлөх ажлыг хийх.